

Гарчиг

Орчуулгын үг	3
Өмнөх үг	4
Гүйцэтгэлийн хураангуй	6
Удиртгал	10
ОҮИТБС: Гарал үүсэл ба зорилго	10
ОҮИТБС-ын Зарчмууд	12
ОҮИТБС-ын Шалгуурууд	13
ОҮИТБС-ын Олон улсын зөвлөх бүлэг	13
Санал зөвлөмжүүдийн хураангуй	16
Хэсэг 1:	
Баталгаажуулалт	17
Баталгаажуулалтын зорилго	18
Баталгаажуулалтын үйл явц	19
Баталгаажуулалтыг хэн хийх ёстойг шийдэх нь	23
Баталгаажуулалтын тайлан	24
Хэсэг 2:	
ОҮИТБС-ыг хэрэгжүүлэх хөшүүрэг	26
Нөөц баялаг ихтэй орнуудын засгийн газруудын хүртэх үр шим	26
Нутгийн ард иргэд, иргэний нийгмийнхний хүртэх үр шим	28
Компаниуд ба хөрөнгө оруулагчдын хүртэх үр шим	29
Дэлхий нийтийн эрчим хүчний аюулгүй байдлын үр шим	30
Хэсэг 3:	
ОҮИТБС-ыг хэрэгжүүлэхэд тулгарах сорилтууд	31
ОҮИТБС ба уул уурхайн салбар	31
ОҮИТБС ба бусад хөтөлбөрүүд	32

ОҮИТБС-ыг бүсийн болон орон нутгийн түвшинд нэвтрүүлэх нь	33
ОҮИТБС ба шинээр хөгжиж буй эдийн засагтай улс орнууд	33

Хэсэг 4:

ОҮИТБС-д чиглэсэн цаашдын зохицуулалтууд	35
Улс орнууд санаачилгыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх нь	36
ОҮИТБС-ыг олон улсын түвшинд удирдах нь	38
ОҮИТБС-ын санхүүжилт	44

Хавсралт

А Баталгаажуулалтын удирдамж	46
Б Баталгаажуулагчийн Ажлын даалгавар	71
В ОҮИТБС-ын Удирдах зөвлөлийн Ажлын даалгавар	75
Г ОУЗБ-ийн хуралдаан бүрт оролцогчид	79

Орчуулгын үг

Байгалийн асар их баялагтай улс орнууд харилцан адилгүй хөгжиж ирснийг түүх бэлхнээ гэрчилнэ. Газрын нөөц баялгаа зүй зохистой ашиглаж өндөр хөгжилд хүрсэн улс орон цөөнгүй бий. Тухайлбал, Норвеги, Канад, Арабын орнуудын хөгжлийн гайхамшигтай амжилт үүний нэг жишээ юм. Гэтэл үүний хажуугаар нөөц баялаг нь цөөн тооны эрх мэдэлтний баяжих хэрэгсэл болж ард олон нь ядууралд автсан, үүнээсээ болж нийгэм нь зөрчил мөргөлдөөнд тулсан улс орон ч олон байна. Ийм харамсмаар байдалд хүрэхгүй байх хамгийн гол хүчин зүйл бол нөөц баялгийн салбарын зохистой удирдлага, түүний ил тод байдлыг дээд зэргээр хангах явдал юм.

Монгол Улсын хувьд уул уурхайн салбар үсрэнгүй хөгжиж, улс оронд маань ололт амжилт, хөгжил дэвшилийг авчраасай хэмээн хэн хүнгүй хүсэн хүлээж байна. Нэн ялангуяа газрын нөөц баялгаас олох орлого нь түүний жинхэнэ эзэн болох иргэдийн аж амьдралыг сайжруулах, нэгэнт шавхагдах нөөцийг боловсрол, эрүүл мэнд, дэд бүтэц зэрэг ирээдүйн үсрэнгүй хөгжлийн үндэс болгоход зориулах шаардлагатай байгаа юм. Энэ бол улс орон байгалийн баялгаа ашигласныхаа төлөө зохих хэмжээний хувия хүртэж, тэр хувь хэмжээгээ үр ашигтай зарцуулах тухай асуудал юм.


Төр, засаг болон компаниуд авсан орлого, төлсөн татвараа нийтэд ил тод мэдээлж, түүнийг нь иргэд хянах боломжтой байх тохиолдолд л үр ашгийн тухай яриа бодит үнэн болох юм. Нэг үгээр хэлбэл төлсөн төлбөр, авсан орлого тэнцэх ёстой. Ийм энгийн бөгөөд чухал асуудлыг шийдвэрлэхийн тулд Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга бий болжээ. Монгол Улс олон улсын энэхүү санаачилгад нэгдэхээ 2006 оны нэгдүгээр сард албан ёсоор илэрхийлсэн билээ. Эдүгээ энэ санал санаачилгыг ажил хэрэг болгох, компаниуд төлбөрөө бодитоор нийтэлж, төр засаг тэрхүү орлогоо тайлагнах ажлыг шуурхай зохион байгуулах шаардлагатай байна.

Бид энэ ажлыг эхлүүлэхэд тус нэмэр болох үүднээс Олборлох салбарын ил тод байдлын санаачилгыг олон улсын түвшинд хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилготой ажилласан Олон улсын зөвлөх бүлгийн тайланг монгол хэлнээ хөрвүүлэн Та бүхэнд толилуулж байна. Өмнө нь Нээлттэй Нийгэм Форумаас «Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын сурвалж бичиг» нэртэй аргазүйн гарын авлагыг нийтэлсэн билээ. Сурвалж бичиг болон энэхүү тайлан нь уг санаачилгыг хэрэгжүүлэх үүрэгтэй төр, засгийн албан тушаалтнууд, мөн уул уурхайн компаниудын удирдлагад тодорхой удирдамж болохын зэрэгцээ санаачилгын ирээдүйн талаарх төсөөлөл өгч хэлэлцүүлэг өрнүүлнэ гэдэгт итгэж байна.

Тайланг монгол хэлнээ бэлтгэн нийтлэхэд оролцсон орчуулагч, редактор нарт талархал илэрхийлье.

П. Эрдэнэжаргал
Нээлттэй Нийгэм Форумын Гүйцэтгэх захирал

Өмнөх үг



Их Британий Ерөнхий сайд Тони Блэйр, Норвегийн Ерөнхий сайд Жэнс Столтенберг


Газрын тос, байгалийн хий, эрдэс баялгаар баян орнуудад 3.5 тэрбум гаруй хүмүүс амьдарч байна. Байгалийн эдгээр баялаг ядуу дорой хүмүүсийн амьдралыг сайжруулах асар их боломжийг олгож байдаг. Гэвч энд тодорхой эрсдлүүд бий. Эдгээр нөөц баялгийн удирдлага тааруу, ил тод байдал хангатгүйгээс ядуурал, мөргөлдөөн, авилгад хүргэж болно. Гэхдээ заавал ийм байх албагүй бөгөөд үүнийг Их Британи, Норвеги улсуудын туршлага харуулж байна.

Ийм ч учраас “Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга” (ОҮИТБС)-ыг 2002 онд эхлүүлсэн юм. Энэхүү санаачилга нь компаниуд, засгийн газрууд, иргэний нийгмийнхэн, хөрөнгө оруулагчдын хамтарч ажиллах шинэ стандартыг тогтоож байна. ОҮИТБС-аас олборлох үйлдвэрлэлийн компаниудын төлж буй төлбөр, засгийн газруудын хүлээн авч буй орлогын аль алиныг ил тод байлгахыг шаардсанаараа нөөц баялгийг сайн удирдах илүү магадлалтай болгож байгаа юм.

Сүүлийн дөрвөн жилд энэ чиглэлд мэдэгдэхүйц ахиц дэвшилд хүрч чадлаа. Анх дөрөвхөн улсад энэ санаа туршигдаж байсан бол өнөөдөр ОҮИТБС-ыг Перугаас Монгол хүртэл, Нигериэс Азerbайжан хүртэл дэлхийн бөмбөрцгийн эргэн тойронд буй 20 гаруй улс хэрэгжүүлж байна.

Хийх зүйл ч их байна. ОҮИТБС-ын цаашдын зам мөрийг тавьж буй Олон улсын зөвлөх бүлгийн энэхүү тайланг бид талархан хүлээн авч байна. Энд дэвшүүлсэн санал зөвлөмжүүд ОҮИТБС-ыг үг ярианаас үйл хэрэг болгон хувиргаж, олон улсын засаглалын нэгэн шинэ стандартыг бий болгох болно.

Улс орнууд хэлж амласан зүйлсээ хийж байгаа эсэхийг шалгах арга замыг ОҮИТБС-д нэвтрүүлэх ёстой хэмээн тус бүлгээс гаргасан санал зөвлөмжтэй бид бүрэн санал нэг байна. Энэхүү тайланда санал болгосон арга нь засгийн газрууд, компаниудад зориулсан ОҮИТБС-ын дэлхий нийтийн стандартыг бий болгох болно. Эдгээр стандартуудыг амьдралд хэрэгжүүлэхэд чиглэгдсэн хучин чармайлтуудыг олон улсын хамтын нийгэмлэгийн зүгээс дэмжих ёстой.



Тус тайланда санаачилгыг хэрэгжүүлэхэд цаашид тулгарах зарим сорилтуудыг ч тэмдэглэж байна. ОУИТБС цаашид жинхэнэ дэлхий нийтийг хамарсан санаачилга болохын хэрээр шинээр төрөн гарч буй зах зээлийн эдийн засагтай орнуудыг уг санаачилгын иж бүрэн, идэвхтэй оролцогчид болгох нь онцгой чухал. Дэлхий дахины хэмжээнд авч үзвэл хайгуул, үйлдвэрлэлийн ажилд Бразил, Орос, Энэтхэг, Хятадын компаниуд улам идэвхтэй оролцож байна. Иймд ОУИТБС-д тэдний дэмжлэг амин чухал юм.

ОУИТБС-ын хүч чадал нь түүний олон талт байдалд оршино. Олборлох салбарын ил тод байдлын төлөө ажиллах үүрэг амлалт авсан засгийн газрууд, компаниуд, хөрөнгө оруулагчид, ТББ-ууд энэхүү санаачилгыг дэвжин дэлгэрэхэд тусалж, байгалийн баялаг нөөцтэй улс орнуудын ард түмнүүд баян чинээлэг болоход түлхэц үзүүлнэ гэдэгт бид эргэлзэхгүй байна.

Тони Блэйр

Женс Столтенберг

2006 оны 9 дугээр сар

Гүйцэтгэлийн хураангуй

Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга (ОҮИТБС) анх үүссэнээс хойш дөрвөн жилийн хугацаанд нэгэн урт замыг туулжээ. Одоогоор дэлхий дээрх байгалийн баялаг нөөц ихтэй 53 улсын талаас илүү нь ОҮИТБС-ыг хэрэгжүүлэх амлалт үүрэг авсан буюу нэг хэсэг нь хэрэгжүүлэх арга замдаа шуудран ороод явж байна. Сонирхогч бүх талуудын оруулах хувь нэмрийн ач холбогдлыг хүлээн зөвшөөрөх замаар ОҮИТБС нь газрын тос, байгалийн хий, уул уурхайн салбарт ил тод байдлыг хангах нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн стандарт болж байгаа нь зүй ёсны хэрэг юм.

Сайн дурын эхлэлийн хувьд ОҮИТБС урт хугацаанд амжилт олж, дэлхий нийтийн стандарт болон хүлээн зөвшөөрөгднө гэдэг нь эргэлзээгүй бөгөөд цаашид олон улсад итгэмжлэгдэх, түүнийг урагшлуулан хөгжүүлэх удирдлага зохион байгуулалтын тодорхой бүтэцтэй болох, түүнийг дэмжигчид энэ санаачилгыг хэрэгжүүлснийхээ ашиг тусыг бусаддаа тайлбарлаж ойлгуулах чадвартай болох шаардлагатай байна. Тус Олон улсын зөвлөх бүлэг (ОУЗБ) дараахь асуултуудыг хөндөн авч үзэхээр 2005 оны 7 дугаар сард байгуулагдсан билээ:

- Улс орнууд ОҮИТБС-ыг хэрэгжүүлэхээр хэлж амласан зүйлсээ хийж гүйцэтгэж байгаа гэдгийг бид хэрхэн үнэлж дүгнэх вэ?
- ОҮИТБС-ын зүгээс түүнд оролцогч талуудын хүсэл сонирхолыг хэрхэн илүү сайн ойлгож, харилцан холбож болох вэ?
- ОҮИТБС зорилгодоо амжилттай хүрэхэд удирдлага, зохион байгуулалтын ямар зохицуулалтуудыг хийх шаардлагатай вэ?

ОУЗБ-ээс дээрх асуултууд болон тус бүлгийн яриа хэлэлцүүлгийн үеэр гарсан тулгамдсан гол асуудлуудад хариулт өгч шийдэх үүднээс 10 үндсэн санал зөвлөмжийг томъёолж байна.

Уг санал зөвлөмжүүдийг дөрвөн ангилалд хуваана:

- ОҮИТБС-ын баталгаажуулалт
- ОҮИТБС-ыг хэрэгжүүлэх хөшүүргүүд
- ОҮИТБС-д цаашид тулгарах сорилтууд
- ОҮИТБС-ын цаашдын зохицуулалтууд

Баталгаажуулалт

Улс орнууд болон компаниуд ОҮИТБС-ыг хэрэгжүүлэхдээ ямар ахиц дэвшил гаргаж байгааг баталгаажуулж чаддаг байх нь амин чухал юм. Иймд улс орнууд хэрэгжүүлэх ажиллагаагаа хэрхэн баталгаажуулж болохыг харуулах үүднээс ОУЗБ-ээс ОҮИТБС-ын Баталгаажуулалтын удирдамж (Хавсралт А) гаргаад байна.

ОҮИТБС-ыг хэрэгжүүлэгч улс орнуудыг Нэр дэвшигч болон Дагаж мөрдөгч гэсэн хоёр ангилалд хуваахаар ОУЗБ-ийнхэн тохирсон:

Нэр дэвшигч орнууд нь ОҮИТБС-ыг хэрэгжүүлэх үүрэг амлалт авсан, энэ талаар иргэний нийгэм ба компаниутайгаа хамтран ажилладаг, хэрэгжилтийг удирдан явуулах хүнээ томилсон, үйл ажиллагааны төлөвлөгөөгөө гаргасан орнууд юм.

Дагаж мөрдөгч орнууд ОҮИТБС-ыг бүрэн хэрэгжүүлж байгаа орнууд юм. Тэдний хувьд ОҮИТБС-ын тайлангаа ОҮИТБС-ын Зарчмууд, Шалгууруудад бүрэн нийцүүлэн хэвлэн нийтэлж, тараасан байна.

Баталгаажуулагчид аливаа улс орон Нэр дэвшигч эсвэл Дагаж мөрдөгч орон эсэх, эсвэл хэрэгжүүлэлттэй холбоотой ямар нэг ноцтой асуудал байгаа эсэх тухай ерөнхий үнэлгээ бүхий тайлан гаргана. Мөн Нэр дэвшигч оронд зориулсан тайландаа тухайн улсад гарч буй ахиц дэвшлийн үнэлгээг оруулах ёстай. Тайлангуудыг оролцогч олон талуудын бүлэг, тухайн засгийн газар, ОҮИТБС-ын Удирдах зөвлөлөөр хэлэлцэж хүлээн зөвшөөрсний үндсэн дээр хэвлэн нийтэлнэ. Дагаж мөрдөгч орны хувьд баталгаажуулалтыг 2 жил тутамд хийнэ, харин Нэр дэвшигч орон шаардлагатай тохиолдолд илүү олон давтамжтайгаар баталгаажуулалт хийж болно.

Баталгаажуулалтыг үнэлгээ хийлгэх тухайн орны оролцогч олон талуудын бүлгээс сонгосон Баталгаажуулагчаар хийлгэх бөгөөд ингэхдээ Олон улсын ОҮИТБС-ын Нарийн бичгийн даргын газар, ОҮИТБС-ын Удирдах зөвлөлөөс урьдчилан баталсан зохих байгууллага, хувь хүмүүсийн жагсаалтаас сонгоно. Баталгаажуулалтын зардлыг түүнийг хийлгэж байгаа улс хариуцна.

Хөшүүргүүд

ОҮИТБС нь хурсэн ололт амжилттай үргэлжлүүлэн бататгах үүднээс ОҮИТБС-ын боломжит хэрэгжүүлэгчид, дэмжигчид, түүний дотор үйлдвэрлэгч орны засгийн газрууд, компаниуд, шинээр хөгжиж буй эдийн засагтай орнууд, олон улсын байгууллагууд, хөрөнгө оруулагчид, дэмжигч орнуудын засгийн газрууд зэрэг бүхий л бүлгүүдэд хандаж ОҮИТБС-ын ашиг тусын талаар тодорхой, итгэл төрүүлэхүйц байдлаар мэдээлж байх шаардлагатай байна. Ашиг тусын зарим нь ОҮИТБС-аас шууд урган гардаг бол нөгөө хэсэг нь ил тод, хариуцлагатай байдал дээшилсний үр дүнд шууд бусаар хүртэх үр шимүүд байна.

Цаашлаад ОҮИТБС-ын зүгээс түүний хөшүүргүүдийн талаар, ялангуяа хөгжлийн үр дүн, бизнесийн орчин, эрчим хүчний хангамжийн аюулгүй байдал зэрэг үр өгөөжийг үнэлэх замаар нотлох баримтын бааз сууриа улам бүр сайжруулах чиглэлээр ажиллах шаардлагатай гэдгийг ОУЗБ санал болгож байна.

Цаашид тулгарах сорилтууд

ОУЗБ-ийн яриа хэлэлцүүлгүүдийн үеэр ОҮИТБС цаашид урагшлан хөгжихэд тохиолдож болзошгүй бодлогын зарим нэг гол асуудлууд гарч ирсэн юм. ОУЗБ-ээс эдгээр асуудлуудын талаар тодорхой дүгнэлт гаргах боломжийг цаг хугацаа бидэнд олгосонгүй. Гэхдээ шинээр байгуулагдах Удирдах зөвлөлийн хүрээнд эдгээр асуудлуудыг авч хэлэлцэх тухай санал зөвлөмжийг энэхүү Тайланд оруулсан байгаа.

- **ОҮИТБС ба уул уурхай**

Уул уурхай зонхилдог орнуудад ОҮИТБС-ыг хэрэгжүүлэхэд нөлөөлдөг хүчин зүйлс нь голдуу газрын тос эсвэл байгалийн хийн олборлох үйлдвэрлэл явуулдаг орнуудтай харьцуулахад нилээд өөр байдаг. Эдгээр хүчин зүйлсэд компаниудын үйл ажиллагааны арга барил, тухайн салбарын цар хүрээ, эдийн засгийн үр нөлөө, уул уурхайн салбарын үйл ажиллагаа явуулдаг нийгмийн орчин нөхцөл зэргийг оруулдаг. Иймээс ОҮИТБС-аас уул уурхайн салбарын онцлог шаардлагад илүү их анхаарал хандуулахыг ОУЗБ зөвлөмж болгож байна.

- **ОҮИТБС-ыг бүсийн болон орон нутгийн түвшинд хэрэгжүүлэх нь**

Зарим оронд үндэсний хэмжээнд хийгдэж байгаа гүйлгээнүүдээс гадна бүсийн болон орон нутгийн түвшинд явагдаж буй орлогын урсгал нилээд их байдаг бөгөөд энэ нь эдгээр орнуудад ОҮИТБС-ыг хэрэгжүүлэх онцлог чанарыг агуулж байж болох юм. Иймээс ОҮИТБС энэхүү нарийн түвэгтэй асуудлыг цаашид анхаарч авч үзэхийг ОУЗБ санал болгоод байна.

- **ОҮИТБС ба бусад хөтөлбөрүүд**

Бусад холбогдох санаачлагуудтай уялдаа холбоотой байх нь алс хэтдээ ОҮИТБС-д тустай байх талтай. Гэхдээ ОҮИТБС-тай уялдаа холбоотой гэж үзэж болох олон янзын үйл явц, байгууллагууд байдаг. ОҮИТБС-аас аль хөтөлбөрүүдтэй хамтран ажиллахаа шийдэхдээ ийнхүү тогтоосон илүү ойр дотно холбоо нь ОҮИТБС-ыг олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн хэм хэмжээ болох явдлыг хэрхэн дэмжих вэ гэдгийг харгалзахаас гадна нөөц хөрөнгийн үр дагаварыг нь тооцож үзэх шаардлагатай болно.

- **Шинээр хөгжиж буй эдийн засагтай улс орнууд**

Бразил, Орос, Энэтхэг, Хятад зэрэг шинээр хөгжиж буй эдийн засагтай улс орнуудад байгалийн баялгийн эрэлт хэрэгцээ хурдацтайгаар өсч байна. Эдгээр орнуудаас төрөн гарсан компаниуд дэлхийн бөмбөрцгийн эргэн тойронд улам идэвхтэй эрэл хайгуул хийдэг болоод байна. Эдгээр шинээр төрсөн эдийн засагтай орнууд, тэдний компаниудыг татан оролцуулах нь ОҮИТБС-ын нэг чухал тэргүүлэх чиглэл болохыг ОУЗБ санал болгож байна.

Цаашид хийх зохицуулалтууд

ОУЗБ-ээс ОҮИТБС-ыг хэрэгжүүлэхэд цаашид хийх зохицуулалтуудыг улс орны болон олон улсын түвшинд авч үзэхдээ ОҮИТБС-ыг хэрэгжүүлэх гол хариуцлагыг оролцогч засгийн газрууд өөрсдөө үргэлжлүүлэн үүрнэ гэсэн зарчмыг дахин нотоллоо. ОҮИТБС-ыг хэрэгжүүлэхийг хүссэн орнуудад олон улсын хамтын нийгэмлэгээс дэмжлэг тусlamж үзүүлэх ёстой.

Хэрэгжүүлэгч улсуудад зөвлөгөө, санхүүгийн дэмжлэг үзүүлэх, хуримтлуулсан туршлага, сургамжуудаа солилцоход зориулсан олон улсын бүтэц шаардлагатай байгаа нь хүлээн зөвлөөрөгдсөн. Гэхдээ ийм бүтэц нь ОҮИТБС-ыг “тогтсон гол үзэл санаа болгох”, түүний зарчим, шалгууруудыг ирэх 3-5 жилийн дотор олборлох үйлдвэрлэлийн бүхий л холбогдох салбарт үйл ажиллагаа явуулахад хэвийн хэм хэмжээ болгох гэсэн эцсийн зорилгод чиглүүлсэн цомхон бүтэц байх ёстой.

ОҮИТБС-ын ерөнхий хөгжил, стратегийн чиглэл, итгэл хүлээх чадварыг төдийгүй нийтэд сурталчлах ажиллагаа, нөлөөллийн асуудал хариуцсан Удирдах зөвлөл байгуулж ажиллахыг ОУЗБ-аас санал болгосон. Удирдах зөвлөлөөс эдгээр асуудлын талаарх санал зөвлөмж гаргаж хоёр жил тутамд зохиогдох ОҮИТБС-ын бага хурлаар хэлэлцүүлэх бөгөөд цомхон ОҮИТБС-ын Нарийн бичгийн дарга нарын газрын тусламжтайгаар ажиллана. Удирдах зөвлөлийн гишүүнчлэл нь ОҮИТБС-ын оролцогч олон талтай байх онцлогыг тусгасан байх ёстой.

ОҮИТБС-ыг хэрэгжүүлэхэд төрөл бүрийн зардлууд гарна. Хэрэгжүүлэгч орны засгийн газар, тэнд ажиллаж байгаа компаниуд, иргэний нийгмийн байгууллагууд тус бүр л хэрэгжилтийн зарим зардлуудыг даах болно. Гэхдээ олон улсын хамтын нийгэмлэгээс хоёр талт тусламжийн хүрээнд болон Дэлхийн Банкнаас захиран зарцуулдаг олон хандивлагч бүхий итгэлцлийн сангаар дамжуулан дэмжлэг үзүүлнэ гэж үзэж болно. Баталгаажуулалтын ажиллагаа төдийгүй Удирдах зөвлөл, Нарийн бичгийн дарга нарын газарт хүртэл зардал гарна. ОУЗБ-ийн зүгээс санхүүжилтийн талаар баттай санал зөвлөмж гаргаж чадаагүй боловч аливаа санхүүжилтийн зохицуулалт хийхдээ ОҮИТБС-ын оролцогчдын олон талт чанарыг тусгасан байх ёстой гэдгийг цохон тэмдэглэсэн билээ.

Дүгнэлт

ОҮИТБС-ын эхний үе шатууд амжилттай явагдсан бөгөөд одоо улам олон үйлдвэрлэгч орнууд, компаниуд төдийгүй дэмжигч орнууд ОҮИТБС-д нэгдэн орж байна. Тус санаачилгын эцсийн зорилго бол ОҮИТБС-ын Зарчмууд ба Шалгууруудыг газрын тос, байгалийн хий, уул уурхайн салбар дахь ил тод байдлын олон улсад хүлээн зөвлөөрөгдсөн стандарт болгох явдал юм. Энэхүү тайланд орсон санал зөвлөмжүүд нь уг зорилго биелэхэд нөлөөлөх гол хүчин зүйлсийг онцлон авч үзэхийг зорьсон болно.

Үдиртгал

ОҮИТБС: Гарал үүсэл ба зорилго

“Нэгэнтээ Эдийн засагч (*The Economist*) сэтгүүлд ОҮИТБС-ыг дэмжигчдийг сониуч эвсэл хэмээн дүрслэн бичсэн байдаг. Бид үнэхээр тийм хүмүүс гэж би боддог. Гэхдээ энэ бол бид бүхний асар их бахархаж явах ёстой тийм нэгэн сониуч эвсэл юм. Бид нарийн ширийн зүйлс дээр өөр өөр үзэл бодолтой байж болох хэдий ч, ил тод байдлыг дээшлүүлэх гэсэн нийтлэг нэг алсын хараатай байдаг, энэ нь “Юу төлснөө нийтэл, юу авснаа ч нийтэл” гэсэн маш энгийн зарчимд тулгуурладаг.”

Хилари Бенн, Олон улсын хөгжил хариуцсан сайд, Их Британи

Олборлох Үйлдвэрлэлийн Ил Тод Байдлын Саначилга (ОҮИТБС)-ыг 2002 онд Йохансбургт болсон Тогтвортой хөгжлийн асуудлаарх дэлхийн дээд хэмжээний уулзалтаас анх гаргасан юм. Энэ нь засгийн газрууд, иргэний нийгмийн байгууллагууд, хөрөнгө оруулагчдын дэлхий нийтийн эвслийг байгалийн баялгаас олж буй орлогын төлөлт ба хүлээн авалтыг илүү ил тод болгох зорилгын дор нэгтгэдэг.

Газрын тос, байгалийн хий, эрдэс баялгаас олж буй орлого нь ийм нөөц баялаг ихтэй орнуудын эдийн засгийг өөрчилж, ядуурлыг бууруулахын зэрэгцээ нийт хүн амын амьжиргааны түвшнийг дээшлүүлж чаддаг. Аливаа улс ОҮИТБС-ыг хэрэгжүүлнэ гэдэг бол тухайн улсын засгийн газар байгалийн баялгийн орлогынхаа ил тод байдлыг дээшлүүлэх үүрэг амлалт авна, харин иргэд нь засгийн газраа уг орлогыг хэрхэн ашиглаж байгааг хянаж хариуцлага тооцох үүрэг хүлээнэ гэсэн үг. Тэд ингэснээрээ дэлхий нийтийн эдийн засагт үр нөлөөтэй үйл ажиллагаа явуулж чадах тогтвортой, баян чинээлэг нийгмийг хамтран бий болгоход тусладаг.

Азербайжан, Нигери, Гана, Перу зэрэг нөөц баялаг ихтэй 20 гаруй орон ОҮИТБС-ыг хэрэгжүүлэх үүрэг амлалт аваад байна. Одоогоор Азербайжан, Нигери хоёр олборлох үйлдвэрлэлийн орлого, төлбөрүүдээ тогтмол тайлангаж байна. Мөн өөр гурван улс (Гвиней, Габон, Кыргызстан) ОҮИТБС-ын тайлангаа гаргаад байна. Бусад улсууд энэ үйл явцыг эхлүүлэх шатандаа яваа бөгөөд хараахан эхлүүлж амжаагүй олон улс байна.

Шигтгээ 1: Нөөц баялаг ихтэй орон гэж юу вэ?

Олон Улсын Валютын Сан (ОУВС)-гаас 2004 оны 12 сард гаргасан **Нөөц баялгийн орлогын ил тод байдлын тухай заавар-т** нүүрстөрөгч болон эрдэс баялгийн нөөцөөр баян орнуудыг дараахь шалгуур үзүүлэлтийн үндсэн дээр тодорхойлж гаргасан байдаг. Үүнд: (i) нүүрстөрөгч болон эрдэс баялгийн орлогын улсын тесөвт эзлэх дундаж хувь хэмжээ нь сүүлийн гурван жилийн турш нийт төсвийн орлогын дор хаяж 25 хувьтай тэнцүү байсан байх; (ii) нүүрстөрөгч болон эрдэс баялгийн экспортын орлогын дундаж хэмжээ нь сүүлийн гурван жилийн турш нийт экспортын орлогын дор хаяж 25 хувьтай тэнцүү байсан гэсэн хоёр шалгуур байдаг.

Оролцогч орнууд ОҮИТБС-ын үйл явцыг оролцогчдын олон талт хандлагын дагуу хэрэгжүүлж, өөрийн болгож, удирдан хөтөлж байна. Засгийн газрууд, газрын тос, байгалийн хий, уул уурхайн компаниуд, дотоодын иргэний нийгмийнхэн ба олон улсын төрийн бус байгууллагууд (ТББ-үүд), Дэлхийн Банк, ОУВС зэрэг олон улсын байгууллагууд, хөрөнгө оруулагчид бүгд л уг санаачилгыг үндэсний болон олон улсын түвшинд урагшуулан хөгжүүлэхийн төлөө хамтран ажиллаж байна. Эдгээр бүлгүүдийн утга төгөлдөр оролцооны үр дүнд л ОҮИТБС одоо байгаа ололт амжилтдаа хүрээд байна.

“ОҮИТБС-ыг ОУВС маш их дэмждэг. Тэдний үйл ажиллагаа нь байгалийн баялгийн орлогыг ил тодор ашиглах бидний зөвлөмжид нөхвөр, нэмэлт болж өгдөг. Энэ ажлын цаана төрийн хариуцлага, ил тод байдал илүү их байх тусам улсын төсвийн зарцуулалтын чанарыг дээшлүүлж, авилгыг багасгаж, ядуурлыг бууруулж чадна гэсэн итгэл үнэмшил оршиж байгаа юм.”

Rodriigo de Rato, ОУВС-гийн удирдах захирал

Эдгээр оролцогч талууд олон улсын дэмжлэг хүлээсээр байна. Африкийн Комисс болон 2003 онд Евианд болсон уулзалтаас хойши Их 8-ын дээд хэмжээний уулзалтуудаар уг санаачилгыг дэмжих хандлагаа нэмэгдүүлэхийг олон улсын хамтын нийгэмлэгтuriалсан. Ялангуяа Франц, Герман, Нидерланд, Норвеги, Их Британи, АНУ зэрэг улсууд хариу арга хэмжээ авч байна. Энэ дэмжлэгийг цаашид үргэлжлүүлэн өргөтгөх шаардлагатай байна. Шинээр төрөн гарсан зах зээлүүд (тухайлбал, Хятад, Орос, Энэтхэг, Бразил улсууд) болон тэдний төрийн өмчит компаниуд дэлхийн хэмжээнд улам бүр чухал тоглогчид болж байна. Тэдгээрийг татан оролцуулснаар ОҮИТБС-д цаащдын ахиц дэвшил гарах юм.

ОҮИТБС-ыг хэрэгжүүлэгч, дэмжигчдийн иж бүрэн, шинэчилсэн жагсаалтыг <http://www.eitransparency.org/section/supporters> хаягаар олж үзэж болно.

ОҮИТБС-ын Зарчмууд

ОҮИТБС-ын Зарчмуудыг 2003 оны 6 дугаар сард Лондонд болсон ОҮИТБС-ын анхдугаар бага хурлаар хэлэлцэн тохирсон юм. Улс орнууд, компаниуд, иргэний нийгмийн байгууллагууд, хөрөнгө оруулагчдын янз бүрийн бүлгүүдийн зүгээс олборлох салбар дахь төлбөр, орлогуудын ил тод байдлыг дээшлүүлэхэд чиглэсэн Зарчмуудын мэдэгдлийг зөвшөөрсөн билээ. Эдгээрийг ОҮИТБС-ын Зарчмууд гэх болсон бөгөөд уг санаачилгын тулгын чулуу юм.

ОҮИТБС-ын Зарчмууд

1. Бид, байгалийн нөөц баялгийг ухаалаг ашиглах нь тогтвортой хөгжил, ядуурлыг бууруулахад хувь нэмэр оруулдаг эдийн засгийн тогтвортой өсөлтийн нэг чухал хөшүүрэг бөгөөд хэрэв үүнийг зөв зохистой удирдахгүй бол нийгэм эдийн засгийн сөрөг үр дагаварт хүрч мэднэ гэдэг итгэл үнэмшлийг хуваалцдаг.
2. Бид, аливаа улс орон байгалийн нөөц баялгаа ард иргэдийнхээ тусын тулд ашиглах нь үндэсний хөгжлийнхэе ашиг сонирхлыг гүйцэлдүүлэх гэсэн тусгаар улсын засгийн газруудын анхаарлын төвд байдаг гэдгийг баталж байна.
3. Бид, нөөц баялгийг олборлосны ашиг тус нь олон жилийн турш хуримтлагдах орлогын урсгалаар бий болох бөгөөд энэ нь үнээс өндөр хамааралтай байх болно гэдгийг хүлээн зөвшөөрч байна.
4. Бид, засгийн газрын орлого, зарцуулалтын талаар ард иргэд ямар нэг ойлголттой байх нь тогтвортой хөгжлийн зохистой, бодитой хувилбаруудын сонголтын талаар олон нийтийн хэлэлцүүлэг явуулах, мэдээлэл өгөхөд тустай байж болохыг хүлээн зөвшөөрч байна.
5. Бид, олборлох салбарт ажиллаж буй засгийн газар ба компаниудын ил тод байхын чухлыг болон төрийн санхүүгийн удирдлага, хариуцлагатай байдлыг сайжруулах шаардлагыг онцлон тэмдэглэж байна.
6. Бид, ил тод байдлыг илүү ихээр хангах явдлыг гэрээ хэлэлцээр, хууль тогтоомжуудыг хүндэтгэн үзэх хүрээнд явагдах ёстой гэдгийг хүлээн зөвшөөрч байна.
7. Бид, санхүүгийн ил тод байдлын үр дүнд гадаад, дотоодын шууд хөрөнгө оруулалтын орчин сайжирч болохыг хүлээн зөвшөөрч байна.
8. Бид, улсын төсвийн орлого, зардлын урсгалыг зохицуулах талаар засгийн газраас бүх ард түмнийхээ өмнө хүлээсэн хариуцлагын зарчмууд болон практик үйл явцад итгэж байна.
9. Бид, нийгмийн амьдрал, бизнесийн болон засгийн газрын үйл ажиллагаанд ил тод байдал, хариуцлагын дээд зэргийн стандартуудыг дэмжин нэвтрүүлэхийн төлөө байна.
10. Бид, төлбөр болон орлогыг ил тод болгоход чиглэсэн өргөн хүрээтэй уялдаа холбоо бүхий, хэрэгжихүйц бөгөөд хэрэглэж, ашиглахад энгийн хялбар арга барил шаардлагатай гэдэгт итгэлтэй байна.
11. Бид, аливаа улс орон дахь төлбөр тооцоог ил тод болгоход тухайн оронд үйл ажиллагаагаа явуулж байгаа олборлох үйлдвэрлэлийн бүх компаниудыг хамруулах ёстой гэж үздэг.
12. Бид, аливаа шийдэл гаргахад бүх оролцогчид, түүний дотор засгийн газар, түүний агентлагууд, олборлох үйлдвэрлэлийн компаниуд, үйлчилгээний компаниуд, олон талт байгууллагууд, санхүүгийн байгууллагууд, хөрөнгө оруулагчид, төрийн бус байгууллагууд дор бүрнээ өөрийн чухал хувь нэмрийг оруулна гэдэгт итгэдэг.

ОҮИТБС-ын Шалгуурууд

ОҮИТБС-ын шалгууруудыг 2005 оны 3 дугаар сард Лондон хотноо зохион байгуулагдсан ОҮИТБС-ын хөёрдугаар бага хурлаар хэлэлцэн тогтсон юм. Оролцогч улс орнууд ОҮИТБС-ыг амжилттай хэрэгжүүлж байгаад тооцогдоход эдгээр шалгуурыг биелүүлэх, боломжтой бол бур давж биелүүлэх шаардлагатай.

ОҮИТБС-ын Шалгуурууд

1. Компаниудаас засгийн газарт төлж байгаа газрын тос, байгалийн хий, уул уурхайн холбогдолтой бүх материаллаг төлбөр (“төлбөр”) ба газрын тос, байгалийн хий, уул уурхайн компаниудаас засгийн газарт хүлээн авсан бүх материаллаг орлогын (“орлого”) талаар өргөн олон нийтэд зориулж хүртээмжтэй, ойлгомжтой, цогц байдлаар тогтмол хэвлэн нийтэлж байх.
2. Хэрэв хөндлөнгийн хяналт байхгүй бол дээрх төлбөр болон орлогыг итгэмжлэгдсэн, хараат бус хянаагчаар олон улсын аудитын стандартуудын дагуу шалгуулдаг байх.
3. Төлбөр болон орлогыг итгэмжлэгдсэн, хараат бус захирагчаар олон улсын аудитын стандартууд хэрэглэн нэгтгэн дүгнүүлж, хэрэв ямар нэг зөрүү, зөрчилтэй байдал илэрсэн бол энэ талаарх тухайн захирагчийн дүгнэлтийг хэвлэн нийтэлдэг байх.
4. Энэ аргыг бүх компаниуд, түүний дотор төрийн өмчит үйлдвэрийн газруудад хамааруулан хэрэглэдэг байх.
5. Дээрх үйл явцыг зохион байгуулах, түүнд хяналт шинжилгээ, үнэлгээ хийхэд иргэний нийгэм идэвхтэй оролцох бөгөөд олон нийтийн хэлэлцүүлэг өрнүүлэхэд хувь нэмрээ оруулдаг байх.
6. Санаачилгыг хэрэгжүүлж буй хүлээн авагч засгийн газар, шаардлагатай тохиолдолд олон улсын санхүүгийн байгууллагуудын тусламжтайгаар, дээрх бүх үйл явцад зориулан санхүүгийн хувьд тогтвортой Үйл ажиллагааны төлөвлөгөө гаргах бөгөөд энэхүү ажлын төлөвлөгөөндөө тавьж болохуйц зорилтууд, хэрэгжүүлэх хугацаа, гарч болзошгүй хүндрэл бэрхшээлийн үнэлгээ зэргийг багтаасан байх.

ОҮИТБС-ын Олон улсын зөвлөх бүлэг

ОҮИТБС-ын Олон улсын зөвлөх бүлэг (ОУЗБ) нь 2006 онд Ослод болох ОҮИТБС-ын гуравдугаар бага хуралд зориулж ОҮИТБС-ын цаашдын ирээдүйн талаар санал зөвлөмж гаргах зорилгоор 2005 оны 7 дугаар сард байгуулагдсан.

“ОҮИТБС-ын Ослогийн бага хурал нь ОҮИТБС-ын хэрэгжилтийг сайжруулж, оролцогчдын тоог нэмэгдүүлэх зорилгоор зохиогдох гэж байна. Тус бага хурлаар ОУЗБ-ийн санал зөвлөмжүүдийг хэлэлцэн баталснаар ОҮИТБС-ын хууль ёсны байдлыг нэмэгдүүлж, түүнийг улам бүр тогтвортой ажиллагаатай болгох юм. Эдгээр дэвшүүлсэн зорилтуудыг хангах үүднээс бид Ослогийн бага хурлыг ОҮИТБС-ыг дэлхий нийтийн хэм хэмжээ болгоход чиглэсэн түүхэн үйл явдал байлгахыг зорино.”

Ионас Гар Штор, Норвегийн Гадаад хэргийн сайд

Транспаренси Интернэшнл байгууллагыг үүсгэн байгуулагч Пийтр Ейген ОУЗБ-ыг даргалж ажиллалаа. Энэ бүлэгт хэд хэдэн газрын тос, байгалийн хий, уул уурхайн компаниуд, иргэний нийгмийн байгууллагууд, засгийн газрууд, хөрөнгө оруулагчдын төлөөлөгчид орсон байна.

Олон улсын зөвлөх бүлэгт оролцогчид

Засгийн газрууд: Азербайжан, Франц, Нигери, Норвег, Перу, АНУ-ын засгийн газрууд

Компаниуд: Anglo-American, BiPi, Chevron, Petrobras

Иргэний нийгэм: Нээлттэй нийгмийн хүрээлэн, Глобал Витнесс, Төв Африкийн католик шашны хамба нарын бага хурал (Камерун), Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлыг дээшлүүлэх эвсэл (Азербайжан).

Хөрөнгө оруулагчид: Эф&Си Ассет Менежмент пүүс.

ОУЗБ-ийнхэн ОҮИТБС-д тулгарч буй асуудлуудыг авч хэлэлцэх зорилгоор Лондон, Вашингтон, Абуза, Баку хотуудад тус тус хуралдлаа. Энэ хугацаанд ОУЗБ-ийн ажлын хэсгийнхэн ихээхэн ажил хийж гүйцэтгэв. Тус бүлгийн эцсийн санал зөвлөмжид дараах асуултуудыг хөндөн авч үзсэн болно:

- Улс орнууд ба компаниуд хэрэгжүүлэхээр хэлж амласан зүйлсээ хийж гүйцэтгэж байгааг бид хэрхэн үнэлж дүгнэх вэ?
- Улс орнууд, компаниуд, иргэний нийгмийнхэн, хөрөнгө оруулагчид, олон улсын байгууллагуудын хувьд ОҮИТБС-ын хэрэгжилтийг дэмжих хөшүүргүүд юу вэ?
- Яваандаа ОҮИТБС-ыг олборлох үйлдвэрлэлийн салбар дахь олон улсын тэргүүн туршлага болгохын тулд түүний олон улсын түвшинд хэрхэн удирдан зохион байгуулах вэ?

Түүнчлэн ОҮИТБС-ын цаашдын тасралтгүй ахиц дэвшлийг хангахын тулд онцлон анхаарах шаардлагатай гол тулгамдсан сорилтуудыг тэд авч хэлэлцлээ.

Энэхүү тайланд дээрх асуултуудыг дөрвөн хэсэгт хуваан авч үзэв.

- **Нэгдүгээр хэсэгт 1, 2, 3 дугаар санал зөвлөмжийг онцлон авч үзэж улс орнуудад хийсэн ажлынхаа гүйцэтгэлийг хэмжих боломж олгох үүднээс санал болгосон баталгаажуулалтын үйл явцын талаар тайлбарлав (Иж бүрэн арга зүйг Хавсралт А-д буй ОҮИТБС-ын Баталгаажуулалтын зааварт дурдсан байгаа).**
- **Хоёрдугаар хэсэгт 4 дүгээр санал зөвлөмжийг авч үзэж ОҮИТБС-ыг хэрэгжүүлэхийн ашиг тус, ач холбогдолын заримыг тодорхойлж гаргав. (Энэ хэсгийг уг тайлантай зэрэгцүүлэн гаргасан Ил тод байдал ба хөгжил, Ил тод байдал ба бизнесийн уур амьсгал, Ил тод байдал ба эрчим хүчний аюулгүй байдал гэсэн гурван нийтлэлд бүр илүү дэлгэрэнгүйгээр авч үзсэн болно.)**
- **Гуравдугаар хэсэгт 5, 6, 7, 8 дугаар санал зөвлөмжийг авч үзэж ОУЗБ-ээс цаашид анхаарах шаардлагатай хэд хэдэн тулгамдсан сорилтууд, түүний дотор бүсийн болон орон нутгийн түвшинд ажиллах, шинээр төрөн гарч байгаа болон шилжилтийн эдийн засагтай тэргүүлэх орнуудтай ажиллах, уул уурхайн салбарт ажиллах, бусад хөтөлбөрүүдтэй уялдуулан холбох зэрэг асуудлуудыг тодорхойлж гаргалаа.**
- **Дөрөвдүгээр хэсэгт 9, 10 дугаар санал зөвлөмжийг авч үзэж ОҮИТБС-ыг олон улсын түвшинд хэрхэн удирдах талаар тайлбарласны зэрэгцээ үндэсний хэмжээнд тухайн улс өөрийн арга барилыг хэрэглэх зарчмыг дахин нотоллоо. Түүнчлэн практик хэрэгжүүлэлтэд олон улсын хамтын нийгэмлэгийн зүгээс үзүүлж болох дэмжлэгүүдийг санал болгов.**

Эдгээр санал зөвлөмжүүд бүгд ОҮИТБС-ын Зарчмууд ба Шалгууруудад нийцсэн байна. ОУЗБ-ийн зүгээс бүх санал зөвлөмжүүдийн талаар эцсийн дүгнэлтэд хүрч чадаагүй бөгөөд энэхүү тайланд уг санал зөвлөмжүүдийг хэрхэн хэрэгжүүлэх, аль эсвэл ОҮИТБС-ын сайн дурын үйл явцад оролцох талаар ОУЗБ-ийн гишүүдийн төлөөлж буй засгийн газрууд, компаниуд, байгууллагуудад ямар нэг хуулийн үүрэг хариуцлага бий болгож оноох гээгүй болно. Энэхүү тайлан нь ОҮИТБС-ыг олборлох үйлдвэрлэлийн салбар дахь олон улсын тэргүүн туршлага болгохын тулд хөндөн авч үзэх шаардлагатай нэмэлт чиглэлүүдийг тодотгон гаргах замаар цаашид хийх ажлын үндэс суурийг тавьж байгаа юм.

Санал зөвлөмжүүдийн хураангуй

Санал зөвлөмж 1: ОҮИТБС бол олон оролцогч талт санаачилга юм. Түүний хэрэгжилтийг бүх оролцогч талуудын бүрэн оролцоотойгоор ОҮИТБС-ын Зарчмууд ба Шалгууруудад нийцүүлэн явуулах нөхцлийг хэрэгжүүлэгч орны засгийн газруудын зүгээс хангаж өгөх ёстой.

Санал зөвлөмж 2: Улс орнууд ОҮИТБС-ыг хэрэгжүүлэх үүрэг амлалт авсны дараа хэрэгжилтэд гарч буй ахиц дэвшлийг тогтмол баталгаажуулж байх шаардлагатай.

Санал зөвлөмж 3: ОҮИТБС-ыг хэрэгжүүлэгч оронд үйл ажиллагаа явуулж буй газрын тос, байгалийн хий, уул уурхайн компаниуд тухайн улсын баталгаажуулалтын нэг хэсэг болж үнэлгээ хийлгэх ёстой. Олон улсын түвшинд үүрэг хүлээж үйл ажиллагаа явуулж буй компаниуд өөрийгөө үнэлэх маягтыг мэдүүлж байх ёстой.

Санал зөвлөмж 4: ОҮИТБС нь түүнийг хэрэгжүүлэхийн ашиг тусыг засаглалын илүү өргөн хүрээтэй шинэчлэлийн нэг хэсэг гэдэг үүднээс нь, мөн эрчим хүчний аюулгүй байдал, бизнесийн уур амьсгал зэрэг бусад ач холбогдол талаас нь илүү тодорхой нотлон харуулах ёстой.

Санал зөвлөмж 5: ОҮИТБС нь уул уурхайн салбарын өвөрмөц онцлогт илүү их анхаарал хандуулах ёстой.

Санал зөвлөмж 6: ОҮИТБС ба түүнийг хэрэгжүүлэгч орнуудын зүгээс ил тод байдал, авилгын эсрэг ажиллагаа, хөгжлийн болон эрчим хүчний аюулгүй байдлын талаарх бусад хөтөлбөрүүдтэй хамтран ажиллах зохих боломжуудыг олж тогтоох ёстой.

Санал зөвлөмж 7: ОҮИТБС нь уг санаачилгыг бүсийн болон орон нутгийн түвшинд хэрэгжүүлэх боломжийн талаар цаашид ажиллах ёстой.

Санал зөвлөмж 8: ОҮИТБС нь шинээр хөгжиж буй эдийн засагтай улс орнуудын засгийн газруудтай ОҮИТБС-ын хэрэгжилтэд илүү сайн оролцохыг дэмжин хамтран ажиллах ёстой.

Санал зөвлөмж 9: ОҮИТБС-ыг хэрэгжүүлэхэд зориулсан дэмжлэг нь тухайн орны идэвх санаачилгад тулгуурласан, тогтвортой байхын зэрэгцээ үр дүн, түншилж ажиллахад чиглэсэн байх ёстой.

Санал зөвлөмж 10: ОҮИТБС нь тус санаачилгыг олон улсын түвшинд удирдан зохион байгуулах олон оролцогч талаас бүрдсэн Удирдах зөвлөлийг байгуулж Нарийн бичгийн дарга нарын газрын дэмжлэгтэйгээр ажиллуулах ёстой.

Хэсэг 1: Баталгаажуулалт

Санал зөвлөмж 1: ОҮИТБС бол олон оролцогч талт санаачилга юм. Түүний хэрэгжилтийг бүх оролцогч талуудын бүрэн оролцоотойгоор ОҮИТБС-ын Зарчмууд ба Шалгууруудад нийцүүлэн явуулах нөхцлийг хэрэгжүүлэгч орны засгийн газруудын зүгээс хангаж өгөх ёстой.

Санал зөвлөмж 2: Улс орнууд ОҮИТБС-ыг хэрэгжүүлэх үүрэг амлалт авсны дараа хэрэгжилтэд гарч буй ахиц дэвшлийг тогтмол баталгаажуулж байх шаардлагатай.

- ОҮИТБС-ыг хэрэгжүүлэгч бүх улс орнууд баталгаажуулалтыг байнга хийлгэдэг байх ёстой.
- Баталгаажуулалтын тайланда хэрэгжүүлэгч орнуудыг "Нэр дэвшигч" эсвэл "Дагаж мөрдөгч" орны хувьд үнэлэх болно.
- Нэр дэвшигч орнууд нь ОҮИТБС-д элсэн орсон ("элсэн орох" бүх дөрвөн үзүүлэлтийг ханган) боловч түүнийг хараахан бүрэн дүүрэн хэрэгжүүлэгүй байдаг.
- Дагаж мөрдөгч орнууд нь уг санаачилгыг бүрэн дүүрэн хэрэгжүүлсэн орнууд байна. Үүнд ОҮИТБС-ын тайлангаа гаргаж нийтийн хүртээл болгох явдал орно.
- Нэр дэвшигч орнууд баталгаажуулалт хийлгэх давтамжийг оролцогч талуудтайгаа тохирсны үндсэн дээр улсынхаа Үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгадаг. Гэхдээ, Нэр дэвшигч орнуудын хувьд баталгаажуулалтыг дор хаяж хоёр жил тутамд хийлгэх ёстой.
- Дагаж мөрдөгч орнууд баталгаажуулалтыг хоёр жил тутамд нэг удаа хийлгэхээр зохицуулна.
- Баталгаажуулагчийг тухайн орны олон оролцогч талуудын бүлгээс сонгож томилох бөгөөд зардлыг баталгаажуулалт хийлгэж байгаа улс хариуцна.
- Баталгаажуулагчийг ОҮИТБС-ын Удирдах зөвлөлөөс урьдчилан баталсан зохих мэргэжил бүхий олон улсын бүлэг, хувь хүмүүсийн жагсаалтаас сонгож авна.
- Баталгаажуулалттай холбоотой санал зөрөлдөөн гарсан тохиолдолд оролцогч талууд уг асуудлыг эхний ээлжинд олон оролцогч талуудын бүлгийн хүрээнд авч хэлэлцэж тухайн Баталгаажуулагчаар шийдвэрлүүлнэ. Хэрэв энэ шатанд асуудлыг шийдвэрлэж чадахгүй бол оролцогч талууд ОҮИТБС-ын Удирдах зөвлөлд хандана.

Санал зөвлөмж 3: ОҮИТБС-ыг хэрэгжүүлэгч оронд үйл ажиллагаа явуулж буй газрын тос, байгалийн хий, уул уурхайн компаниуд тухайн улсын баталгаажуулалтын нэг хэсэг болж үнэлгээ хийлгэх ёстой. Олон улсын түвшинд үүрэг хүлээж үйл ажиллагаа явуулдаг компаниуд өөрийгөө үнэлэх маягтыг бөглөх ёстой.

- Компанийн баталгаажуулалт нь тухайн орны баталгаажуулалтын үйл явцаас эхтэй байна.
- Компаниуд үндэсний түвшинд өөрийгөө үнэлэх маягтыг бөглөх ёстой.
- Дэлхийн хэмжээнд үүрэг хүлээсэн компаниуд олон улсын түвшний өөрийгөө үнэлэх маягтыг бөглөх ёстой.

Баталгаажуулалтын зорилго

1.0. Улс орнууд ба компаниуд ОҮИТБС-ыг хэрэгжүүлэхдээ хэр ахиц дэвшил гаргаж байгааг үнэлэн баталгаажуулж чаддаг байх нь чухал болохтой ОҮИТБС-ын бүх оролцогч талууд санал нэгтэй байсан билээ. Баталгаажуулалтыг нээлттэй, ил тод, хариуцлагатай байлгах замаар ОҮИТБС-ын Зарчмууд ба Шалгууруудад нийцүүлсэн байх ёстой гэж ОУЗБ-ийнхэн үзэж байна. Мөн баталгаажуулалтыг удирдан явуулах багц нэмэлт зарчмуудыг хэлэлцэн тохирсон байна (Шигтгээ 2-ыг үзнэ үү).

Шигтгээ 2: ОҮИТБС-ын баталгаажуулалтын зарчмууд

Баталгаажуулалтын үйл явцыг удирдан явуулах дараахь зарчмуудыг ОУЗБ хэлэлцэн тохиром:

- ОҮИТБС-ын баталгаажуулалт нь ил тод байдлын бусад бодлогуудад биш, ОҮИТБС-ыг хэрэгжүүлэхэд голлон чиглэнэ.
- Баталгаажуулалт нь улс орнуудыг хооронд нь харьцуулах боломж бүхий дэлхий нийтийн нийтлэг нэг стандартад тулгуурлана.
- Уг үйл явц нь улс орнуудын өөрсдийн санаачлага, бүтээгдэхүүн байх бөгөөд ОҮИТБС-ыг хэрэгжүүлэхэд тухайн орны давтагдашгүй байдлыг тусгана.
- Уг үйл явцад олон сонирхол бүхий талуудын оролцоог хангана.
- Уг үйл явц нь цомхон байх шаардлагатай бөгөөд хэрэгцээгүй хүнд суртал бий болгохгүй. Аль болох одоо байгаа байгууллага, чадавхид тулгуурлана.
- Уг үйл явц нь шүүмжлэлээс илүү бүтээлч санал зөвлөмжийг чухалчилна.
- Баталгаажуулагч нь ОҮИТБС-ын талаархи хангалттай мэдлэг, боловсрол, туршлагатай байх ёстой.
- Баталгаажуулагч нь үүргээ үр нөлөөтэй гүйцэтгэх хангалттай чадавхитай байх ёстой.
- Гарсан ахиц дэвшлээс гадна үнэмлэхүй ололт амжилтын үнэлгээ өгнө.

Баталгаажуулалт бол санхүүгийн аудит биш юм. Баталгаажуулагчийн ажил үүрэг бол улс орнууд ба компаниудаас хийхээр амласан зүйлээ гүйцэтгэж байгаа эсэхийг шалгах явдал юм. Баталгаажуулагч нь санхүүгийн аудит хийхийг чухалчлан эрмэлзэх ёсгүй.

1.1. Баталгаажуулалт хоёр гол зорилготой байна гэж ОУЗБ-ийнхэн үзэж байна:

- ОҮИТБС-ыг хэрэгжүүлж байгаа боловч хараахан бүрэн дүүрэн хэрэгжүүлж амжаагүй байгаа улс орнуудын хувьд (Нэр дэвшигч орнууд - дор үзнэ үү) баталгаажуулалт нь хэрэгжилтийн явцыг хэмжих зорилготой.
- ОҮИТБС-ыг бүрэн дүүрэн хэрэгжүүлж байгаа улс орнуудын хувьд (Дагаж мөрдөгч орнууд- дор үзнэ үү) баталгаажуулалт нь тухайн улс орон ОҮИТБС-ын Зарчмууд ба Шалгууруудыг дагаж мөрдөж байгаа эсэхэд үнэмлэхүй үнэлгээ өгөх зорилготой.

1.2. Дээр дурдсанчлан улс орнуудыг хоёр ангилалд багтаан авч үзэхээр тогтсон:

1.3. Нэр дэвшиг орнууд нь ОҮИТБС-ыг хэрэгжүүлэхээр элсэн орсон, Баталгаажуулалтын хүснэгт (дор үзнэ үү) дэх элсэн орох шатанд хангавал зохих дөрвөн үзүүлэлтийг бүгдийг хангасан, энэ талаарх нотлох баримтуудыг ОҮИТБС-ын Удирдах зөвлөл, Нарийн бичгийн даргын газарт гаргаж өгсөн орнууд байна. Энэхүү үзүүлэлтүүд нь аливаа засгийн газар дараахь зүйлийг гүйцэтгэсэн байхыг шаарддаг. Үүнд:

- ОҮИТБС-ыг хэрэгжүүлэх үүрэг амлалт авсан;
- иргэний нийгэм болон хувийн хэвшлийнхэнтэй хамтран ажиллах үүрэг хүлээсэн;
- хэрэгжилтийг хариуцан удирдан явуулах хүнээ томилсон;
- оролцогч талуудтайгаа хэлэлцэн тохирсны үндсэн дээр улсынхаа Үйл ажиллагааны төлөвлөгөөг гаргасан эсэх

1.4. **Дагаж мөрдөгч** орнууд нь ОҮИТБС-ыг бүрэн хэрэгжүүлж байгаа орнууд байна. Тэдний хувьд ОҮИТБС-ын Тайлангаа хэвлэн нийтэлж түгээх зэрэг Баталгаажуулалтын хүснэгтийн бүх үзүүлэлтүүдийг хангасан байна.

ОҮИТБС-ын эдгээр тайлангууд нь газрын тосны орлогын үр шимиийг бүгд хүртэж мэдрэх, улмаар Азербайжаны эдийн засагт үсрэлт гарч, тус улсын ард түмнийг баян чинээлэг болгохын төлөө түншийн хамтын ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулахад зоригжуулж байгаа хөдөлгөгч хүч гэж бид үздэг.

Дэвид Вүүдвард, БиПи Азербайжан компанийй дэд ерөнхийлөгч

Баталгаажуулалтын үйл явц

1.5. Бүдүүвч 1-д баталгаажуулалтын үйл явцыг дүрслэн харуулав. Баталгаажуулалтыг бүрдүүлэгч хүлээн зөвшөөрөгдсөн алхамуудын тухай дэлгэрэнгүй мэдээллийг дор нэгтгэн харуулсан бөгөөд Хавсралт А-гийн Баталгаажуулалтын зааварт оруулсан байгаа.

1.6. Хамгийн эхний алхам бол олон оролцогчдын бүлгийн зүгээс Баталгаажуулагчыг сонгож томилох явдал юм. Дараа нь уг Баталгаажуулагч үнэлгээ хийлгэх тухайн улсад очиж ажиллана. Баталгаажуулагчийн хийх ажил нь гурван үндсэн баримт бичигт тулгуурлана. Эдгээр нь:

- Тухайн улсын Үйл ажиллагааны төлөвлөгөө
- Баталгаажуулалтын хүснэгт (болон холбогдох Үзүүлэлтийн үнэлгээний хэрэгсэл)
- Компаниас бэлтгэсэн маягтууд байна.

Шигтгээ 3: Олон оролцогч талуудын бүлэг гэж юу вэ?

ОҮИТБС-ын Сурвалж бичигт (2005 оны 3 дугаар сар) ОҮИТБС-д олон тооны боломжит оролцогч талууд байгааг тэмдэглэсний дотор төрийн байгууллагууд, хувийн хэвшил, иргэний нийгэм, ОҮИТБС-ыг хэрэгжүүлэгчид, олон улсын түнш байгууллагуудыг дурдаж болно. Хэрэгжүүлэгч орны засгийн газрууд нь бүхий л холбогдох талуудын төлөөллийг хангасан зохицуулах хороо (буюу олон оролцогч талуудын бүлэг)-г байгуулах ёстой.

Олон оролцогч талуудын бүлэгт иргэний нийгмийнхэн (түүний дотор ард иргэдийн санаачилгад тулгуурласан байгууллагууд, үндэсний болон олон улсын ТББ-үүд, хэвлэл мэдээллийн хэрэгслийд, үйлдвэрчний эвлэлүүд, эрдэм шинжилгээний болон судалгааны байгууллагууд, шашны байгууллагууд) болон парламентчид чухал үүрэг гүйцэтгэх ёстойг ОУЗБ-ээс цохон тэмдэглэсэн байна.

1.7. Тухайн баталгаажуулагч эдгээр баримт бичгүүдийг ашиглан олон оролцогч талуудын бүлэг, засгийн газар ба компаниудаас гаргаж өгсөн тоо баримтыг нэгтгэх үүрэгтэй байгууллага болон бусад гол оролцогч талууд (түүний дотор олон оролцогч талуудын бүлэгт багтаагүй компаниуд, иргэний нийгмийнхэн)-тай уулзаж ярилцана.


1.8. Баталгаажуулагч энэхүү мэдээллээ ашиглан тайлан гаргах бөгөөд үүнд дараахъ зүйлсийг багтаасан байна:

- Гарсан ахиц дэвшилийг тухайн улсын үйл ажиллагааны төлөвлөгөөтэй харьцуулсан товч тайлан
- Гарсан ахиц дэвшилийг Баталгаажуулалтын хүснэгтийн үзүүлэлтүүдтэй харьцуулсан товч тайлан
- Бүрэн бөглөсөн Баталгаажуулалтын хүснэгт
- Компанийн хэрэгжүүлэлтийн талаарх тайлан
- Харьцуулж нэгтгэсэн компаний маягтууд
- ОҮИТБС-ын хэрэгжилтийн ерөнхий үнэлгээ: тухайн улс Нэр дэвшигч орон уу, Дагаж мөрдөгч орон уу, ямар нэг бодитой ахиц дэвшил гаргаж чадсан байна уу?

1.9. Энэхүү тайлан эхлээд тухайн улсын олон оролцогч талуудын бүлэг, засгийн газарт болон ОҮИТБС-ын Удирдах зөвлөлд очих ёстой. Хэрвээ эдгээр бүлгүүд тухайн Баталгаажуулалтын тайлангийн бүрдэлд сэтгэл ханамжтай байвал түүнийг хэвлэн нийтэлж, холбогдох дүгнэлт, саналуудыг гаргана.



Зураг 1: Баталгаажуулалтын үйл явц



Тухайн улсын Үйл ажиллагааны төлөвлөгөө

1.10. Баталгаажуулалтын үйл явц нь Улсын үйл ажиллагааны батлагдсан төлөвлөгөөнд тулгуурлан хийгдэх ёстай. Үйл ажиллагааны төлөвлөгөөг бэлтгэх нь ОУИТБС-ыг хэрэгжүүлэх зургаан шалгуурын нэг бөгөөд үүнийг Баталгаажуулалтын хүснэгтийн дөрөвдүгээр үзүүлэлтээс харж болно. ОУИТБС-ын гол оролцогч талууд Үйл ажиллагааны төлөвлөгөөг зөвшөөрч нийтийн хүртээл болгох ёстай. Үйл ажиллагааны төлөвлөгөө бүрт хэмжих болохуйц зорилтууд, хэрэгжүүлэх хугацаа, хэрэгжүүлэхдэд тулгарч болох хүндрэл бэрхшээлүүдийн үнэлгээ (засгийн газар, хувийн хэвшил, иргэний нийтгэм) болон гарч болзошгүй зардлуудыг агуулсан байна.

1.11. Мөн тухайн улсын үйл ажиллагааны төлөвлөгөөнд засгийн газраас ОУИТБС-ын олон оролцогч талт чанарыг хангах, ялангуяа иргэний нийгмийнхэнэйг татан оролцуулах талаас нь анхаарах ёстай.

1.12. Аливаа улс Нэр дэвшигч орны шатанд яваа тохиолдолд баталгаажуулалт хийлгэх цаг хугацааны хуваарийг тухайн улсын Үйл ажиллагааны төлөвлөгөөнд тогтоож өгсөн байна. Энэ нь тухайн улсын хэрэгцээ шаардлагыг хангасан байх бөгөөд дор хаяж хоёр жилд нэг удаа хийгдэхээр тусгагдсан байна. Удирдах зөвлөлөөс тухайн Нэр дэвшигч орны хэрэгжилтэд туслах үүднээс баталгаажуулалтыг хэтэрхий төвөгт удалгүйгээр илүү олон давтамжтай явуулах асуудлыг авч үзэж болно. Мөн үйл ажиллагааны төлөвлөгөөнд баталгаажуулалтын зардлыг тухайн засгийн газар хэрхэн төлж барагдуулахыг тодорхой заасан байна.

ОҮИТБС-ЫН Баталгаажуулалтын хүснэгт ба Үзүүлэлтийн үнэлгээний хэрэгсэл

- 1.13. Баталгаажуулалтын үйл явцын гол бүрдэл нь Баталгаажуулалтын хүснэгт, Үзүүлэлтийн үнэлгээний хэрэгсэл (YYX) хоёр юм. Баталгаажуулалтын хүснэгтэд шаардлага “хангасан” болон “хангаагүй” гэж чанарын хувьд үнэлгээ өгөх ёстой 18 үзүүлэлт, дээр нь хүүрнэл тайланд зөвхөн чанарын хувьд үнэлэх ёстой хоёр үзүүлэлт нэмэгдэж тусгагдсан байна.
- 1.14. Ямар нэг үзүүлэлтийг үнэлэхэд илүү нарийн түвэгтэй эсвэл субъектив үнэлгээ шаардагдах тохиолдолд YYX-ээс тухайн Баталгаажуулагчид нэмэлт заавар өгнө.
- 1.15. Бүх үзүүлэлтүүд нь ОҮИТБС-ЫН Зарчмууд ба Шалгууруудад нийцэх бөгөөд улс орнуудын хооронд учир утгатай харьцуулалт хийх боломж олгоно. Гэхдээ, ОУЗБ-ээс уг үзүүлэлтүүдийг боловсруулахдаа улс орнууд ОҮИТБС-ыг өөр өөр арга замаар хэрэгжүүлдэг онцлогийг тусгасан байгаа.

Шигтгээ 4: Арга зүйн боловсруулалт

ОУЗБ-т тулгарч буй нэг чухал асуудал бол баталгаажуулалтын үйл явцыг утга төгөлдөр болгож хангалттай стандартчилах, гэхдээ улс орнууд ба тэдгээрийн эдийн засгийн олон тооны ялгааг тусгаж, хангалттай уян байлгах явдал байв.

2005 оны 10 дугаар сард Вашингтонд болсон ОУЗБ-ийн хоёрдугаар уулзалтын үеэр Нигери, Азербайжан хоёр улсаас санал болгосон баталгаажуулалтын арга зүйг туршиж үзэн, хуримтлуулсан туршлагаа эргэж тайлагнахаар тохирсон юм. Нигери, Азербайжан хоёр бол хооронд нь харьцуулшгүй өөр эдийн засагтай орнууд бөгөөд ОҮИТБС-ЫН хэрэгжилтийг баталгаажуулах үеэр харгалзах өвөрмөц нөхцөл, эрс өөр олон асуудлууд гарч байв.

Азербайжан, Нигери улсуудын аль алиных нь туршлагаас баталгаажуулалтын үндсэн арга, зарчим хүлээн зөвшөөрөгдхүйц болохыг мэдэхийн зэрэгцээ уг арга зүйг хэрхэн сайжруулж болохыг ч харуулсан юм. Хоёр туршилтын аль алинаас баталгаажуулалтын үзүүлэлтүүдийн тоог эрс бууруулж болохыг санал болгосон. Түүнчлэн, хэдийгээр ОҮИТБС-ЫН гол тулгуур үзүүлэлтүүдийг хараахан хангаж чадаагүй ч, гарсан ахиц дэвшил, хийгдсэн сайжруулалтуудыг уг арга зүйд тусгах шаардлагатай байгааг тэд санал болгосон юм.

Тодорхой үзүүлэлтүүд хангагдсан, эсвэл хангагдаагүй болохыг үнэлэх шаардлагатай заавраар хангах үүднээс үзүүлэлтийн үнэлгээний шинэ хэрэгслийг боловсруулсан бөгөөд дэд үзүүлэлтүүдийг байхгүй болгосон арга байна.

Дээр нь, тухайн улсын үйл ажиллагааны төлөвлөгөө нь хэрэгжүүлэлтийн урьдач нөхцөл бөгөөд хэмжигдэхүйц зорилтууд, хэрэгжүүлэлтийн хуваарийг агуулдаг учраас оролцогч орон бүрийн үйл ажиллагааны төлөвлөгөөг баталгаажуулалтын ажиллагааны гол хэсэг болгохыг туршилтад оролцогчид санал болгосон юм.

Компанийн маягтууд

1.16. Компаниудын хэрэгжүүлэлтийг баталгаажуулах, гэхдээ үүнийг зөвхөн тухайн улсын үнэлгээний хүрээнд хийх ёстай гэдгийг ОУЗБ хэлэлцэж тохирсон. Иймээс тухайн улсын баталгаажуулалтын хүрээнд компаниуд урьдчилан өгөгдсөн маягтын дагуу өөрийгөө үнэлэх үнэлгээ хийж Баталгаажуулагчид буцааж өгөх явдал орж байна. Баталгаажуулагч хэрэв шаардлагатай бол компаниудаас илүү их нэмэлт мэдээлэл авахыг хүсэх бүрэн эрхтэй байна. Бөглөсөн маягтыг тухайн компанийн вэбсайтад байрлуулах ёстай бөгөөд тухайн Улсын үнэлгээний тайланд компанийн өөрийн үнэлгээний маягтуудыг зэрэгцүүлэн харьцуулж оруулсан байна.

1.17. Аливаа компани өөрийн үнэлгээний маягтыг бөглөж ирүүлээгүй бол Баталгаажуулагч энэ тухай Улсын үнэлгээний тайланд дурдаж, тухайн компаний тухай холбогдох ямар нэг мэдээллийг олон нийтийн мэдээллийн хэрэгслүүдээс авч уг тайланд оруулна. Мөн тухайн компанийд энэхүү мэдээллийг шалгах боломж олгоно.

1.18. ОҮИТБС-д оролцогч компаниуд уг санаачилгыг хэрэгжүүлэхийг зөвшөөрсөн тухайгаа өөрсдийн вэбсайт дээр тавьж мэдээлнэ.

1.19. ОҮИТБС-ыг дэмжих олон улсын үүрэг хүлээсэн компаниуд олон улсын түвшний өөрийгөө үнэлэх маягтыг бөглөж, түүнийгээ ОҮИТБС-ын Нарийн бичгийн дарга нарын газарт шууд ирүүлэх ёстай. Эдгээрийг ОҮИТБС-ын вэбсайт дээр байрлуулна.

Баталгаажуулалтыг хэн хийх ёстойг шийдэх нь

1.20. Баталгаажуулагч нь аливаа улсын хэрэгжилтэд гарч буй ахиц дэвшлийн талаар болон холбогдох улсын компаниуд хүлээсэн үүргээ биелүүлж байгаа эсэхийг тайлагнах үүрэгтэй.

1.21. Хэнээр баталгаажуулалт хийлгэх тухай асуудлыг ОУЗБ авч хэлэлцээд Баталгаажуулагч нь тухайн үнэлгээ хийлгэх орны тухайд гаднаас ирсэн, дараахь гол ур чадвар туршлагыг эзэмшсэн этгээд байна гэж тохирсон:

- Техникийн болон санхүүгийн ур чадвар
- Олон улсын хөгжлийн санаачилгатай ажилласан туршлага
- ОҮИТБС-ын тухай нарийн мэдлэг, боловсрол, туршлага
- Хангалттай чадавхи

1.22. Баталгаажуулагчид нь ОҮИТБС-ын үйл явцад гол үүрэг гүйцэтгэх үүднээсээ итгэл хүлээхүйц бөгөөд шударга, хараат бус байдлаа илтгэн харуулсан байх ёстай.

1.23. Баталгаажуулагчид тавигдах шаардлагыг Хавсралт Б-д үзүүлсэн Баталгаажуулагчийн Ажлын даалгавраас дэлгэрэнгүй үзэж болно.

Баталгаажуулагчийг томилох нь

1.24. ОҮИТБС-ын Нарийн бичгийн дарга нарын газар нь ОҮИТБС-ын Удирдах зөвлөлтэй хамтран Баталгаажуулагчдын жагсаалтыг батлан гаргана. Эдгээр хувь хүмүүс ба бүлгүүдийг нээлттэй, өрсөлдөөнтэй, ил тод сонгон шалгаруулалтын журмын дагуу сонгож авна. Баталгаажуулалт хийлгэж байгаа улс орнууд тухайн жагсаалтад бичигдсэн хэд хэдэн Баталгаажуулагчаас сонгож авах боломжтой байна. Эцсийн сонголтыг тухайн улсын олон оролцогч талуудын бүлгээс хийх бөгөөд зардлыг тухайн засгийн газар хариуцан төлнө.

Баталгаажуулалтын тайлан

1.25. Баталгаажуулалтын тайланда аливаа улс орон Нэр дэвшигч эсвэл Дагаж мөрдөгч орон эсэх, аль эсвэл хэрэгжүүлэлттэй холбоотой ямар нэг ноцтой асуудал байгаа эсэх тухай ерөнхий үнэлгээ орсон байна.

1.26. Уг тайланда хэрэгжилтийн явцад ажиглагдсан сургамжууд, түүнчлэн хүмүүсийн илэрхийлсэн санаа зовоосон асуудлууд, цаашдын хэрэгжилтэд зориулсан санал зөвлөмжүүдийг тусгана.

1.27. Тайланг тухайн улсын олон оролцогч талуудын бүлэг, засгийн газар болон ОҮИТБС-ын Удирдах зөвлөлөөс зөвшөөрсний үндсэн дээр англи хэл дээр болон тухайн орны хэл дээр хэвлэн, нийтийн хүртээл болгох ёстой.

Санал зөрөлдөөнийг шийдвэрлэх нь

1.28. Баталгаажуулалтын тайлантай холбоотой ямар нэг санал зөрөлдөөн гарвал эхний ээлжинд тухайн улсын засгийн газар, олон оролцогч талуудын бүлэг ба Баталгаажуулагчийн хүрээнд хэлэлцэн шийдвэрлэх ёстой. Хэрэв уг санал зөрөлдөөнийг ойлголцож хялбар шийдсэн бол Баталгаажуулагч тайландаа зохих нэмэлт, өөрчлөлтийг оруулах ёстой. Хэрвээ санал зөрөлдөөнийг энэ байдлаар шийдэж чадаагүй бол энэ тухай Баталгаажуулагчийн тайланд тэмдэглэх ёстой.

1.29. Баталгаажуулагч нь шаардлагатай тохиолдолд санал зөрөлдөөнөөс урьдчилан сэргийлэх болон шийдвэрлэх хангалттай өндөр зэрэглэл, ур чадвартай байна.

1.30. Баталгаажуулалтын үйл явцтай холбоотой ноцтой санал зөрөлдөөнийг ОҮИТБС-ын Удирдах зөвлөл болон Даргад хандан тавих бөгөөд тэд эдгээр маргаантай асуудлыг шийдвэрлэхийг эрмэлзэхийн зэрэгцээ ноцтой тохиолдолд баталгаажуулалтын ажиллагааг дахин явуулахыг шаардах боломжтой. Харин Удирдах зөвлөл ба Даргын

хувьд ялихгүй жижиг, уур уцаар хүргэсэн, үндэслэлгүй гэж үзсэн гомдлыг авч үзэхээс татгалзах бүрэн эрхтэй. Санал зөрөлдөөнийг шийдвэрлэх тухай дэлгэрэнгүй зааврыг 4.43 дугаар хэсэгт оруулав.

Баталгаажуулалтын дараах үйл ажиллагаа

1.31. Баталгаажуулалтаар ямар нэг чухал ахиц дэвшил гараагүй болон ОҮИТБС-ыг түүний Зарчмууд ба Шалгууруудад нийцүүлэн хэрэгжүүлэх хүсэл сонирхол багатай байна гэж үзвэл тухайн улсыг Нэр дэвшигч орнуудын жагсаалтаас хасах шийдвэрийг Удирдах зөвлөл гаргаж болно. Гэхдээ тухайн улсад ахиц дэвшил гаргах хангалттай боломж олгосны дараа л энэхүү “жагсаалтаас хасах” шийдвэрийг гаргаж болно. Жишээлбэл, удаа дараагийн баталгаажуулалтаар адил дүгнэлтэд хүрсэн тохиолдолд ингэж шийдэж болно.

1.32. Удирдах зөвлөл аливаа улсыг жагсаалтаас хэрхэн хасах тухай нарийн ширийн зүйлсийг ОУЗБ эцэслэн шийдвэрлэж гаргаагүй байна. Удирдах зөвлөл Баталгаажуулагчийн гаргасан дүгнэлтэд тулгуурлан шийдвэр гаргахын зэрэгцээ онцгой нөхцөл байдалд Баталгаажуулагчаас өгсөн санал зөвлөмжийг давж шийдвэр гаргах эрхтэй. Тухайлбал, хэрвээ Удирдах зөвлөл тухайн улсыг жагсаалтаас хасах нь тус улсын ашиг сонирхолд бүрэн нийцэхгүй гэж үзвэл ийн шийдэж болно. Удирдах зөвлөл иймэрхүү онцгой нөхцөл байдлын талаар сайтар эргэцүүлэн бодох ёстой.

1.33. Удирдах зөвлөл нь нэг бол а) жагсаалтаас хасах шийдвэр өөрөө гаргана, эсвэл б) жагсаалтаас хасах шийдвэр гаргахад зориулан явуулах үйл ажиллагааны тусгайлсан хувилбар гаргана.

1.34. Аливаа улсыг жагсаалтаас хасах шийдвэрт Удирдах зөвлөлийн гишүүд шууд биечлэн оролцож байгаа тохиолдолд ашиг сонирхолын зөрчилтэй гишүүд өөрсдөө уг хэлэлцүүлэгт оролцохос татгалзах ёстой гэж ОУЗБ үзэж байна. Зөвхөн тухайн Удирдах зөвлөлийн гишүүн “орлогч” гишүүнтэй тохиолдолд л шийдвэр гаргах зорилгын үүднээс уг гишүүнийг орлуулах боломжтой байна.

Хэсэг 2: ОҮИТБС-ыг хэрэгжүүлэх хөшүүрэг

Санал зөвлөмж 4: ОҮИТБС нь түүнийг хэрэгжүүлэхийн ашиг тусыг засаглалын илүү өргөн хүрээтэй шинэчлэлийн нэг хэсэг гэдэг үүднээс нь, мөн эрчим хүчний аюулгүй байдал, бизнесийн уур амьсгал зэрэг бусад ач холбогдол талаас нь илүү тодорхой нотлон харуулах ёстай.

2.0. ОҮИТБС-ын Зарчмуудад байгалийн нөөц баялагийг ухаалаг ашиглах нь тогтвортой хөгжил, ядуурлыг бууруулахад хувь нэмэр оруулдаг эдийн засгийн тогтвортой өсөлтийн нэг чухал хөшүүрэг байх ёстой гэж заасан байгаа. Энэ нь ОҮИТБС-ын оролцогч талуудын итгэл үнэмшлийг нотолдог. Түүнчлэн энэхүү өсөлтөд ил тод байдал болон төрийн санхүүгийн удирдлага, хариуцлагатай байдлыг дээшлүүлэх алхамууд чухал үүрэгтэй гэсэн итгэл үнэмшлийг ч тэд онцолдог.

2.1. Улам олон орнууд ОҮИТБС-д элсэн орж, түүнийг хэрэгжүүлж эхлэхийн хэрээр нотлох баримтын өргөн хүрээтэй, баттай үндэс суурь бий болгож болно. ОҮИТБС гэх мэт ил тод байдлын санаачилгууд нь харьцангуй шинэ бөгөөд ил тод байдлын бодит үр нөлөөг задлан шинжлэх эрдэм шинжилгээ судалгааны ажлууд харьцангуй хийгдсэн байдаг. Гэсэн хэдий ч ОҮЗБ-ээс нөөц баялаг ихтэй орнууд болон ОҮИТБС –ыг дэмжигч бусад орнуудыг зорижуулж болох хэд хэдэн боломжит хөшүүргийг цохон тэмдэглэсэн юм. Эдгээрийг дор дурдсан байдлаар авч үзэж болно. Тус санаачилгын ололт амжилтыг үргэлжлүүлэн бататгахын тулд ОҮИТБС-аас эдгээр боломжит хөшүүргүүдийн цаанаа буй нотлох баримтуудын үндэс суурийн талаар ойлгомжтой, итгэл төрүүлэхүйц байдлаар аль болох олон оролцогч талд хүргэж мэдээлэх шаардлагатай болно.

2.2. Мөн ОҮИТБС-ыг өргөн хүрээтэй шинэчлэлийн нэг гол чиглэл байдлаар хэрэгжүүлбэл хамгийн сайн хэрэгждэг болохыг ОҮЗБ онцлон тэмдэглэсэн. Энэ нь засаглалыг илүү сайн болгоход чиглэсэн нэг алхам буюу голдуу эхний алхам болдог төдийгүй хэрэгжүүлэгч улсад ил тод, хариуцлагатай байдлыг илүү өргөн хүрээнд дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлж чаддаг. Иймээс ОҮИТБС-ыг дагалдах ашиг тусыг энэ хүрээнд авч үзэх шаардлагатай.

2.3. Хэрвээ зарим орны хувьд түүнийг хэрэгжүүлэх хөшүүрэг бага байгаа бол тэдэнд илүү хүчтэй, тодорхой ашиг тус бий болгож өгөхөд олон улсын хамтын нийгэмлэгээс тусалж болох юм. Удирдах зөвлөл ч энэ асуудлыг цаашид авч үзэж болох юм.

Нөөц баялаг ихтэй орнуудын засгийн газруудын хүртэх үр шим

2.4. Шигтгээ 5-д ОҮИТБС-ыг хэрэгжүүлэх гол шалтгаанууд болон хэрэгжүүлсний ашиг тусын заримаас дурдаж байна. Энд эдгээр хөшүүргийг тодотгон харуулсан боловч Удирдах зөвлөлөөс цаашид хийх ажлын эхлэлийн цэг болох юм. Эдгээр үр шим нь ОҮИТБС-аас шууд урган гарах болон ил тод, хариуцлагатай байдал дээшилсний үр дүнд шууд бусаар хүртэх үр шимүүд байна.

Шигтгээ 5: Хэрэгжүүлэгч засгийн газрын хүртэх шууд болон шууд бус үр шимүүд

Чиглэл	Шууд үр шим	Шууд бус үр шим
Эдийн засаг	Олборлох үйлдвэрлэлийн компаниудаас авах татвар хураалт сайжирна	Хөрөнгө оруулалтын илүү тогтвортой, тааламжтай орчин бүрдэнэ
		Өсөлт нэмэгдэнэ
	Улсын гадаад өрийн зэрэглэлийн итгэл хүлээх чадвар нэмэгдэнэ	Хөрөнгө капитал олж авах боломж нэмэгдэнэ
	Авиалын түвшин буурна- үргүй зардал багасаж эдийн засгийн үйл ажиллагаа нэмэгдэнэ	Хувийн хөрөнгө капитал олж авах боломж нэмэгдэнэ
Засаглал	Хариуцлагатай байдал дээшилнэ	Зөрчилдөөн үүсэх эрсдэл багасна
	Төрийн санхүүгийн удирдлага хүчирхэгжинэ	Авиалга буурна
	Эрх зүйт төр, хариуцлагатай байдлыг илүүтэй хүндэтгэнэ	Тогтвортой байдал нэмэгдэнэ
		Олон нийтээс төр засагт итгэл нэмэгдэнэ
Хөгжил	Хүний хөгжилд оруулах хөрөнгө оруулалт нэмэгдэнэ	Нийгэмд шударга ёс дээшилнэ
	Ажил эрхлэлтийн түвшин, хөдөлмөрийн нөхцөл дээшилнэ	Ядуурлыг бууруулна
Нэр хүнд	“Манлайллагчид” болно	Төрийн байгууллагуудад илүү итгэж, хүндэтгэдэг болно
	Мэдлэгийг чухалчлах тусам илүү зөв зүйтэй хүлээлтүүд үүснэ	Улс төрийн хүрээнд шударга ёс нэмэгдэнэ

2.5. ОУИТБС нь хөгжлийн өргөн хүрээтэй хүчин чармайлтуудын нэг хэсэг болохын хувьд нийгмийг өөрчилж, ядуусын амьдралыг дээшлүүлж чаддаг. Ил тод байдал өөрөө төр засгийн бодлогын чанарыг дээшлүүлэх, хөрөнгө оруулалтын зардлыг бууруулах, гадаадын капиталыг татан оруулах замаар ялангуяа бага орлоготой хэсгүүдийн ядуурлыг бууруулах, амьжиргааны түвшнийг дээшлүүлэхэд хувь нэмэр оруулдаг.

Шигтгээ 6: Олборлох үйлдвэрлэл ба ядуурлын бууралт

Байгалийн баялаг бол түүнийг ашиглаж байгаа улс орнуудад ядуурлыг бууруулах асар их чадамжтай байдаг. Чили улсын үндэсний ядуурлын түвшин 1990-2003 оны хугацаанд 41 гаруй хувиар буурсан бөгөөд тус улсын уул уурхайн бүс нутаг Антофагастад ядуурал хамгийн их буюу 60% хувь буурсан байна.

Эх сурвалж: Гронингений Өсөлт ба Хөгжлийн Төв, Нидерланд улс

2.6. ОУИТБС-ыг хэрэгжүүлэх орнуудын хувьд нэг чухал урамшуулагч хүч нь бизнесийн орчин уур амьсгал сайжрах явдал бөгөөд ялангуяа тус санаачилгаас хөхиүлэн дэмждэг орлогын ил тод байдал нь авилгыг хязгаарлах хүчирхэг хэрэгсэл болдог. Авилга бага байна гэдэг бол бизнесийн өөртөө итгэх итгэл, итгэлцэлийг төрүүлэх нэг чухал хүчин зүйл байдаг.

“Газрын тос, уул уурхайгаас олсон мөнгийг зөв зохистой удирдахгүй байгаагийн сүйрүүлэгч үр нөлөө Африкт миний эргэн тойронд хаа сайгүй харагдаж байна. Хараахан ингэж зөв зохистой удирдаж чадахгүй байгаа Африкийн газрын тос үйлдвэрлэгч орнууд болон уул уурхайн салбарт оролцогч орнууд одоо энэ асуудлыг ойлгож идэвхтэй оролцоно гэдэгт би итгэж, залбирч байна. ОУИТБС-аас бидэнд илүү сайхан ирээдүйн төлөө хамтран ажиллах боломжийг олгож байна. Манай улсын болон Африкийн бусад улсын засгийн газрууд, олон улсын хамтын нийгэмлэгийнхэн бидэнтэй хамтран ажиллаж, уг санаачилгыг амьдралд хэрэгжүүлэхэд зохих хөрөнгө нөөцөөр хангана гэдэгт би итгэж байна.”

Эцэг Патрик Лафон, Төв Африкийн Хамба нарын Бага хурал

2.7. Ил тод байдал нь аливаа улс гадаадын хөрөнгө оруулагчид, олон улсын банкны хамтын нийгэмлэгийнхний итгэлийг хүлээх чадварыг дээшлүүлж, цаашдын хөгжлийнх нь чадамжийг сайжруулж чаддаг. Ил тод байдал сайтай орнуудад зээллэгийн зардал бага байдаг, ийм улсуудад хөрөнгө оруулалтын сангудаас ихээхэн хөрөнгө оруулдаг нь нотлогдсон. Шинээр төрөн гарч буй зах зээлтэй орнуудад өсөлтийн таатай боломж харагдаж байгаа учраас капиталын зах зээлийн хөрөнгө оруулалтууд тэдгээр орнуудад анхаарлаа улам ихээр хандуулж байна. Гэхдээ муу засаглал хөрөнгө оруулалтад ихээхэн саад тогтор учруулж болдог. ОУИТБС буюу ерөнхийдөө ил тод байдал нь түүнгүйгээр хөрөнгө оруулалтын хувьд тааламжтай бус байсан зах зээлүүдийг боломжит хөрөнгө оруулагчдын нүдэнд илүү амьдрах чадвартай харагдуулж чаддаг.

Нутгийн ард иргэд, иргэний нийгмийнхний хүртэх үр шим

2.8. Ил тод байдлын ерөнхий уур амьсгал нь иргэний нийгэмд эрх мэдэл олгож байдаг. Жишээлбэл, ОУИТБС-ыг хэрэгжүүлснээр тухайн улсын засаглал дахь олон нийтийн

оролцоог дээшлүүлж, иргэний нийгэмлэгийн байгууллагуудын мэдээлэл авах боломжийг сайжруулдаг. Нутгийн ард иргэдийн хувьд орлогын урсгал нэмэгдсэний эдийн засгийн үр шимийг хүртэж болохын зэрэгцээ нийгмийн шударга ёс, хариуцлагатай байдал, авилгын эсрэг тэмцэл идэвхжиж, сайн засаглал бэхжин хөгждөг.

2.9. Түүнчлэн компаниуд ба засгийн газартай харилцах харилцаа, үзүүлэх нөлөө нэмэгдэх, хөрөнгө оруулагчид, олон улсын байгууллагуудтай хэлхээ холбоо тогтоож бэхжүүлэх боломж ёсөх, засаглал сайжрах, төрийн байгууллагууд бэхжих, иргэд илүү их мэдлэг мэдээлэл, эрх мэдэлтэй болох зэргээс үүдсэн үр шимийг иргэний нийгмийн байгууллагууд хүртэж болох юм.

Компаниуд ба хөрөнгө оруулагчдын хүртэх үр шим

“Авила, муу засаглал хоёр нь дэлхийн шинээр төрөн гарч байгаа нөөц баялаг ихтэй орнуудад бизнес эрхлэхэд эрсдэлтэй, үнэ өртөг ихтэй болгож байна. Эдгээр орны засгийн газрууд ОҮИТБС-ыг авч хэрэгжүүлснээр хариуцлагатай байдал, эрх зүйт төрд тулгуурласан тогтвортой, баян чинээлэг нийгэм байгуулахаар шийдвэртэй зорьж байна гэсэн дохиог капиталын зах зээлүүдэд өгөх болно. ОҮИТБС бол хөрөнгө оруулагчдад бага эрсдэл, хөгжих байгаа орнуудад хямд капитал, нутгийн ард иргэдэд бизнесийн ил тод практик ба илүү сайхан амьдрал авчирна гэсэн үг.”

Алайн Грисэй, Эф&Си Ассет Менежмент пүүсийн Ерөнхий захирал

2.10. ОҮИТБС-ыг хэрэгжүүлэх үүрэг хүлээсэн орнуудад ажиллаж буй компаниуд уг санаачилгыг хэрэгжүүлэх шаардлагатай. Гэхдээ компаниуд тус санаачилгыг бүрэн дэмжихэд чиглэгдсэн хэд хэдэн хөшүүрэг бий. Компаниуд түүнийг хэрэгжүүлнэ гэдэг бол капиталын зардал бага байна, компанийн нэр хүнд, ажилтнуудын сэтгэл ханамж дээшилнэ гэсэн үг. Илүү их ил тод байдал нь хувьцаа эзэмшигчдийн харилцаа ба зах зээлийн итгэх итгэлийг сайжруулж, эрсдэлийн илүү сайн удирдлага, ард иргэдтэй харилцах харилцааг бий болгодог. ОҮИТБС-ын зүгээс аливаа хэрэгжүүлэгч улсад үйл ажиллагаа явуулж буй бүх компаниудаас ил тод байдал шаардаж буй арга барил нь тэдний өрсөлдөөний талбарыг адил тэгш болгож, хариуцлагатай компаниудыг бусдын хариуцлагагүй байдлаас хамгаалахад тустай байж болно.

2.11. Түүнчлэн, компаниуд ОҮИТБС гэх мэт хөгжлийн өргөн хүрээтэй зорилтуудыг дэмжсэнээр хүний хөгжил, байгаль орчны чиглэлийн үүрэг хариуцлага болон орон нутгийн ач холбогдолтой асуудлуудад ашгаасаа хөрөнгө оруулах үүрэгтэй корпорацийн нийгмийн хариуцлагын зорилтуудаа биелүүлэхэд тустай байж болно. Мөн компаниуд өөрсдийн үйлдвэрлэлээс тухайн бүс нутгийн байгалийн баялагт үзүүлж байгаа үр нөлөөг ойлгож байгаагаа харуулсныхаа үр шимийг хүртэх боломжтой.

Дэлхий нийтийн эрчим хүчний аюулгүй байдлын үр шим

2.12. Эрчим хүчний аюулгүй байдал нь ялангуяа шинээр хөгжиж буй эдийн засагтай улс орнуудын байгалийн гаралтай эрчим хүчний нөөцийн эрэлт өсөхийн хэрээр уlam бүр дэлхий нийтийн тулгамдсан асуудал болж байна. Өнөөдрийн эрчим хүчний зах зээлүүд дээр тулгамдаж буй асуудал бол асар хурдацтай аж үйлдвэржиж байгаа дэлхий ертөнцийн эрэлт хэрэгцээг хангах хүрэлцэхүйц хэмжээний газрын тос, байгалийн хий, бусад түлшний нөөц байгаа юу гэдэгт биш, харин аль эх үүсвэр нь харьцаангүй эрсдэл багатай байна вэ, эдгээр нөөцүүдийг яаж аль болох үр ашигтай, өртөг зардал багатайгаар ашиглах вэ гэдэгт оршиж байна.

2.13. ОҮИТБС-ыг дагаж мөрдөгч улс орны хувьд эрчим хүчний найдвартай нийлүүлэгч гэсэн нэр хүндээ бэхжүүлснээрээ хэрэглэгчдээ нийлүүлэлтийн өөр эх үүсвэр эрж хайх сонирхолгүй болгож, улмаар орлогынхао урсгалыг илүү баталгаатай болгож өгдөг. Түүний зэрэгцээ тэд хэрэглэгч орнууддаа түгээлтийн дамжуулах хоолой байгуулах гэх мэт үнэ өртөг ихтэй төслүүдэд хөрөнгө оруулах сонирхол төрүүлж, улмаар дэлхийн зах зээлтэй тогтоох хэлхээ холбоогоо сайжруулдаг.

2.14. Дэлхий нийтийн эрчим хүчний аюулгүй байдалд хөтөлдөг олон хүчин зүйлс байдаг бөгөөд ОҮИТБС бол эрчим хүчний аюулгүй байдлыг удирдах ганц жор биш юм. Гэхдээ ОҮИТБС нь орлогын ил тод байдлыг хангаж, илүү их хариуцлагатай байдлыг бий болгосноор нөөц баялаг ихтэй олон оронд гардаг улс төрийн тогтвортгүй байдлын цаад шалтгааны нэгээхэн хэсгийг хөндөн авч үзэхэд тусладаг. Хэрвээ ил тод байдлын соёл бий болоогүй бол дэлхий нийтийн эрчим хүчний аюулгүй байдлын асуудлыг хөндөн авч үзэх гэсэн бусад ямар ч хүчин чармайлт хий дэмий оролдлого болох нь нотлогдох магадлалтай.

Хэсэг 3: ОҮИТБС-ыг хэрэгжүүлэхэд тулгараах сорилтууд

Санал зөвлөмж 5: ОҮИТБС нь уул уурхайн салбарын өвөрмөц онцлогт илүү их анхаарал хандуулах ёстай.

Санал зөвлөмж 6: ОҮИТБС ба түүнийг хэрэгжүүлэгч орнуудын зүгээс ил тод байдал, авилгын эсрэг ажиллагаа, хөгжлийн болон эрчим хүчний аюулгүй байдлын талаарх бусад хөтөлбөрүүдтэй хамтран ажиллах зохих боломжуудыг олж тогтоох ёстай.

Санал зөвлөмж 7: ОҮИТБС нь уг санаачилгыг бүсийн болон орон нутгийн түвшинд хэрэгжүүлэх боломжийн талаар цаашид ажиллах ёстай.

Санал зөвлөмж 8: ОҮИТБС нь шинээр хөгжиж буй эдийн засагтай улс орнуудын засгийн газруудтай ОҮИТБС-ын хэрэгжилтэд илүү сайн оролцохыг дэмжин хамтран ажиллах ёстай.

ОҮИТБС ба уул уурхайн салбар

3.0. Анх ОҮИТБС-ыг туршсан орнууд уул уурхайн хүчирхэг салбаруудтай байсан бөгөөд одоо ч ОҮИТБС уул уурхай хөгжсөн бусад улс оронд хэрэгжиж байна. ОҮИТБС-ыг хэрэгжүүлэхээр зөвшөөрсөн улс орнуудын бараг тал хувь нь үндсэндээ уул уурхайн орнууд байдаг бөгөөд тэдгээрт ил тод байдалтай холбоотой асар их үйл ажиллагаа явагдаж байна.

3.1. Харин уул уурхай зонхилдог орнуудад ОҮИТБС-ыг хэрэгжүүлэхэд нөлөөлдөг хүчин зүйлс нь голдуу газрын тос, эсвэл байгалийн хийн олборлох үйлдвэрлэл явуулдаг орнуудтай харьцуулахад нилээд өөр байдаг. Эдгээр хүчин зүйлсэд компаниудын үйл ажиллагааны арга барил, тухайн салбарын цар хүрээ, эдийн засгийн үр нөлөө, уул уурхайн бүс нутгууд дахь нийгмийн орчин нөхцөл зэргийг оруулдаг. Одоогийн байдлаар газрын тос, байгалийн хийн нөөцтэй улс орнуудад илүү их ахиц дэвшил гардаад байгаа бөгөөд ОҮИТБС-аас эрдэс баялгаар баян орнууд болон уул уурхайн компаниудыг түлхүү анхаарах нь чухал байна.

3.2. Энэ нь уул уурхайн салбарын өвөрмөц онцлогт тохирсон тусгай арга барил хэрэглэхийг шаардах болно. Үүнд эрдэс баялгаас хамааралтай орнууд, уул уурхайн компаниуд (бизнесийн холбоод), уг салбарыг тусгайлан сонирхдог иргэний нийгмийн байгууллагуудад зориулсан уул уурхайн дэд бүлгийг ОҮИТБС-ын Удирдах зөвлөлийн дор тусад нь байгуулах асуудал орох ёстай. Бусад дэд бүлгүүдийг ч шаардлагатай гэж үзвэл, хэрэгтэй үед нь байгуулах болно.

3.3. Энэхүү дэд бүлэг нь салбарын холбоод, эрдэс баялаг ихтэй орнуудын төлөөлөгчид (одоо ОҮИТБС-ыг хэрэгжүүлж байгаа эсэхээс үл хамааран), олон талт хамтын ажиллагааны байгууллагууд, хөрөнгө оруулалтын байгууллагууд болон уул уурхайн салбарт илүү анхаардаг ТББ-үүд ОҮИТБС-ын үйл явцад ойр дотно, үр нөлөөтэй оролцох боломжийг олгох болно.

3.4. ОҮИТБС нь Олон улсын уул уурхай, металийн зөвлөл ба холбогдох үйлдвэрчний эвлэлүүд гэх мэт уул уурхайн салбарын гол гол оролцогчдыг дэд бүлэгтээ хамруулах ёстай. Ингэснээр ОҮИТБС-ын загварыг тус салбарт тохируулан хэрэглэхэд шаардлагатай түншлэл, дэмжлэг, уул уурхайн талаарх мэдлэг туршлагыг тус Санаачилгад өгөөд зогсохгүй ОҮИТБС-ыг олон улс оронд хэрэгжүүлэхэд туслах юм.

Шигтгээ 7: Олон улсын уул уурхай, металийн зөвлөл (ОУУУМЗ)

Уул уурхайн салбар нь үйл ажиллагаа явуулж буй газрууддаа илүү тогтвортой нөлөө үзүүлэхийг дэмжихэд чиглэсэн нийтлэг нэг алсын хараа бүхий дэлхийн хэмжээний хэд хэдэн томоохон уул уурхайн компани хамтран уг Зөвлөлийг байгуулсан байна.

Ийм учраас ОУУУМЗ-ийн гүйцэтгэх үүрэг газрын тос, байгалийн хийн салбар дахь бизнест чиглэсэн салбарын холбоодтой огт адилгүй байдаг.

ОУУУМЗ-өөс Нөөцийн Хандивын Төсөл гэдэг үйл ажиллагаа-судалгааны төслөө эхлүүлсэн бөгөөд үүнийгээ НҮБ-ын Худалдаа, Хөгжлийн Бага Хурал (UNCTAD), Дэлхийн Банкны групп болон бусад олон янзын оролцогч талуудтай хамтран хэрэгжүүлж байна.

ОҮИТБС ба бусад хөтөлбөрүүд

3.5. ОҮИТБС бол ил тод, хариуцлагатай байдлыг хөхиүлэн дэмжих үүрэг хүлээсэн хэд хэдэн олон улсын хөтөлбөрүүдийн зөвхөн нэг нь юм. Дээр дурьдсанчлан ОҮИТБС-ыг өргөн хүрээтэй шинэчлэлийн нэг гол хэсэг байдаар бусад хөтөлбөрүүдэд нэмэлт болгож хэрэгжүүлбэл хамгийн сайн хэрэгждэг байна. ОҮИТБС-ын үр нөлөөтэй байдлыг дээд цэгт хүргэж, өргөн олонд хүргэх, мэдлэг туршлагaa хуваалцаж, хамтын ажиллагааг хөхиүлэн дэмжихэд туслахын тулд ОҮИТБС-аас үзэл санаа нэгтэй байгууллага, санаачилгуудтай нягт хамтран ажиллах ёстай.

3.6. Олон талт хамтын ажиллагааны болон санхүүгийн байгууллагаудаас ОҮИТБС-ын үйл ажиллагаанд нэмэлт болж, түүнийг дэмжиж болохуйц янз бүрийн санаачилга, ажлуудыг хийж байгааг ОУЗБ анхаарч авч үзсэн. Эдгээрийн дотор засаглалыг сайжруулах, төрийн санхүүгийн удирдлагыг бэхжүүлэхийг хөхүүлэн дэмжих замаар байгалийн нөөц баялгийн удирдлагыг боловсронгуй болгохыг шууд ба шууд бусаар дэмждэг санаачилгууд; хэдийгээр газрын тос, байгалийн хий, уул уурхайгаас өөр салбарт боловч ОҮИТБС-ын ил тод, хариуцлагатай байдлын талаар хийж буй ажлуудад нэмэлт болдог санаачилгууд ороно.

3.7. ОҮИТБС ямар байгууллага, санаачилгуудтай тусгайлан хамтарч ажиллах талаар ОУЗБ ямар нэг тогтсон дүгнэлтэд хүрээгүй байна. Удирдах зөвлөл үүнийг цаашдын ажлын хөтөлбөрийнхөө хүрээнд авч үзэх ёстай. Удирдах зөвлөл иймэрхүү бүх хэлхээ холбоог ОҮИТБС-ын зорилтуудад ямар хувь нэмэр оруулж болох вэ гэдэг талаас нь авч үзэх ёстайн зэрэгцээ холбогдох хөрөнгө санхүү, үзүүлэх янз бүрийн нөлөөг нь харгалзах ёстай гэдгийг ОУЗБ онцлон тэмдэглэсэн байна.

3.8. Удирдах зөвлөл (Дэлхийн Банк, ОУВС зэрэг байгууллагуудтай зөвлөлдөн) ОҮИТБС-ыг тогтсон үзэл санаа болгон төлөвшүүлж, түүнийг ирэх 3-5 жилийн дотор олборлох үйлдвэрлэлийн бүхий л холбогдох салбарт үйл ажиллагаа явуулах хэвийн хэм хэмжээ болгоход чиглэгдсэн боломжит хэлхээ холбоонуудыг авч үзэх нь чухал гэдгийг энд бас цохон тэмдэглэсэн.

ОҮИТБС-ыг бүсийн болон орон нутгийн түвшинд нэвтрүүлэх нь

3.9. ОҮИТБС нь үндсэндээ үндэсний түвшинд ажиллахад зориулагдаж ирсэн. Гэхдээ ОҮИТБС-аас бүсийн болон орон нутгийн засгийн газрууд, холбогдох эрх бүхий байгууллагуудад төлж буй төлбөрүүдийг гаргах талаар ОУЗБ авч хэлэлцсэн.

3.10. Нийтлэгдсэн шалгууруудын дагуу орлогыг хуваах талаар хууль тогтоомжийн буюу үндсэн хуулийн шаардлагууд тавигдсан тохиолдолд уг сангудыг тэдгээрт нийцүүлэн хуваарилахгүй бол итгэлцэлийг алдагдуулдаг. Зарим орнуудад үндэсний хэмжээний орлогын урсгалаас гадна орон нутгийн болон бүсийн орлогын урсгал нилээд их байдаг. ОУЗБ-ийн хурлууд болон уул уурхайн салбарын оролцогч талуудтай хийсэн салбарын чанартай хоёр удаагийн семинар дээр энэ нь ялангуяа уул уурхайн салбарт ард иргэдтэй харилцахад шийдвэрлэх үүрэгтэй асуудал гэж ярьсан билээ.

3.11. ОҮИТБС-ыг бүсийн болон орон нутгийн түвшинд хэрэгжүүлэх нарийвчилсан санал зөвлөмж гаргахаас өмнө багагүй ажил хийх шаардлагатай хэвээр байна. Энэ ажлыг хийхийн тулд шинэ Удирдах зөвлөлийн мэдэлд ажлын дэд хэсэг ажиллуулах нь зүйтэй бөгөөд орон нутгийн чанартай асуудлууд нь ашигт малтмалын олборлолттой онцгой уялдаатай учраас уул уурхайн салбарын мэдлэг туршлагатай Удирдах зөвлөлийн гишүүнээр даргалуулах нь зүйтэй. Удирдах зөвлөлийн бусад сонирхсон гишүүдийг болон харилцан тохиролцсоны үндсэн дээр шаардагдах мэргэжилтнүүдийг бүрэлдэхүүнд оруулах хэрэгтэй. Цаашид авч хэлэлцэх асуудлуудын дотор бүсийн болон орон нутгийн түвшний татвар төлөлтэд зориулсан маягууд, тодорхой бүс нутгууд дахь орлогын хуваарилалтыг тодорхойлох асуудал, туршиж хэрэгжүүлэх төслүүд зэргийг оруулж болох юм.

ОҮИТБС ба шинээр хөгжиж буй эдийн засагтай улс орнууд

“Сайн дурын зарчмууд ба ОҮИТБС хоёр хоёулаа “Хойд” зүгээс гаралтай учраас “нео-импералист” шинжтэй гэж үздэг болохыг би сонссон. Гэхдээ тэд бидний хэн нэгний зэмлэн буруушаамаар зорилтуудыг дэмжин сурталчилж байна гэж үү? Хэрвээ энэ асуултад “үгүй” гэж хариулж байгаа бол түүнийг түгээн дэлгэрүүлэх хамтын үүрэг хариуцлага хүлээхийг би Их-20-н бүх засгийн газруудаас шаардах байна.”

Сэр Марк Мүүди-Стюарт, Англо-Американ компаний захирал

3.12. ОҮИТБС-ыг Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага (ЭЗХАХБ)-ын гишүүн орнуудын ихэнх засгийн газрууд, ЭЗХАХБ-ын орнуудад төвтэй олон компаниуд дэмждэг. Одоо ОҮИТБС-аас шинээр хөгжиж буй эдийн засагтай улс орнуудын засгийн газрыг илүү ихээр татан оролцуулах чиглэлд ажиллах ёстай. Тэдний дэмжлэг, оролцоо тус Санаачилгын дунд ба урт хугацааны амжилтад шийдвэрлэх үүрэгтэй юм.

3.13. Бразил, Орос, Энэтхэг, Хятад төдийгүй Мексик, Өмнөд Африк гэх мэт шинээр хөгжиж буй эдийн засгуудын хүрээ тэлсээр, тэдний байгалийн баялгийн эрэлт хэрэгцээ өссөөр байна. Сүүлийн дөрвөн жилд дэлхийн хэмжээнд газрын тосны эрэлтэд гарсан өсөлтийн 40 хүртэлх хувийг Хятадын эдийн засгийн өсөлт дэнгаараа бий болгосон байна.

3.14. Шинээр хөгжиж буй буй эдийн засагтай улс орнуудад төвтэй компаниуд, түүний дотор төрийн өмчит газрын тос, байгалийн хийн компаниуд дэлхийн бөмбөрцгийн эргэн тойронд хийгдэж буй байгалийн баялгийн хайгуул, үйлдвэрлэлийн ажиллагаанд улам идэвхтэй оролцох болсон байна. Эдгээр компаниудын зарим нь ОҮИТБС-ыг хэрэгжүүлэгч орнуудад явуулж буй үйл ажиллагаагаараа дамжуулан тус санаачилгад аль хэдийн нэгдэн оролцож эхлээд байна.

3.15. ОҮИТБС-аас газрын тос, байгалийн хий, уул уурхайн компаниуд төвлөрч буй ЭЗХАХБ-ын гишүүн бус гол орнуудыг татан оролцуулах тусгай стратеги боловсруулах ёстай. Үүндээ иргэний нийгэм болон хувийн хэвшлийнхийг татан оролцуулах стратеги боловсруулах хэрэгтэй. Зарим засгийн газруудын үзэж байгаагаар НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаар батлуулахыг хичээх нь ОҮИТБС-ын хууль ёсны чадамжийг илүү их дээшлүүлэх болно.

Хэсэг 4: ОҮИТБС-ад чиглэсэн цаашдын зохицуулалтууд

Санал зөвлөмж 9: ОҮИТБС-ыг хэрэгжүүлэхэд зориулсан дэмжлэг нь тухайн орны идэвх санаачилгад тулгуурласан, тогтвортой байхын зэрэгцээ үр дүн, түншилж ажиллахад чиглэсэн байх ёстой.

- Нарийн бичгийн дарга нарын газар үндэсний болон олон улсын түншлэгч байгууллагуудтай ажиллаж ОҮИТБС-ын бүх оролцогч талууд улс төр, санхүү, техникийн дэмжлэг авах боломжтой байх нөхцлийг хангаж өгөх ёстой.

Санал зөвлөмж 10: ОҮИТБС нь тус санаачилгыг олон улсын түвшинд удирдан зохион байгуулах олон оролцогч талаас бүрдсэн Удирдах зөвлөлийг байгуулж Нарийн бичгийн дарга нарын газрын дэмжлэгтэйгаар ажиллуулах ёстой.

- Яваандаа ОҮИТБС-ыг "тогтсон үзэл санаа болгож", түүний зарчим, шалгууруудыг ирэх 3-5 жилийн дотор олборлох үйлдвэрлэлийн бүхий л холбогдох салбарт үйл ажиллагаа явуулах хэвийн хэм хэмжээ болгох ёстой.
- Удирдах зөвлөл нь ОҮИТБС-ыг дэмждэг оролцогч талуудыг тусгасан 19 гишүүнтэй, хараат бус нэг Даргатай байна.
- Ослод байгуулагдсан Удирдах зөвлөл дараагийн ОҮИТБС-ын Бага хурал хүртэл ажиллана.
- Удирдах зөвлөл нь аль болох зөвшилцөлд тулгуурлан ажиллана.
- Санал хураалт явуулах шаардлагатай үед хэрэглэх санал хураах журмыг Удирдах зөвлөлийн анхны хуралдаанаар хамтран хэлэлцэж шийдвэрлэнэ.
 - Удирдах зөвлөлийн дарга санал өгөх эрхтэй бөгөөд хэрвээ санал хураалтын журмаар гишүүдийн санал тэнцсэн тохиолдолд дарга санал өгч хагална.
- Оролцогч тал бүр өөрийн төлөөллөө оруулах зохицуулалттай байх ёстой. Харин Гишүүн ба Орлогч гишүүн гэсэн зохицуулалт хийхээр төсөөлж байна.
- Эхний ээлжинд дээд тал нь гурван жилийн хугацаатайгаар ажиллах орон тооны зургаан гишүүн бүхий Нарийн бичгийн дарга нарын газрыг Ослогийн бага хурлын дараа аль болох хурдан томилж ажиллуулна.
- Нарийн бичгийн дарга нарын газар ажлаа Удирдах зөвлөлд даргаараа дамжуулан тайлагнана.
- Нарийн бичгийн дарга нарын газрын санхүүжилтийг бүх оролцогч талын бүлгүүд хуваан гаргана.
- ОҮИТБС-ын Бага хурал хоёр жил тутамд нэг удаа зохион байгуулагдана.
- Удирдах зөвлөл дараа дараагийн бага хурлуудаар хэлэлцэх асуудлыг ярилцан тохирно.

ОҮИТБС бол харьцангуй богино хугацаанд асар их амжилт гаргасан ховорхон эвслийн нэг юм. ОҮИТБС нь ил тод байдлын тодорхой дүрмүүдийг хөхиулэн дэмжих, түүний дотор янз бүрийн улс орнуудад ОҮИТБС-ын хэрэгжилтэд хяналт шинжилгээ хийх үйл ажиллагаа бий болгох, уг санаачилгыг бүрэн хэрэгжүүлж байгаа улс орнуудыг шагнаж урамшуулах замаар амжилт олох болно.

Петр Эйген, ОҮИТБС-ын ОУЗБ-ийн дарга

4.0. ОҮИТБС-ыг хэрэгжүүлэх гол үүрэг хариуцлагыг хэрэгжүүлэгч орны засгийн газар өөрөө хүлээнэ гэдгийг ОУЗБ дахин нотолсон. Өнөөг хүртэл ОҮИТБС-ыг оролцогч оруууд өөрсдөө хэрхэн хэрэгжүүлж, өөрийн болгож, удирдан хөтлөж ирсэн нь түүний нэг чухал давуу тал мөн.

Улс орнууд санаачилгыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх нь

4.1. ОҮИТБС-д оролцох сонголт хийснийхээ дараа улс орон, салбар бүр санаачилгыг хэрэгжүүлэх өөрийн загварыг боловсруулах шаардлагатай болно. Гэхдээ өнөөдрийг хүртэл бидний олж аваад байгаа туршлагаас хэд хэдэн ерөнхий сургамж төрж гараад байна. Эдгээрийн заримийг ОҮИТБС-ын сурвалж бичигт оруулсан байгаа. Эдгээрийг байнга шинэчилж, цаашид авах сургамжуудыг тусгаж байх ёстой.

4.2. ОҮИТБС-ыг хэрэгжүүлэх үүрэг хариуцлага тухайн оронд өөрт нь оногдож байгаагийн зэрэгцээ олон улсын хамтын нийгэмлэгийн зүгээс шаардлагатай улс төр, санхүү, техникийн дэмжлэг үзүүлэх ёстой. Үүнд дэмжигч улс орнуудаас үзүүлэх хоёр талын хамтын ажиллагааны дэмжлэг туслалцаа эсвэл олон улсын санхүүгийн байгууллагууд, олон улсын ТББ-үүд, НҮБ гэх мэт дэлхий нийтийн байгууллагуудаас хэрэгжүүлэх хөтөлбөрүүд багтаж болох юм.

4.3. Үзүүлэх дэмжлэг нь дараахь онцлогтой байх ёстой:

- **Улс орны онцлог бүхий** - өөрийн гэсэн хэрэгжүүлэх үйл ажиллагаатай байх эрх нь хэрэгжүүлэгч орны засгийн газар, дотоодын иргэний нийгэм, хувийн хэвшлийнхэнд хадгалагдсан байна.
- **Үр дүнд чиглэсэн-** ОҮИТБС-ын тайлан, чадавхийг бэхжүүлэх ажиллагаа гэх мэт алсын үр дүнд чиглэсэн байна.
- **Түншлэлд чиглэсэн-** засгийн газар, иргэний нийгэм, компаниуд, хөрөнгө оруулагчид гэх мэт олон оролцогч талт аргуудын бүхий л бүрдлүүдийн оролцоог хангаж зохицуулсан байна.
- **Тогтвортой-** эхний шатны гаднаас дэмжлэг үзүүлэх хүчин чармайлтаас цааш уг үйл явцыг хэрхэн тогтвортой үргэлжлүүлэн авч явахыг урьдчилан тооцож боловсруулсан байна.

4.4. Аливаа улс орны ОҮИТБС-ын хэрэгжилтийг удирдан чиглүүлэх гол бүрдэл нь тухайн улсын Үйл ажиллагааны төлөвлөгөө байна. Үйл ажиллагааны төлөвлөгөө нь ОҮИТБС-ын Шалгууруудад нийцсэн байхын зэрэгцээ хэмжих болохуйц зорилтууд, хэрэгжүүлэх хуваарь, чадавхид тулгарч болох хүндрэл бэрхшээлүүдийн үнэлгээг багтаасан байна. Уг үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулахын тулд олон улсын санхүүгийн байгууллагуудаас дэмжлэг туслалцаа хүсч болно. Хэрэгжүүлэгч орны засгийн газар холбогдох оролцогч талуудтайгаа зөвлөлдсөний үндсэн дээр Үйл ажиллагааны төлөвлөгөөгөө боловсруулах ёстой. Хэрэгжилтийг дэмжих чиглэлд засгийн газрын өөрийн тавьж буй хүчин чармайлтууд

болон олон улсын хамтын нийгэмлэгийн дэмжлэг нь зөвшөөрөгдсөн Үйл ажиллагааны төлөвлөгөөтэй уялдсан байх ёстой.

4.5. ОҮИТБС-д оролцогч талууд нь шаардагдах улс төр, санхүү, техникийн дэмжлэг туслалцаа авах боломжтой байх үүднээс ОҮИТБС-ын Нарийн бичгийн дарга нарын газар нь хэрэгжүүлэгч оруудын засгийн газрууд, тэдгээрийн олон оролцогч талт бүлгүүд (нэгэнт байгуулагдсан), олон улсын хамтын нийгэмлэгийн холбогдох гишүүдтэй хамтарч ажиллах ёстой.

4.6. Тухайн улсын Үйл ажиллагааны төлөвлөгөө нь засаглал ба хөгжлийн үр нөлөөг сайжруулахад чиглэсэн засгийн газрын бусад хөтөлбөрүүдийн хүрээнд сайтар уялдсан байх ёстой. Энэ нь ОҮИТБС-ын хэрэгжилтэд зориулж олон улсын хамтын нийгэмлэгээс үзүүлэх дэмжлэгийн холбогдох бусад хөтөлбөрүүдэд хувь нэмэр оруулах (тэдгээртэй харилцан уялдах) нөхцлийг хангахад тустай байна.

“Элсэн орох” шатанд үзүүлэх дэмжлэг

4.7. Элсэн орох шатанд олон улсын хамтын нийгэмлэгээс засгийн газрууд, иргэний нийгэм, хувийн хэвшлийнхэнд энэ санаачилгыг хэрэгжүүлэхийн ашиг тусыг таниулж нөлөөлөх ёстой. Таниулах, мэдлэг дээшлүүлэх энэхүү шатанд засгийн газар, иргэний нийгэм, компаниуд, хөрөнгө оруулагчдын анхаарлыг татах, хэрэгжүүлэлтэд оролцохыг сонирхолтой бүлгүүдэд чадавхийг бэхжүүлэх болон бусад дэмжлэг үзүүлэх ажиллагаа орж болох юм.

4.8. Түүнчлэн, олон улсын түвшинд улс төрийн зөв зохистой мэдээлэл явах нөхцлийг хангах замаар дэмжигч орнуудыг элсэн орох эсэхээ шийдэхэд туслаж болно. Олон улсын хамтын нийгэмлэгийн зүгээс хэрэгжилтийг тойрсон янз бүрийн хөшүүргүүдийг ашиглах боломжийг улс орнуудад олгож болно.

“Бэлтгэл” шатанд үзүүлэх дэмжлэг

4.9. Аливаа улс нэгэнт ОҮИТБС-д элсэн орохоор шийдсэн тохиолдолд, иргэний нийгмийнхэн болон компаниуд энэ талын мэдлэг чадавхia дээшлүүлэхэд шаардагдах техникийн туслалцааг авч, сургалт явуулж байгаа эсэх, хэрэгжүүлэгч орны засгийн газруудад ОҮИТБС-ын дагуу хүлээсэн үүргээ биелүүлэхэд шаардагдах ур чадвар, тогтолцоо, ажилтнууд байдаг, тэднийг хөгжүүлж байгаа эсэхийг тогтооход олон улсын дэмжлэг туслалцаа хэрэгтэй байж болно.

4.10. Эдгээрт дараахь дэмжлэгийг оруулж болно:

- Засгийн газрууд орлогын тоо баримтуудын талаар зөвлөлдөх, тэдгээрийг илээр тайлагнах, түгээн дэлгэрүүлэх, мэтгэлцээн өрнүүлэхэд дотоодын иргэний нийгмийнхэн, өргөн олон нийт болон компаниудыг татан оролцуулах үүргээ удирдан зохион байгуулахад зориулсан техникийн туслалцаа үзүүлж, сургалт явуулах.
- Засгийн газруудын чадавхид хүндэрэл бэрхшээл учрах, мэдлэг туршлага дутагдахад туслах.

-
- Үндэсний болон төрийн өмчит компаниуд (зарим тохиолодолд үндэстэн дамнасан компаниудын төлөөлөгчийн газрууд) ОУИТБС-ын хөгжилд өөрсдийн үүргийг гүйцэтгэх боломж олгоход чиглэсэн дэмжлэг үзүүлэх.
 - Улсын компаниудад ОУИТБС-ын хэрэгжилтэд оролцоход зайлшгүй шаардлагатай тогтолцоог бий болгох үүднээс тодорхой чадавхийг бэхжүүлэх дэмжлэг үзүүлэх.
 - Иргэний нийгмийн гишүүдэд газрын тос, байгалийн хий, уул уурхайн салбар болон санхүүгийн бүртгэлийг ойлгоход шаардлагатай мэдлэг, чадвар олгох.

4.11. Түүнчлэн ТББ-уудад санаа бодлоо шударгаар илэрхийлэх боломж олгоход олон улсын хамтын нийгэмлэг дэмжлэг үзүүлэх ёстой.

ОУИТБС-ыг олон улсын түвшинд удирдах нь

ОУИТБС-ын Удирдах зөвлөл байгуулах

4.12. ОУИТБС-ын үйл ажиллагааг удирдан чиглүүлэх Удирдах зөвлөлийг байгуулах ёстой. Тус зөвлөл нь ОУИТБС-ын ерөнхий хөгжил, стратегийн чиглэл, итгэл хүлээх чадварыг төдийгүй олон нийтэд сурталчлах ажиллагаа, нөлөөллийн асуудлыг хариуцна. Үүний зэрэгцээ Удирдах зөвлөл нь ОУИТБС-ын Бага хуралд зориулж бичгээр тайлан бэлтгэн гаргах замаар дээрх асуудлуудын талаарх санал зөвлөмж боловсруулж, Бага хурлаар хэлэлцүүлнэ. Мөн Удирдах зөвлөл нь ОУИТБС-ын Нарийн бичгийн дарга нарын газрын үйл ажиллаагааг хянаж, удирдан чиглүүлнэ. Удирдах зөвлөлийн гишүүд үйл ажиллагаагаа ямагт тус Санаачилгын ашиг сонирхолд сайтар нийцүүлж ажиллах үүрэгтэй байна.

Удирдах зөвлөлийн гишүүнчлэл

4.13. Удирдах зөвлөл нь олон оролцогч талуудын онцлогийг тусгасан байх бөгөөд нэг хараат бус Даргаас гадна дараах гишүүдээс бүрдэнэ:

- Хэрэгжүүлэгч орнуудын (Дагаж мөрдөгч орнууд) 5 төлөөлөгч;
- Дэмжигч орнуудын 3 төлөөлөгч;
- Иргэний нийгмийн байгууллагуудын 5 төлөөлөгч;
- Компаниуд, компаниудын холбоодын 5 төлөөлөгч;
- Хөрөнгө оруулалтын компанийн 1 төлөөлөгч.

4.14. Түүнчлэн, Дэлхийн Банк, ОУВС гэх зэрэг олон улсын хэд хэдэн байгууллагын ажилтнууд, холбогдох бусад оролцогч талуудыг Удирдах зөвлөлийн хурлуудад Ажиглагчаар урьж оролцуулах ёстой. Тэд санал өгөх эрхгүй байна.

ОҮИТБС-ын гишүүдийн бүрдүүлэлт ба сэлгэлт

4.15. Удирдах зөвлөлд төлөөлөлтэй болох тухайгаа Сонирхогч талын бүлэг бүр хэлэлцэн шийдвэрлэх ёстай. Үүний тулд оролцогч талууд i) төлөөлөгчөөр сонгогдох, ii) сонгон шалгаруулалтад оролцох хүмүүсээ тохирох асуудлыг урьдчилж хэлэлцэх шаардлагатай. Мөн одоо байгаа, ирээдүйд орох боломжтой оролцогчдын хооронд зааглах, нөөцөд буй оролцогчдыг жинхэнэ оролцогч болохыг дэмжих үүднээс хоёр давхар гишүүнчлэлийн тогтолцоотой болох саналыг аль нэг оролцогч талын бүлгээс тавьж болзошгүй гэж үзэж байна.

4.16. Ослогийн Бага хурлаар анхны Удирдах зөвлөлийг байгуулахад оролцогч талуудын бүлгүүд төлөөлөгч (нараа)-өө нэр дэвшүүлнэ. Санал болгосон 19 төлөөлөгчийг Удирдах зөвлөлийн даргад нэр дэвшигчийг байлцуулан тус Бага хурал дээр танилцуулах ёстай. Ингээд Бага хурлын Үр дүнгийн мэдэгдэлд Удирдах зөвлөлд нэр дэвшүүлсэн гишүүдийн нэрсийг оруулна. Оролцогчид өөрсдийгөө Үр дүнгийн мэдэгдэлтэй холбож өгснөөрөө Удирдах зөвлөлийг байгуулахад оролцох юм.

4.17. Удирдах зөвлөл нь Ослогийн Бага хурлаас дараагийн Бага хурал хүртэл ажиллана. Өргөн хүрээтэй төлөөллийг дэмжих, Удирдах зөвлөлийн гишүүдийн өөрчлөлтийн залгамж чанарыг хадгалах үүднээс тухайн оролцогч талын бүлгийн өөр нэг гишүүн Удирдах зөвлөлийн гишүүний “Орлогч”-ийн хэмжээнд байж болохыг санал болгоод байна. Ингээд тодорхой хугацааны дараа Удирдах зөвлөлийн гишүүнийг суудлаасаа чөлөөлөгдөхөд Орлогч гишүүн нь Удирдах зөвлөлийн жинхэнэ гишүүн болох юм. Энэ үед тухайн оролцогч талын бүлгийн өөр нэг гишүүн шинэ Удирдах зөвлөлийн гишүүний Орлогч гишүүнээр сонгогдоно.

4.18. Удирдах зөвлөлийн гишүүд Орлогч гишүүдтэй болох тохиолдолд тэд Удирдах зөвлөлийн гишүүдээ орлож ажиллах болно. Тэд Удирдах зөвлөлийн хуралд ажиглагчаар оролцох боловч хэлэлцүүлэгт таслах эрхтэй оролцож (буюу санал өгөх) болохгүй. Харин Удирдах зөвлөлийн гишүүний эзгүйд түүний ширээнд сууж, хэлэлцүүлэгт оролцон, санал өгөх эрхтэй. Удирдах зөвлөлийн томилогдсон гишүүн тодорхой нэг санал хураалтад оролцооос татгалзах (тухайлбал, ашиг сонирхолын зөрчилтэй байна гэж үзэх) тохиолдолд Орлогч нь тухайн Удирдах зөвлөлийн гишүүний оронд санал хураалтад оролцож болно.

4.19. Түүнчлэн эзэнгүйдэл гаргахгүй байх, тасалдуулахгүй байх үүднээс Гишүүдийг Орлогдоор орлуулах товыг Удирдах зөвлөлийн даргатай урьдчилан тохирсон байх ёстай. Тухайлбал, тасалдал гаргахгүй тулд Удирдах зөвлөлийн хоёр, гурван хурал дамнуулан орлуулж болох юм.

Удирдах зөвлөлийн үндсэн чиг үүрэг

4.20. Удирдах зөвлөл нь ОҮИТБС-д нөлөөлөх бодлогын асуудлуудыг авч үзнэ. Удирдах зөвлөл ОҮИТБС-ын Бага хурлаас хөндсөн болон хэрэгжүүлэлтийн явцад урган гарсан асуудлуудын аль алиныг авч үзэх шаардлагатай болно. Жишээлбэл, 2006 оны ОҮИТБС-ын Бага хурлын дараа ОУЗБ-ийн тайлангийн Гуравдугаар хэсэгт нээлттэй үлдээсэн чиглэлүүдээр болон Ослогийн Бага хурлын Үр дүнгийн мэдэгдлээр дэвшүүлсэн асуудлуудаар Удирдах зөвлөл хэлэлцүүлэг явуулж, санал дүгнэлт гаргах шаардлагатай байж болно.

4.21. Удирдах зөвлөл нь Нарийн бичгийн дарга нарын газрын ажлыг удирдан чиглүүлэх ёстай. Удирдах зөвлөлийн гишүүд нь тодорхой бодлогын чиглэлээр, түүний дотор зохих судалгаа явуулах асуудлаар Нарийн бичгийн дарга нарын газраас зөвлөгөө авах хүсэлтийг тодорхой үндэслэлтэйгээр тавьж болно.

4.22. Удирдах зөвлөл нь ОҮИТБС-ыг хэрэгжүүлэгч улсууд болон компаниудын ажил байдалд үнэлгээ өгөх ёстай. Энэ үүрэгт Баталгаажуулагчдын жагсаалтыг (Нарийн бичгийн дарга нарын газраас бэлтгэсэн) батлах, Баталгаажуулалтын тайланг хүлээн зөвшөөрөх явдал орно. Мөн Удирдах зөвлөл нь ОҮИТБС-ыг хэрэгжүүлэгч бус орнуудад үнэлгээ өгөхөд хяналтын болон эцсийн арбитрийн үүрэг гүйцэтгэх ёстай.

4.23. Удирдах зөвлөл зөвшилцэлийн зарчим арга барилаар ажиллахыг зорих ёстай. Гэхдээ санал хураалт явуулах шаардлагатай үе байж болно. Санал хураалтыг яаж явуулах талаар ОУЗБ-ээс тогтсон санал зөвлөмж гаргаагүй бөгөөд үүнийг шинэ Удирдах зөвлөл хэлэлцэн шийдвэрлэх ёстай.

4.24. Ослод байгуулагдсан Удирдах зөвлөл нь олон улсын удирдлагын зохицуулалттай холбоотой шийдэгдээгүй үлдсэн хэд хэдэн гол асуудлыг онцлон авч үзэх шаардлагатай. Үүнд:

- Удирдах зөвлөлийн ирээдүйн даргыг томилох үйл явц
- Удирдах зөвлөлийн дарга болон гишүүдийн бүрэн эрхийн хугацаа
- Санал хураалтын тогтолцоо (ба санал хураалт зайлшгүй явуулах шаардлагатай тохиолдлууд)
- Нэн тэргүүнд дэмжлэг үзүүлэх орнуудыг тодорхойлоход Удирдах зөвлөлийн гүйцэтгэх үүрэг
- Даргын цалин хангамж
- ОҮИТБС-ын бага хуралд зориулсан бусад зохицуулалтууд

4.25. Удирдах зөвлөл нь Нарийн бичгийн дарга нарын газрын дэмжлэгтэйгээр ОҮИТБС-ын бага хурлаар хэлэлцэн батлах тайланг гаргах ёстай. Үүнд ОҮИТБС-ын хөгжилд нөлөөлж буй бодлогын гол асуудлууд төдийгүй ОҮИТБС-ын Нэр дэвшигч болон Дагаж мөрдөгч

орнуудад гарч буй ахиц дэвшлийн тайланг авч хэлэлцэж, санал зөвлөмж гаргах асуудал багтана.

Удирдах зөвлөлийн даргын үүрэг

4.26. Удирдах зөвлөлийн дарга нь гишүүд болон гол оролцогчид, түүний дотор засгийн газрууд, компаниуд, иргэний нийгэм, хөрөнгө оруулагчид, олон улсын байгууллагуудын хоорондын хамтын харилцааг хадгалахыг эрмэлзэх үүднээс Удирдах зөвлөлийн хурал хэлэлцүүлгийг удирдах ёстай. Дарга нь Удирдах зөвлөлийн санал өгөх эрхтэй гишүүний нэг байх бөгөөд олонхиор санал хураах тохиолдолд гишүүдийн санал тэнцсэн үед хагалах санал өгөх ёстай.

4.27. Дарга нь дараах үүрэгтэй. Үүнд:

- ОҮИТБС-ын Бага хуралд Удирдах зөвлөлийн тайланг танилцуулах;
- Тус санаачилгын олон оролцогч талт чанар хадгалагдаж, бүх шатны ОҮИТБС-д тусгалаа олж байх нөхцлийг бүрдүүлэх;
- Орлогын ил тод байдлыг цаашид дэлхий нийтээр баримтлах, үүнд засгийн газрууд, компаниуд болон бусад байгууллагуудаас шаардлагатай санхүүжилтийг татан оруулах үзэл санаатайгаар ОҮИТБС-ыг улс төр, бизнесийн ертөнцийн дээд түвшинд төлөөлөх;
- Удирдах зөвлөлөөс тодорхойлсон стратегиудыг хэрэгжүүлэх үүднээс Нарийн бичгийн дарга нарын газарт заавар удирдамж өгөх.

4.28. Удирдах зөвлөлийн дарга нь Удирдах зөвлөлийн зохих гишүүд, холбогдох бусад талуудын дэмжлэгтэйгээр Нарийн бичгийн дарга нарын газрын тэргүүнийг томилж, удирдах, түүний дотор үйл ажиллагааны удирдамжаар хангах, гүйцэтгэлийн биелэлтэд үнэлэлт дүгнэлт өгөх үүрэгтэй.

4.29. Дарга нь Удирдах зөвлөлөөр хэлэлцэх, батлуулах шаардлагатай асуудлуудаар зөвлөлийн хурлуудын завсар хугацаанд гишүүдтэйгээ хамтарч ажиллана. Зайлшгүй шаардлагатай үед шуурхай арга хэмжээ авах нөхцлийг бүрдүүлэхийн тулд чухал ач холбогдолтой асуудлуудад Даргын зүгээс оновчтой арга замаар зөвлөгөө өгч, авах журмыг Удирдах зөвлөл хэлэлцэн батлах ёстай.

Дэд бүлгүүд ажиллуулах нь

4.30. Удирдах зөвлөл нь ОҮИТБС-ыг хэрэгжүүлэх тодорхой ашиг сонирхлын чиглэлүүдийг хамаарах дэд бүлгүүд ажиллуулах ёстай. Эдгээр дэд бүлгүүд нь Удирдах зөвлөлд тулгарч буй стратегийн үндсэн асуудлуудыг шийдвэрлэх, урагш ахиулахад чухал үүрэг гүйцэтгэж болох юм. Дэд бүлгүүдийн гишүүнчлэлд ОҮИТБС-ын олон оролцогч талт чанарыг хадгалахын зэрэгцээ Удирдах зөвлөлийн гишүүд, холбогдох мэргэжилтнүүдийг хэлэлцэн тохирсны үндсэн дээр оруулж болох юм.

4.31. Дараах дэд бүлгүүд байж болно:

- Газрын тос болон байгалийн хийн (техник асуудлууд)
- Уул уурхайн (техник асуудлууд)
- Бүсийн болон орон нутгийн түвшний хэрэгжүүлэлт
- Баталгаажуулалт
- Хэрэгжилтэд үзүүлэх дэмжлэг

4.32. Дэд бүлгүүдийг Удирдах зөвлөлийн гишүүд даргална. Даргаар дамжуулан Удирдах зөвлөлд ажлаа тайлагнана. Ямар санал зөвлөмжүүд болон үйл ажиллагааг авч хэрэгжүүлэх асуудлыг Удирдах зөвлөл бүрэн хяналтандaa байлгана.

ОҮИТБС-ын Удирдах зөвлөлөөс Олон хандивлагчийн итгэлцлийн сангийн Зохицуулах хороотой харилцаа

4.33. ОҮИТБС-ыг хэрэгжүүлэхийг хүсч буй орнуудад санхүүгийн дэмжлэг үзүүлэх Олон хандивлагчийн итгэлцэлийн сан (ОХИС) байгуулагдсан. Уг санг Дэлхийн Банк удирдан ажиллуулдаг. Дэлхийн Банк болон уг Итгэлцэлийн санд 500.000 ам.доллараас дээш хандив өргөөд байгаа засгийн газрууд (одоогоор, Франц, Герман, Нидерланд, Норвеги, Их Британий засгийн газар)-ын төлөөлөгчдөөс бүрдсэн Зохицуулах хорооноос Итгэлцэлийн сангийн үйл ажиллагааны төлөвлөгөө гаргадаг.

4.34. Энэхүү Итгэлцэлийн сан нь Удирдах зөвлөлийн нэг дэд хороо биш юм. Харин Удирдах зөвлөл болон ОҮИТБС-ын Бага хурлаас гаргасан бодлогын санал зөвлөмжүүдийг аль болох харгалзан үздэг байх ёстой. Үүнийг хэрхэн хэрэгжүүлэх талаар Удирдах зөвлөл Зохицуулах хороотой тохиролцож хамтран ажиллана. ОҮИТБС-ын Удирдах зөвлөл, Итгэлцэлийн сангийн Зохицуулах хороо хоёрын хооронд Ойлголцлын санамж бичиг байгуулж болох санал гараад байгаа.

Удирдах зөвлөлийн хурлын зохицуулалтууд

4.35. Удирдах зөвлөл нь жилд дээд тал нь дөрвөн хурал хийхэд хүрэлцэхүйц жилийн төсөвтэй байна. Гэхдээ хоёроос гурван хурлыг биечлэн хийж, тэр хооронд видео эсвэл телеконференцээр дамжуулан хуралдахаар Удирдах зөвлөл шийдэж болно.

4.36. Удирдах зөвлөлөөс зөвлөлийн дийлэнх гишүүддэд тохиромжтой газар хурал хийхээр шийдвэр гаргана. Дараа нь Удирдах зөвлөлийн хурлыг зохих газарт нь зохион байгуулахад Нарийн бичгийн дарга нарын газар тухайн орны засгийн газар, бусад байгууллагуудтай хамтран ажиллана.

4.37. Удирдах зөвлөл бүхий л үйл ажиллагаагаа бүрэн ил тод байдлаар явуулах ёстой. Үүнд хэлэлцэх асуудал гаргах, баримт бичиг, протоколуудыг ил тод болгох явдал орно. Удирдах зөвлөлийн үйл ажиллагаа англи хэл дээр явагдах бөгөөд хэрвээ Удирдах зөвлөлөөс шаардсан, хэлэлцэж тохирсон тохиолдолд нэмэлт хэлүүдээр орчуулга хийгдэх ёстой.

ОҮИТБС-ын Нарийн бичгийн дарга нарын газар

4.38. Одоо байгаа Лондон дахь Олон улсын хөгжлийн газарт төвтэй Нарийн бичгийн дарга нарын газрыг бие даасан Нарийн бичгийн дарга нарын газраар сольж ажиллуулах ёстай. Нарийн бичгийн дарга нарын газар нь эхний ээлжинд орон тооны зургаан ажилтантай байна. Тэднийг Ослогийн Бага хурлын дараа аль болох хурдан томилох ёстай бөгөөд дээд тал нь гурван жилийн хугацаатай буюу 2009 оны 10-р сарын 29-ний өдөр хүртэл ажиллуулах ёстай.

4.39. Нарийн бичгийн дарга нарын газар нь Удирдах зөвлөлд ажлаа хариуцан тайлagnана. Тус газар нь ОҮИТБС-ын өдөр тутмын үйл ажиллагааг зохицуулан явуулна. Нарийн бичгийн дарга нарын газар нь оролцогч талуудтай харилцах, сурч мэдсэн зүйл буюу болон хамааралтай мэдээллийг хуваалцах, батлагдсан Баталгаажуулагч нарын жагсаалтыг удирдах, ОҮИТБС-ын Бага хурлыг зохион байгуулахад хүлээн авагч засгийн газарт туслах зэрэг үүрэгтэй.

4.40. Нарийн бичгийн дарга нарын газар нь хэрэгжилтийг дэмжих үүрэг гүйцэтгэнэ. Гэхдээ шууд дэмжлэг үзүүлэх эрхгүй бөгөөд энэ үүргийг Дэлхийн Банк, дэмжигч орнууд гэх мэт бусад байгууллагууд гүйцэтгэнэ. Харин Нарийн бичгийн дарга нарын газар нь дэмжлэг хэрэгтэй байгаа орнуудыг тодруулах, авах нөхцлийг бүрдүүлэх үүднээс Удирдах зөвлөл, Дэлхийн Банк болон бусад дэмжигч орнууд, байгууллагуудтай холбож өгөхөд чухал үүрэг гүйцэтгэх болно. Үүнд Нарийн бичгийн дарга нарын газраас дэмжигч орнууд, байгууллагуудыг тодорхой чиглэлд анхаарлаа төвлөрүүлэх, баталгаажуулалтын тайланда олж мэдсэн зүйлсийг анхааралдаа авахыг дэмжих явдал орно.

4.41. Түүнчлэн Нарийн бичгийн дарга нарын газар нь ОҮИТБС-ын олон нийтэд хандсан сурталчилгаа, нөлөөллийг удирдан явуулах үүрэгтэй.

ОҮИТБС-ын Бага хурал

4.42. ОҮИТБС-ын Бага хурал нь тус санаачилгын амжилтад чухал ач холбогдолтой хэвээр байх болно гэдэгтэй ОУЗБ санал нэг байв. Бага хурлууд хоёр жил тутамд нэг удаа зохиогдох ёстай. Дараа дараагийн бага хурлуудад хэн оролцох, хэрхэн зохион байгуулахыг Удирдах зөвлөл хэлэлцэн шийдвэрлэх шаардлагатай.

Санал зөрөлдөөнийг шийдвэрлэх нь

4.43. Хэрэгжүүлэх үйл явцын янз бүрийн шатанд оролцогчдын хооронд санал зөрөлдөөн гарах нь зайлшгүй. Иймд ОУЗБ дараахь зарчмыг хэлэлцэн тохирсон: санал зөрөлдөөн гарвал эхний ээлжинд тухайн хэрэгжүүлэгч оронд хэлэлцэж шийдвэрлэнэ, санал зөрөлдөөнийг аль болох цаг алдалгүй гарсан дор нь шуурхай шийдвэрлэх ёстай, ОҮИТБС-ын Зарчмуудын 6 дугаар зарчмын дагуу ОҮИТБС-д гарсан санал зөрөлдөөнийг

шийдвэрлэх арга нь талуудын хооронд байгуулсан гэрээ, эрх зүйн бусад тохиролцоонд агуулагдаж буй маргааныг шийдвэрлэх механизмтай давхардах, зөрчилдөх ёсгүй.

4.44. Хэрэв аливаа маргааныг тухайн улсын өөрийн олон оролцогч талуудын бүлэг шийдвэрлэж чадахгүй бол ОҮИТБС-ын Удирдах зөвлөл эсвэл Нарийн бичгийн дарга нарын газар (гадны мэдлэг туршлагын тусламжтайгаар) маргааныг шийдвэрлэхэд оролцно. Юуны өмнө Удирдах зөвлөлийн дарга тухайн улсын олон оролцогч талуудыг бүлэгтэй асуудлыг ярьж хэлэлцэнэ гэсэн санал гарч байна. Түүнчлэн, шаардлагатай бол Удирдах зөвлөлийн мэдэлд олон янзын оролцогч талаас бүрдсэн дэд бүлэг байгуулан хуралдуулж, маргааныг хэлэлцэж болно. Хэрвээ уг олон оролцогч талт бүлэг асуудлыг цаг тухайд нь шуурхай шийдвэрлэж чадахгүй хэвээр үргэлжилбэл Удирдах зөвлөл Даргаараа дамжуулан ямар нэг шийдлийг санал болгож болох юм.

ОҮИТБС-ын санхүүжилт


“Яг одоо ОҮИТБС-аас илүү хатуу, илүү их итгэл хүлээхүйц зайлшгүй шаардлагатай алхамуудыг хийх, хэрэгжилтийг илүү үр нөлөөтэй болгоход нь оролцогчдод туслах цаг болсон байна. Түүнчлэн уг санаачилгыг жинхэнэ дэлхий нийтийн хэмжээний болгож, дэлхий дээр бодитой өөрчлөлт гаргадаг болгоход бидэнд хөрөнгө хүч хэрэгтэй байна.”

Симон Тэйлор, Глобал Витнесс байгууллагын захирал

4.45. ОҮИТБС-ыг хэрэгжүүлэхэд дор хаяж дараагийн гурван жилийн хэрэгжүүлэлт, баталгаажуулалт, санал болгосон олон улсын удирдлагын зохицуулалтад зориулсан тасралтгүй санхүүжилт шаардагдана. Энэ санхүүжилтийг олох хэд хэдэн эх үүсвэр бий. Жишээлбэл, хэрэгжүүлэлтийн ажилд хэрэгжүүлэгч орны засгийн газрууд болон тэдгээр оронд ажиллаж буй компаниуд, иргэний нийгмийн байгууллагуудад гарах зардлууд, мөн хэрэгжилтийг дэмжиж буй олон улсын хамтын нийгэмлэгээс гарах зардлууд орох боломжтой. ОУЗБ-ээс эдгээр санхүүжилтийн талаар тогтсон санал зөвлөмж гаргаагүй, цаашид энэ асуудлыг Удирдах зөвлөлөөр хэлэлцэн шийдвэрлэх шаардлагатай. Гэхдээ асуудлыг авч хэлэлцэхэд чиглэл удирдамж болохуйц зарим нэг ерөнхий зохицуулалтуудыг хийсэн байгаа.

4.46. **Хэрэгжүүлэлт:** Дэлхийн Банкнаас ирэх гурван жилийн хугацаанд хэрэгжилтийг дэмжих ажиллагаанд 15-20 сая ам.долларын зардал гаргаж болзошгүй гэж (ОҮИТБС-ыг алгуур өсч хөгжихөөр төсөөлж) тооцоолсон байна. Үүн дээр нэмээд хэрэгжүүлэгч орнуудын засгийн газар, бусад оролцогч талуудаас гаргах зардал, хоёр талын хамтын ажиллагааны дэмжлэгүүд орох юм.

4.47. **Баталгаажуулалт:** Гурван жилийн хугацаанд баталгаажуулалтын зардалд 3.5 сая ам.доллар гарах тооцоотой байгааг ОУЗБ онцлон тэмдэглэсэн. Энэ нь ойролцоогоор 50 удаа үнэлгээ хийх боломж олгох юм. Түүнчлэн баталгаажуулалтын зардлыг түүнийг захиалан хийлгэж байгаа улс орны засгийн газрууд хариуцах ёстойг санал болгосон байгаа.



4.48. Удирдлага: ОУЗБ-ээс ирэх гурван жилд гарч болох олон улсын удирдлагын зардлын боломжит хүрээг 5-15 сая ам.доллар байна гэж үзсэн. Зардлын хувьсагчуудад янз бүрийн газар баталгаажуулалт хийхэд гарах зардлууд, цалингийн зардлууд, мөн Нарийн бичгийн даргын газраас хэрэгжилтийг дэмжихэд оролцох байдлыг харгалзсан. Удирдлагын зардлын дээд, доод заагийн хооронд гарч буй гол зөрүү нь Нарийн бичгийн дарга нарын газрын цалингийн зардлууд болон хөтөлбөрийн үйл ажиллагааны санхүүжилттэй холбоотой.

4.49. ОУИТБС-ын олон оролцогч талт үзэл санааг харгалзвал Удирдах зөвлөл, Нарийн бичгийн дарга нарын газрын цаашдын санхүүжилтийг Оролцогч талуудын бүх бүлгүүдийн хооронд хувааж гаргах ёстой (Шигтгээ 8-г үзнэ үү). Үүнд янз бүрийн оролцогч талуудын харилцан адилгүй санхүүгийн чадавхийг хэрхэн тусгах вэ гэдэгт анхаарал хандуулах ёстой.

Шигтгээ 8:

ОУЗБ-ийн төсвийн асуудал хариуцсан дэд бүлгээс Удирдах зөвлөл болон Нарийн бичгийн дарга нарын газрын санхүүжилтийг оролцогч талууд дараахь байдлаар хуваан гаргахыг санал болгосон:

Хэрэгжүүлэгч орнууд	20%
Дэмжигч компаниуд	25%
Дэмжигч орнууд	25%
Дэмжигч ТББ-ууд	15%
Хөрөнгө оруулагчид	15%

ОУЗБ нь энэхүү хуваарилалтын талаар нэг мөр санал зөвлөмж гаргаагүй болно.

4.50. Санхүүжилт олж цуглуулах ажиллагаа ОУИТБС-д хэт дарамт учруулахаас зайлсхийхийн тулд оролцогч талууд бүхий л үеийн санхүүжилтийг хариуцах, эсвэл ОУИТБС амжилттай үргэлжилвэл гурав дахь жилийн санхүүжилт эхний жилүүдийнхтэй адил хэмжээнд байна гэж төсөөлөөд ядаж эхний хоёр жилийн санхүүжилтийн шаардлагыг хангах үүрэг амлалт авах нь зүйтэй гэдгийг ОУЗБ тэмдэглэж байна. Түүнчлэн зарим оролцогч талуудын хувьд санхүүгийн байнгын үүрэг хариуцлага хүлээхээсээ илүү нэг удаа сайн дурын хандив өргөх нь дээр гэж үзэх тохиолдол байж болно.

4.51. ОУЗБ-ээс олон улсын удирдлага зохицуулалтад шаардагдах санхүүжилтийг авч хэлэлцэхдээ дараахь ажиглалтыг хийсэн:

- Хандивлагч дор бүрнээ санхүүжилтийн үүрэг хүлээхээс зайлсхийж зөвхөн нэг этгээд нь, тухайлбал тухайн улсын засгийн газар хариуцан Нарийн бичгийн дарга нарын газартай гэрээ байгуулах нь зүйтэй юм.
- Эдгээр үндсэн зардлуудад оруулах хандив нь ОУИТБС-ын амжилтын төлөө байнга үүрэг хүлээж байгаагийн үзүүлэлт байх болно. Хэрэгжүүлэгч орнуудын хувьд энэ хандивыг "гишүүний төлбөр" гэж ойлгож болох юм.

Хавсралт А: Баталгаажуулалтын удирдамж

Гарчиг

1. Оршил	47
Баталгаажуулалтын зорилго	47
Баталгаажуулалтын тойм	47
2. Баталгаажуулалтад шаардагдах үндсэн баримт бичгүүд	49
Улсын үйл ажиллагааны төлөвлөгөө	49
ОҮИТБС-ын Баталгаажуулалтын хүснэгт ба Үзүүлэлтийн үнэлгээний хэрэгсэлүүд	49
Компанийн маягтууд	51
3. Баталгаажуулалтын тайлан	52
4. Баталгаажуулалтын дараахь үйл ажиллагаа	53
5. Баталгаажуулалтын хүснэгт	54
6. Үзүүлэлтийн үнэлгээний хэрэгслүүд	56
7. Компанийн маягтууд	66
8. Дүгнэх үзүүлэлтүүд	70

1. Оршил

Баталгаажуулалтын зорилго

Баталгаажуулалт хоёр гол зорилготой байна:

- ОҮИТБС-ыг хэрэгжүүлж байгаа боловч хараахан бүрэн дүүрэн хэрэгжүүлж амжаагүй байгаа улс орнуудын хувьд (Нэр дэвшигч орнууд- дор үзнэ үү) баталгаажуулалт нь хэрэгжилтийн явцыг хэмжих зорилготой.
- ОҮИТБС-ыг бүрэн дүүрэн хэрэгжүүлж байгаа улс орнуудын хувьд (Дагаж мөрдөгч орнууд- дор үзнэ үү) баталгаажуулалт нь тухайн улс орон ОҮИТБС-ын Зарчмууд ба Шалгууруудыг дагаж мөрдөж байгаа эсэх тухай үнэмлэхүй үнэлгээ өгөх зорилготой.

Дээр дурдсанчлан, хоёр төрлийн улс орон байна гэж үзсэн:

Нэр дэвшигч орнууд нь ОҮИТБС-ыг хэрэгжүүлэхээр элсэн орсон, Баталгаажуулалтын хүснэгт (дор үзнэ үү) дэх элсэн орох шатны дөрвөн үзүүлэлтийг бүгдийг хангасан орнууд байна. Үүнд:

- ОҮИТБС-ыг хэрэгжүүлэх үүрэг амлалт авсан;
- иргэний нийгэм ба хувийн хэвшлийнхэнтэй хамтран ажиллах үүрэг хүлээсэн;
- хэрэгжилтийг удирдан явуулах хүнээ томилсон;
- оролцогч талуудтайгаа хэлэлцэн тохирсны үндсэн дээр улсынхаа Үйл ажиллагааны төлөвлөгөөг гаргасан байх явдал орно.

Дагаж мөрдөгч орнууд нь ОҮИТБС-ыг бүрэн хэрэгжүүлж байгаа орнууд байна. Тэдний хувьд ОҮИТБС-ын Тайллангаа хэвлэн нийтэлж, тараах зэрэг Баталгаажуулалтын хүснэгтийн бүх үзүүлэлтүүдийг хангасан байна.

Баталгаажуулалтын тойм

Зураг 1-д баталгаажуулалтын үйл явцыг дүрслэн харуулав. Баталгаажуулалтыг бүрдүүлэгч хүлээн зөвшөөрөгдсөн алхамуудын тухай дэлгэрэнгүй мэдээллийг энэхүү удирдамжид тусгасан болно.

Хамгийн эхний алхам бол олон оролцогчдын бүлгээс Баталгаажуулагчыг сонгож томилох явдал юм. Сонгогдсон Баталгаажуулагч нь гурван үндсэн баримт бичигт тулгуурлан ажлаа явуулна. Эдгээр нь:

- Тухайн улсын Үйл ажиллагааны төлөвлөгөө
- Баталгаажуулалтын хүснэгт болон Үзүүлэлтийн үнэлгээний хэрэгсэл
- Компанийн маягтууд болно.

Тухайн баталгаажуулагч эдгээр баримт бичгүүдийг ашиглан олон оролцогч талуудын бүлэг, компаниуд, засгийн газраас гаргаж өгсөн тоо баримтыг нэгтгэх үүрэгтэй байгууллага болон бусад гол оролцогч талууд (түүний дотор олон оролцогч талуудын бүлэгт ороогүй компаниуд, иргэний нийгмийнхэн)-тай уулзаж ярилцана.

Баталгаажуулагч энэхүү мэдээллээ ашиглан тайлан гаргах бөгөөд үүнд дараахь зүйлсийг багтаасан байна:


- Гарсан ахиц дэвшлийг тухайн улсын Үйл ажиллагааны төлөвлөгөөтэй харьцуулсан товч тайлан
- Гарсан ахиц дэвшлийг Баталгаажуулалтын хүснэгтийн үзүүлэлтуүдтэй харьцуулсан товч тайлан
- Бүрэн бөглөсөн Баталгаажуулалтын хүснэгт
- Компаний хэрэгжүүлэлтийн талаарх тайлан
- Харьцуулж нэгтгэсэн компаний маягтууд
- ОУИТБС-ын хэрэгжилтийн ерөнхий үнэлгээ: тухайн улс Нэр дэвшигч орон уу, Дагаж мөрдөгч орон уу, аль эсвэл ямар нэг бодитой ахиц дэвшил гараагүй байна уу?**

Энэхүү тайлан эхлээд тухайн улсын олон оролцогч талуудын бүлэг, засгийн газарт болон ОУИТБС-ын Удирдах зөвлөлд очих ёстой. Хэрвээ эдгээр бүлгүүд тухайн Баталгаажуулалтын тайлангийн бүрдэлд сэтгэл ханамжтай байвал түүнийг хэвлэн нийтэлж, холбогдох дүгнэлт, дагалдах арга хэмжээний саналуудыг гаргана.

Баталгаажуулалтын үйл явцтай холбоотой ямар нэг санал зөрөлдөөн гарвал түүнийг эхний ээлжинд дотооддоо хэлэлцэн шийдвэрлэх бөгөөд ноцтой маргаан гарсан тохиолдолд ОУИТБС-ын Удирдах зөвлөлд хандана.

Баталгаажуулалт бол санхүүгийн аудит биш юм. Баталгаажуулагчийн ажил үүрэг бол улс орнууд болон компаниудаас хийхээр амласан зүйлээ хийж гүйцэтгэж байгаа эсэхийг шалгах явдал болохоос санхүүгийн аудит хийх явдал биш.

Зураг 1: Баталгаажуулалтын ажлын бүдүүвч зураг



2. Баталгаажуулалтад шаардагдах үндсэн баримт бичгүүд

Улсын үйл ажиллагааны төлөвлөгөө

Баталгаажуулалтын нэг чухал бүрэлдэхүүн хэсэг бол тухайн хүлээн авагч Улсын үйл ажиллагааны төлөвлөгөө юм. Энэхүү Үйл ажиллагааны төлөвлөгөөг улс орнууд “элсэн орох” үе шатнаас “бэлтгэл” шатанд шилжихээсээ өмнө батлан гаргаж, нийтэлсэн байх ёстой. ОҮИТБС-ын шалгуурын дагуу тухайн Үйл ажиллагааны төлөвлөгөө нь санхүүгийн хувьд тогтвортой байх ёстой. Үүнд:

- хэмжиж болохуйц зорилтууд,
- хэрэгжүүлэлтийн хуваарь,
- хэрэгжүүлэх чадавхид тулгарах хүндрэл бэрхшээлүүдийн үнэлгээг агуулсан байх ёстой.

Мөн тухайн улсын Үйл ажиллагааны төлөвлөгөөнд засгийн газраас ОҮИТБС-ын олон оролцогч талт чанарыг хэрхэн хангахыг, ялангуяа иргэний нийгмийнхэнийг хэрхэн татан оролцуулахыг тусгасан байх ёстой.

Үйл ажиллагааны төлөвлөгөөнд аливаа улс “Нэр дэвшигч” орны шатанд байгаа тохиолдолд баталгаажуулалт хийлгэх цаг хугацааны хуваарийг тогтоож өгөх ёстой. Энэ нь тухайн улсын хэрэгцээ шаардлагыг тусгаж дор хаяж хоёр жилд нэг удаа хийгдэх ёстой. ОҮИТБС-ын Удирдах зөвлөлөөс тухайн Нэр дэвшигч орны хэрэгжилтэд туслах үүднээс баталгаажуулалтыг хэт төвөгт удалгүйгээр илүү олон давтамжтай явуулах асуудлыг авч үзэж болно. Мөн баталгаажуулалтын зардлыг тухайн засгийн газар төлж барагдуулахыг Үйл ажиллагааны төлөвлөгөөнд тодорхой заасан байна.

Баталгаажуулагч нь ОҮИТБС-ын хэрэгжилтэд гарч буй ахиц дэвшилийг эдгээр зорилтууд болон цагийн хуваарытай харьцуулан үнэлэх, тухайн улсын чадавхид тулгарах хүндрэл бэрхшээлүүдийг арилгах арга хэмжээ авсан эсэхэд үнэлэлт өгнө.

Тухайн улсад хийгдэж буй баталгаажуулалтын үйл явцын нэг гол бүрдэл бол хэрэгжүүлэлтийн хуваарийг цаг хугацааны хувьд баримталж байгаа эсэх юм. Хэрвээ цагийн хуваарийг мөрдөхгүй байгаа бол Баталгаажуулагч гол оролцогч талууд, бусад этгээдүүдээс авсан нотлох баримтад тулгуурлан уг цагийн хуваарийг үндэслэлтэйгээр хойшлуулсан эсэхийг тодорхойлох шаардлагатай болно.

Баталгаажуулагч хэрэгжилтэд гарсан ахиц дэвшилийн тухай үзэл бодлоо тайлан байдлаар бичих ёстой.

ОҮИТБС-ЫН Баталгаажуулалтын хүснэгт ба Үзүүлэлтийн үнэлгээний хэрэгслүүд

Баталгаажуулалтын үйл явцын гол цөм нь ОҮИТБС-ын Баталгаажуулалтын хүснэгт юм. Энэ нь Баталгаажуулагч ахиц дэвшилийн үнэлгээндээ ашиглаж ёстой 20 үзүүлэлтээс бүрдэнэ. Эдгээрийн 18-ыг нь “хангасан”, “хангаагүй” гэсэн үнэлгээ тавьж бөглөнө. Харин хоёр үзүүлэлтэд (компаний баталгаажуулалт ба үнэлэлт дүгнэлт) Баталгаажуулагчийн тайлангаар үнэлгээ өгөх ёстой. Баталгаажуулагчийн тайланд уг Хүснэгт, Үзүүлэлтийн үнэлгээний хэрэгсэл (дор үзнэ үү) хоёроос гадна, гарсан ахиц дэвшилийг Хүснэгтийн үзүүлэлтүүдтэй харьцуулж үнэлсэн тайланг оруулсан байх ёстой.

Баталгаажуулалтын хүснэгтийн үзүүлэлтүүдийн бараг тал хувь нь объектив чанартай бөгөөд Баталгаажуулагч тэдгээрийг хангасан, эсвэл хангаагүй эсэхийг шийдэх ёстой.

Үзүүлэлтүүдийн тал хувь нь объектив чанар багатай бөгөөд дараах ажлуудтай холбоотой:

- a. **Үзүүлэлт 4- Улсын үйл ажиллагааны төлөвлөгөө.** Дээр дурдсанчлан Улсын үйл ажиллагааны төлөвлөгөө бол баталгаажуулалтын үйл явцын гол бүрдэл мөн. Үүнтэй холбоотойгоор уг хүснэгтийн 4 дүгээр үзүүлэлт нь Улсын үйл ажиллагааны төлөвлөгөөнд байж болох бүрэлдэхүүн хэсгүүдийг жагсаан гаргасан Үзүүлэлтийн үнэлгээний хэрэгсэлтэй байна.
- б. **Бэлтгэл шат.** Тухайн Баталгаажуулагч бэлтгэл шатанд гарсан ахиц дэвшилийг үнэлэхдээ янз бүрийн улс орнуудад хэрэгжүүлэх арга барилыг харгалzan үзэх зайлшгүй шаардлагатай болдог. Энэ зорилгоор үзүүлэлт бүр холбогдох Үзүүлэлтийн үнэлгээний хэрэгсэлтэй байдаг тэр нь уг үзүүлэлтийг хэрхэн үнэлэх тухай зааврыг Баталгаажуулагчид өгдөг.
- в. **Компаний баталгаажуулалт.** Энэ нь тухайн улсын үнэлгээний үйл явцын нэг хэсэг бөгөөд компаний үйл ажиллагаатай тусгайлан холбоотой асуултуудад хариулахыг шаарддаг. Компаниудад зориулсан Үзүүлэлтийн үнэлгээний хэрэгсэл нь компани бүрийн бөглөх ёстой өөрийгөө үнэлэх маягт гаргасан байдаг. Компанийн баталгаажуулалтад зориулсан хүснэгтэд “хангасан” эсвэл “хангаагүй” гэсэн тэмдэглэгээ байдаггүй нь олон компаний тайланг иймэрхүү байдлаар нэгтгэн дүгнэхэд хэцүү байдагтай холбоотой. Харин Баталгаажуулагч нь компаниудын өгсөн хариултуудын үнэлэлт дүгнэлтийг тайлан байдлаар оруулахын зэрэгцээ хариулалтуудыг харьцуулан жишиж Баталгаажуулалтын тайландаа оруулах ёстой.
- г. **Түгээн дэлгэрүүлэлт.** Баталгаажуулалтын тайланг нийтийн хүртээл болгоход чиглэсэн тодорхой үйл ажиллагаануудын үнэлгээ байна.
- д. **Үнэлэлт дүгнэлт.** Үнэлгээний чанарын зорилтуудыг тодорхойлдог.

Дээр дурдсанчлан, тодорхой үзүүлэлтүүдэд зориулж **Үзүүлэлтийн үнэлгээний хэрэгсэлийг** боловсруулсан болно. YYX-ийн зорилго бол тухайн үзүүлэлтэд гадны оролцоо ихтэй буюу илүү субъектив чанартай тохиолдолд яаж үнэлэх тухай нэмэлт зааврыг

Баталгаажуулагчид өгөх явдал юм. Зарим YYX-үүдийн хувьд дурдсан нотлох баримт ил байгаа эсэхийг Баталгаажуулагч шалгах ёстoy. Харин бусад YYX-үүдийн хувьд улс орнууд янз бүрийн арга барил хэрэглэж болохыг болон дурдсан нотлох баримтууд ил харагдаж байгааг давхар харуулдаг. Ийм YYX-үүдийн хувьд тухайн үзүүлэлтийг эерэгээр үнэлэхийн тулд дурдсан нотлох баримт бүрийг зайлшгүй шалгах шаардлага байхгүй.

Компанийн маягтууд

Компаниудын ОҮИТБС-ын хэрэгжилтийг ч бас баталгаажуулах ёстoy. Үүнийг тухайн улсын үнэлгээний нэг хэсэг байдлаар гүйцэтгэх ёстoy. Тухайн улсын баталгаажуулалтын ажлын хүрээнд компаниуд маягтын дагуу өөртөө үнэлгээ хийж, маягтыг Баталгаажуулагчид буцааж өгдөг. Баталгаажуулагч шаардлагатай бол компаниудаас илүү их нэмэлт мэдээлэл авахыг хүсэх бүрэн эрхтэй.

Бөглөсөн маягтыг тухайн компаний вэбсайтад байршуулж тухайн тайланда компаниудын өөрийн үнэлгээний маягтуудыг зэрэгцүүлэн харьцуулж оруулсан байна.

Аливаа компани өөрийн үнэлгээний маягтыг бөглөж ирүүлээгүй бол Баталгаажуулагч тухайн Улсын үнэлгээний тайланда дурдаж, компаний тухай ямар нэг холбогдох мэдээллийг олон нийтийн мэдээллийн хэрэгслийдээс авч уг тайланда оруулна. Мөн тухайн компанид энэхүү мэдээллийг шалгах боломж олгоно.

ОҮИТБС-д оролцогч компаниуд уг санаачилгыг хэрэгжүүлэхийг зөвшөөрсөн тухайгаа өөрсдийн вэбсайт дээр тавьж мэдээлнэ.

Харин ОҮИТБС-ыг дэмжих олон улсын үүрэг хүлээсэн компаниуд олон улсын түвшний өөрийгөө үнэлэх маягтыг бөглөх ёстoy бөгөөд түүнийгээ ОҮИТБС-ын Нарийн бичгийн дарга нарын газарт шууд ирүүлэх ёстoy. Эдгээрийг ОҮИТБС-ын вэбсайт дээр байрлуулна.

3. Баталгаажуулалтын тайлан

Дээр дурдсанчлан, Баталгаажуулалтын тайланда дараахь зүйлсийг тусгасан байх ёстой:

- Гарсан ахиц дэвшлийг тухайн улсын Үйл ажиллагааны төлөвлөгөөтэй харьцуулсан товч тайлан
- Гарсан ахиц дэвшлийг Баталгаажуулалтын хүснэгтийн үзүүлэлтүүдтэй харьцуулсан товч тайлан
- Бүрэн бөглөсөн Баталгаажуулалтын хүснэгт
- Компанийн хэрэгжилтийн тайлан
- Харьцуулж нэгтгэсэн компанийн маягтууд
- **ОҮИТБС-ын хэрэгжилтийн ерөнхий үнэлгээ: тухайн улс Нэр дэвшигч орон уу, Дагаж мөрдөгч орон уу, аль эсвэл ямар нэг бодитой ахиц дэвшил гараагүй байна уу?**

Баталгаажуулалтаар дорвитой ахиц дэвшил гараагүй, ОҮИТБС-ыг түүний Зарчмууд ба Шалгууруудад нийцүүлэн хэрэгжүүлэх хүсэл сонирхол багатай байна гэж үзвэл энэ нь тухайн улсыг Нэр дэвшигч орнуудын жагсаалтаас хасах хүртэл шийдвэрийг Удирдах зөвлөл гаргах ёстой гэж үзэх эсэх тухай тодорхой үнэлэлтийг Баталгаажуулагч бүрдүүлж өгөх нь чухал. Баталгаажуулагч иймэрхүү санал зөвлөмж бэлтгэхийн өмнө тухайн улсад ахиц дэвшил гаргах хангалттай хугацаа байсан эсэхийг шалгах ёстой. Жишээлбэл хоёр удаагийн баталгаажуулалтаар ижилхэн дүгнэлтэд хүрсэн тохиолдолд л ийм санал гаргахыг үндэслэлтэй гэж үзнэ. Гэхдээ өөр өөр нөхцөл байдалд зөвхөн нэг баталгаажуулалт хийсний дараа ийм дүгнэлтэд хүрэх нь зүйтэй ч байж болох юм.

Уг тайланда хэрэгжилтийн явцад авсан сургамжууд, түүнчлэн хүмүүсээс илэрхийлсэн санаа зовоосон асуудлууд, ОҮИТБС-ын цаашдын хэрэгжилтэд тус болохуйц санал зөвлөмжүүдийг агуулна.

Тайланг тухайн улсын олон оролцогч талуудын бүлэг, засгийн газар болон ОҮИТБС-ын Удирдах зөвлөлөөс нэгэнт зөвшөөрсөн тохиолдолд түүнийг хэвлэн гаргаж, англи хэл дээр болон дотоодын хэлүүдээр хэвлэж нийтийн хүртээл болгох ёстой.

4. Баталгаажуулалтын дараахь үйл ажиллагаа

Тухайн улсын засгийн газар, олон оролцогч талуудын бүлэг, ОУИТБС-ын Удирдах зөвлөлийн зүгээс Баталгаажуулалтын тайлантай холбоотой ямар нэг санал зөрөлдөөн гарвал Баталгаажуулагч үүнийг эхний ээлжинд тус улсын хүрээнд эдгээр бүлгүүдтэй хамтран хэлэлцэж шийдвэрлэх ёстoy. Ингээд уг санал зөрөлдөөнийг шийдсэн бол Баталгаажуулагч тайландаа зохих нэмэлт өөрчлөлтийг оруулах ёстoy. Хэрвээ санал зөрөлдөөнийг шийдвэрлэж чадаагүй бол энэ тухай Баталгаажуулагчийн тайланд тэмдэглэх ёстoy.

Баталгаажуулалтын үйл явцтай холбоотой ноцтой санал зөрөлдөөнийг ОУИТБС-ын Удирдах зөвлөл болон Даргад хандан тавих бөгөөд тэд маргаантай асуудлыг шийдвэрлэхийг эрмэлзэнэ. Харин Удирдах зөвлөл болон Даргын зүгээс ялихгүй жижиг, хүлээн авах боломжгүй, эсвэл үндэслэлгүй гэж үзсэн гомдлыг авч үзэхээс татгалзах бүрэн эрхтэй.

5. Баталгаажуулалтын хүснэгт

ОҮИТБС-ын Шалгуурууд-

ОҮИТБС-ын хэрэгжилт нь доорх шалгууруудад нийцэн байх ёстой.

1. ХЭВЛЭН НИЙТЛЭЛ: Компаниудаас засгийн газарт төлж байгаа газрын тос, байгалийн хий, уул уурхайн холбогдолтой бүх материаллаг төлбөрүүд ("төлбөрүүд") болон газрын тос, байгалийн хий, уул уурхайн компаниудаас засгийн газарт хүлээн авсан бүх материаллаг орлогуудын ("орлогууд") талаар өргөн олон нийтэд зориулж ил тод хүртээмжтэй, ойлгомжтой, цогц байдлаар тогтмол хэвлэн нийтэлж байх.

2. АУДИТ: Хэрэв хөндлөнгийн хяналт байхгүй бол дээрх төлбөр болон орлогуудыг итгэмжлэгдсэн, хараат бус аудитаар олон улсын аудитын стандартын дагуу шалгуулдаг байх.

3. НЭГТГЭЛТ: Төлбөр болон орлогыг итгэмжлэгдсэн, хараат бус захирагчаар олон улсын аудитын стандартын дагуу нэгтгэн дүгнүүлж, хэрэв ямар нэг зөрүүтэй, зөрчилтэй байдал илэрсэн бол тухайн захирагчын энэ талаарх дүгнэлтийг хэвлэн нийтэлдэг байх.

4. ХАМРАХ ХҮРЭЭ: Энэ аргыг бүх компаниуд, түүний дотор төрийн өмчтэй улсын үйлдвэрийн газруудад хамааруулан хэрэглэдэг байх.

5. ИРГЭНИЙ НИЙГЭМ: Дээрх үйл явцыг зохион байгуулах, түүнд хяналт шинжилгээ, үнэлгээ хийхэд иргэний нийгэм идэвхтэй оролцох бөгөөд олон нийтийн хэлэлцүүлэг өрнүүлэхэд хувь нэмрээ оруулдаг байх.

6. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ: Санаачилгыг хэрэгжүүлж буй хүлээн авагч засгийн газар, шаардлагатай тохиолдолд олон улсын санхүүгийн байгууллагуудын тусламжтайгаар, дээрх бүх үйл явцаад зориулан санхүүгийн хувьд тогтвортой Үйл ажиллагааны төлөвлөгөө гаргах, энэхүү ажлын төлөвлөгөөндөө хүрч болохуйц зорилтууд, хэрэгжүүлэх хугацаа, гарч болзошгүй хүндрэл бэрхшээлийн үнэлгээ зэргийг агуулсан, зардлыг бүрэн тусгасан үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж, олон нийтэд ил тод болгож мэдээлсэн үү?

ОҮИТБС-ын хэрэгжилт

Элсэн орох

Бэлтгэл

1. Засгийн газар ОҮИТБС-ыг хэрэгжүүлэх хүсэл сонирхолтой байгаа талаараа олон нийтэд хандсан тодорхой мэдэгдэл хийсэн үү?



2. Засгийн газар ОҮИТБС-ыг хэрэгжүүлэхэд иргэний нийгмийнхэн болон компаниудтай хамтран ажиллах үүрэг амлалт авсан үү?



3. Засгийн газар ОҮИТБС-ын хэрэгжилтийг хариуцан удирдах хүнээ томилсон үү?



4. Хүрч болохуйц зорилтууд, хэрэгжүүлэх хугацаа, чадавхид (засгийн газар, хувийн хэвшил, иргэний нийгэм) гарч болзошгүй хүндрэл бэрхшээлийн үнэлгээ зэргийг агуулсан, зардлыг бүрэн тусгасан үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж, олон нийтэд ил тод болгож мэдээлсэн үү?

Үзүүлэлтийн үнэлгээний хэрэгсэл (YYX)-ийг үзнэ үү.



5. Засгийн газраас ОҮИТБС-ын хэрэгжилтийг хянах олон оролцогч талуудын бүлэг байгуулсан үү?

YYX-г үзнэ үү.



6. Уг үйл явцаад иргэний нийгмийнхэн оролцож байна үү?

YYX-г үзнэ үү.



7. Уг үйл явцаад компаниуд оролцож байна үү?

YYX-г үзнэ үү.



8. Засгийн газар ОҮИТБС-ын хэрэгжилтэд тулгарч буй аливаа саад тогторыг арилгасан үү?

YYX-г үзнэ үү.



9. Тайлангийн загваруудыг хэлэлцэн тохирсон үү?

YYX-г үзнэ үү.



Ил тод тайлагнах

Мэдээлэл түгээлт

10. Тoo баримтуудыг цуглувж нэгтгэх байгууллагад олон оролцогч талуудын бүлэг сэтгэл ханамжтай байна уу?

ҮҮХ-г үзнэ үү.

11. Засгийн газраас бүх компаниудад тайлагнах нөхцлийг хангаж өгсөн үү?

ҮҮХ-г үзнэ үү.

12. Компаниудын тайлан олон улсын стандартуудын дагуу аудитлагдсан тоо бүртгэлд тулгуурласан байх нөхцлийг засгийн газар хангаж өгсөн үү?

ҮҮХ-г үзнэ үү.

13. Засгийн газрын тайлангууд олон улсын стандартуудын дагуу аудитлагдсан тоо бүртгэлд тулгуурласан байх нөхцлийг засгийн газар хангаж өгсөн үү?

ҮҮХ-г үзнэ үү.

14. Компаниудаас төлж байгаа газрын тос, байгалийн хий, уул уурхайн холбогдолтой бүх материаллаг төлбөрүүд (“төлбөрүүд”)-ийг уг тоо баримтыг нэгтгэн дүгнэх гэрээтэй байгууллагад тайлагнаж, ОҮИТБС-ын тайлан гаргасан уу?

18. ОҮИТБС-ын тайланг

- хүртээмжтэй,
- дэлгэрэнгүй,
- ойлгомжтой байдлаар олон нийтийн хүртээл болгосон уу?

ҮҮХ-г үзнэ үү.

15. Засгийн газарт хүлээн авсан газрын тос, байгалийн хий, уул уурхайн бүх материаллаг орлогуудын (“орлогууд”)-ыг уг тоо баримтыг нэгтгэн дүгнэх гэрээтэй байгууллагад тайлагнаж, ОҮИТБС-ын тайлан гаргасан уу?

16. Тoo баримтыг нэгтгэн дүгнэх гэрээтэй байгууллага үүргээ хангалттай биелүүлсэн гэдэгт олон оролцогч талуудын бүлэг сэтгэл ханамжтай байна уу?

17. ОҮИТБС-ын тайландаа зөрөөтэй байдлыг тодорхойлж, авбал зохих арга хэмжээний санал зөвлөмж гаргасан уу?

Газрын тос, байгалийн хий, уул уурхайн компаниуд ОҮИТБС-ыг хэрхэн дэмжиж байна вэ?

ҮҮХ-г үзнэ үү.

Хэрэгжилтийн явцад авсан сургамжуудаас суралцах, зөрүүтэй байдлыг шийдвэрлэх, ОҮИТБС-ыг цаашид тогтвортой хэрэгжүүлэх талаар ямар алхамууд хийгдээд байна вэ? ҮҮХ-г үзнэ үү.

6. Үзүүлэлтийн үнэлгээний хэрэгслүүд

Хүснэгтийн үзүүлэлт 4: Үзүүлэлтийн үнэлгээний хэрэгсэл

Үзүүлэлт: Хүрч болохуйц зорилтууд, хэрэгжүүлэх гацаа, чадавхид (засгийн газар, хувийн хэвшил, иргэний нийгэм) тулгарах хүндрэл бэрхшээлийн үнэлгээ зэргийг агуулсан, зардлыг бүрэн тусгасан үйл ажиллагааны төлөвлөгөө гаргаж, нийтэд ил болгож мэдээлсэн үү?

Зорилго: Улсын үйл ажиллагааны төлөвлөгөө бол тухайн улсын баталгаажуулалтын үйл явцын нэг бүрдэл юм. ОУИТБС-ын 6 дугаар шалгуурт гол оролцогч талуудтай хэлэлцэн тохирсны үндсэн дээр үйл ажиллагааны төлөвлөгөө гаргаж, олон нийтэд ил тод болгосон байхыг шаарддаг.

Нотлох баримт: Энэхүү үзүүлэлтээр үнэлгээ өгөхийн тулд Баталгаажуулагч тухайн үйл ажиллагааны төлөвлөгөөг гол оролцогч талуудтай хэлэлцэн тохирсон, төлөвлөгөөнд дараах зүйлсийг тусгасан эсэхийг шалгах болно:

- Хүрч болохуйц зорилтууд.
- Хэрэгжүүлэх хугацаа.
- Хэрэгжүүлэх чадавхид тулгарах хүндрэл бэрхшээлүүдийн үнэлгээ.
- Засгийн газраас ОУИТБС-ын олон оролцогч талт чанарыг хэрхэн хангах, иргэний нийгмийнхэнийг хэрхэн татан оролцуулах вэ.
- Аливаа улс "Нэр дэвшигч" орны шатанд яваа тохиолдолд баталгаажуулалт хийлгэх цаг хугацааны хуваарь. Энэ нь тухайн улсын хэрэгцээ шаардлагыг тусгах бөгөөд дор хаяж хоёр жилд нэг удаа хийгдэх ёстой.
- Үйл ажиллагааны төлөвлөгөөнд тухайн засгийн газар баталгаажуулалтын зардлыг хэрхэн төлж барагдуулахыг тодорхой заасан байна.

Баталгаажуулагч нь ОУИТБС-ын хэрэгжилтэд гарч буй ахиц дэвшлийг эдгээр зорилтууд болон хэрэгжүүлэх хугацаатай харьцуулан үнэлэх шаардлагатай. Бас тухайн улсын чадавхид тулгарах хүндрэл бэрхшээлүүдийг арилгах чиглэлд арга хэмжээ авсан эсэхэд үнэлэлт өгнө.

Тухайн улсад хийгдэж буй баталгаажуулалтын үйл явцын нэг гол бүрдэл хэсэг бол хэрэгжүүлэх хугацааг баримталж байгаа эсэх юм. Хэрвээ цаг хугацааг дагаж мөрдөхгүй байгаа бол Баталгаажуулагч (гол оролцогч талууд болон бусад этгээдүүдээс авсан нотлох баримтад тулгуурлан) уг хуваарийг ямар үндэслэлээр хойшлуулсан эсэхийг тодорхойлох шаардлагатай болно. Хэрвээ үндэслэлгүй байвал, Баталгаажуулагч тухайн улсыг Нэр дэвшигч орны жагсаалтаас хасах санал гаргах эсэхээ авч үзэх шаардлагатай.

Хүснэгтийн үзүүлэлт 5: Үзүүлэлтийн үнэлгээний хэрэгсэл

Үзүүлэлт: Засгийн газраас ОҮИТБС-ын хэрэгжилтийг хянах олон оролцогч талуудын бүлэг байгуулсан уу?

Зорилго: ОҮИТБС-ыг түүнд оролцогч холбогдох бүх талууд, түүний дотор хувийн хэвшил, иргэний нийгэм (иргэний нийгмийн бие даасан бүлгүүд, мөн хэвлэл мэдээлэл, парламентчид зэрэг бусад иргэний нийгмийнхэн орно), засгийн газрын холбогдох яамд зэргээс бүрдсэн (гэхдээ үүгээр хязгаарлагдахгүй) бүлэг удирдаж хянаж байх ёстой. Тус бүлэг нь тодорхой бөгөөд олон нийтийн чанартай Ажлын даалгавар (АД) гаргаж батлах ёстой. Ажлын даалгаврууд дараах зүйл багтдаг. Үүнд: Улсын үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах, шаардлагатай засвар өөрчлөлт хийх, компаниуд болон тухайн засгийн газраас нэгтгэхэд зориулж ирүүлсэн тоо баримтууд нь олон улсын стандартад нийцүүлэн аудитлагдсан тоо баримтад тулгуурлаагүй тохиолдолд түүнд аудит хийх аудиторыг сонгох, тоо баримт цуглуулж нэгтгэх байгууллагыг сонгох болон Баталгаажуулалтын хүснэгтэд дурдсан бусад ажлууд орно.

Нотлох баримт: Энэ үзүүлэлтээр үнэлгээ өгөхийн тулд Баталгаажуулагч ямар нэг олон оролцогч талт бүлэг байгуулагдсан, түүнд нь холбогдох оролцогч талууд багтсан, ажлын даалгавар нь зорилгодоо тохирч байгаа эсэх тухай нотлох баримт олж авах хэрэгтэй болно.

Нотлох баримтад дараах зүйлс орно:

- Оролцогч талуудын хийгдээд байгаа үнэлгээнүүд.
- Олон оролцогч талуудын бүлгийн гишүүнчлэлийн тухай мэдээлэл:
 - Уг бүлэгт оролцуулах нь нээлттэй, ил тод байсан уу?
 - Оролцогч талуудын төлөөлөл бүрэн хангагдсан уу (энэ нь оролцогч талууд адил тэгш төлөөлөлтэй байх ёстой гэсэн үг биш)?
 - Оролцогч талууд өөрийн төлөөллөө хангалттай оруулсан гэж үзэж байна уу?
 - Оролцогч талууд тухайн хорооны нэг хэсэг болж ямарваа зохисгүй нөлөөлөл эсвэл албадлагаас ангид ажиллаж (түүний дотор өөрсдийн сонгосон бүлэг болон бусад оролцогч талуудтай холбоотой ажиллах) чадна гэж үзэж байна уу?
 - Тус бүлгийн иргэний нийгмийг төлөөлсөн гишүүд нь үйл ажиллагааны хувьд болон бодлогын талаасаа төр засаг, хувийн хэвшлээс хараат бус байж чадах уу?
 - Бүлгийн гишүүд өөрчлөгдөх тохиолдолд хуучин байдлыг алдагдуулахгүйгээр ямар нэг байдлаар гишүүд нэмж оруулах албадлагын санал, оролдлого гарч байсан уу?
 - Бүлгийн гишүүд үүргээ гүйцэтгэх хангалттай чадавхитай юу?

- Ажлын даалгаварт ОҮИТБС-ын талаар хорооны зүгээс үг хэлэх эрх олгодог уу? Ажлын даалгавруудад наад зах нь дараахь зүйлийг оруулсан байх ёстой: Улсын үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах, шаардлагатай засвар өөрчлөлт хийх, компаниуд болон тухайн засгийн газраас нэгтгэхэд зориулж ирүүлсэн тоо баримтууд нь олон улсын стандартад нийцүүлэн аудитлагдсан тоо баримтад тулгуурлаагүй тохиолдолд түүнд аудит хийх аудиторыг сонгох, тоо баримт цуглуулж нэгтгэх байгууллагыг сонгох болон Баталгаажуулалтын хүснэгтэд дурдсан бусад ажлууд орно.
- Хороонд засгийн газрын эрх бүхий албан тушаалтуудын төлөөлөл орсон уу?

Хүснэгтийн үзүүлэлт 6: Үзүүлэлтийн үнэлгээний хэрэгсэл

Үзүүлэлт: Уг үйл явцад иргэний нийгмийнхэн оролцож байна уу?

Зорилго: Энэ үзүүлэлт нь 5 дугаар үзүүлэлтийг бататгаж байна. ОҮИТБС-ын шалгуурт уг үйл явцын боловсруулалт, хяналт шинжилгээ, үнэлгээ хийхэд оролцогчын хувьд иргэний нийгмийнхэн энэ ажилд идэвхтэй оролцох, олон нийтийн мэтгэлцээн өрнүүлэхэд хувь нэмрээ оруулахыг шаарддаг. Үүний тулд ОҮИТБС-ын хэрэгжилтэд иргэний нийгэм идэвхтэй оролцох шаардлагатай болно. Үүнийг олон оролцогч талуудын бүлгээр дамжуулах, эсвэл олон оролцогч талын бүлэгт нэмэлт үүрэг болгох байдлаар гүйцэтгэж болно.

Нотлох баримт: Энэ үзүүлэлтээр үнэлгээ өгөхийн тулд Баталгаажуулагч тухайн засгийн газар болон шаардлагатай тохиолдолд олон оролцогч талуудын бүлгээс ОҮИТБС-ын хэрэгжилтийн үйл явцад иргэний нийгмийнхнийг татан оролцуулахыг эрмэлзэж байгаа эсэхийг нотлох баримт олох хэрэгтэй болно. Үүнд дараахь нотлох баримт орох ёстой:

- Олон оролцогч талуудын бүлгээс өргөн хүрээтэй иргэний нийгмийн бүлгүүдэд хандаж тухайн засгийн газар ОҮИТБС-ыг хэрэгжүүлэх үүрэг амлалт авсан тухай болон үүнд иргэний нийгмийнхэн болон компаниудын гүйцэтгэх гол үүргийн талаар таниулан сурталчилж байгаа байдал, түүний дотор иргэний нийгмийн бүлэглэл, эвслүүдүүдтэй (тухайлбал Юу төлснөө нийтэл эвслийн дотоодын салбар гэх мэт) харилцааны хүрээ байгаа байдал (хэвлэл мэдээллийн хэрэгсэл, вэбсайт, албан бичгээр).
- Иргэний нийгмийн оролцоонд нөлөөлж буй чадавхийн асуудлыг хөндөж шийдвэрлэх талаар засгийн газар, иргэний нийгэм, компаниудаас хэрэгжүүлж байгаа арга хэмжээ.
- ОҮИТБС-д оролцож буй иргэний нийгмийн бүлгүүд үйл ажиллагааны хувьд ч, бодлогын талаасаа ч засгийн газар болон хувийн хэвшлээс хараат бус байх ёстой.
- ОҮИТБС-д оролцож буй иргэний нийгмийн бүлгүүд ямар нэг зохисгүй дарамт шахалт, албадлагагүйгээр үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлнэ.

Хүснэгтийн үзүүлэлт 7: Үзүүлэлтийн үнэлгээний хэрэгсэл

Үзүүлэлт: Уг үйл явцад компаниуд оролцож байна уу?

Зорилго: Энэ үзүүлэлт нь 5 дугаар үзүүлэлтийг бататгаж байна. ОУИТБС-ын шалгуурт компаниуд санаачилгын хэрэгжилтэд идэвхтэй оролцож, бүх компаниуд ОУИТБС-ын дагуу тайлагнахыг шаарддаг. Үүний тулд ОУИТБС-ын хэрэгжилтэд газрын тос, байгалийн хий, уул уурхайн компаниуд идэвхтэй оролцох шаардлагатай болно. Үүнийг олон оролцогч талуудын бүлгээр дамжуулах, эсвэл олон оролцогч талын бүлэгт нэмэлт үүрэг болгох байдлаар гүйцэтгэж болно.

Нотлох баримт: Энэ үзүүлэлтээр үнэлгээ өгөхийн тулд Баталгаажуулагч тухайн засгийн газар болон шаардлагатай тохиолдолд олон оролцогч талуудын бүлгээс ОУИТБС-ын хэрэгжилтийн үйл явцад компаниудыг татан оролцуулахыг эрмэлзэж байгаа эсэхийг нотлох баримт олох хэрэгтэй болно. Үүнд дараахь нотлох баримт орох ёстой:

- Олон оролцогч талуудын бүлгээс газрын тос, байгалийн хий, уул уурхайн компаниудад хандаж тухайн засгийн газар ОУИТБС-ыг хэрэгжүүлэх үүрэг амлалт авсан тухай болон үүнд компаниудын гүйцэтгэх гол үүргийн талаар таниулан сурталчилж байгаа байдал, түүний дотор харилцааны хүрээ (хэвлэл мэдээллийн хэрэгсэл, вэбсайт, албан бичгээр).
- Компаниудад нөлөөлж буй чадавхийн асуудлыг хөндөж шийдвэрлэх талаар засгийн газар, иргэний нийгэм, компаниудаас хэрэгжүүлж байгаа арга хэмжээ.

Хүснэгтийн үзүүлэлт 8: Үзүүлэлтийн үнэлгээний хэрэгсэл

Үзүүлэлт: Засгийн газар ОУИТБС-ын хэрэгжилтэд тулгарч буй аливаа саад тогторыг арилгасан уу?

Зорилго: ОУИТБС-ын хэрэгжилтэд хууль эрх зүй, зохицуулалтын болон бусад саад тогтор учирч байгаа бол тухайн засгийн газар тэдгээрийг арилгах шаардлагатай болно. Ийм нийтлэг саад тогторуудын дотор засгийн газрын болон компаниудын гэрээн дэх нууцлалын заалтууд, засгийн газрын байгууллагуудын мөнгө шилжүүлгийн зөрчилтэй байдал зэрэг асуудал орно.

Нотлох баримт: Энэ үзүүлэлтээр үнэлгээ өгөхийн тулд Баталгаажуулагч тухайн засгийн газар ямар нэг саад тогторыг арилгасан эсэхийг нотлох баримт олох хэрэгтэй болно. Үүнд саад тогторыг урьдчилан үнэлэх идэвхтэй арга, эсвэл үүссэн саад тогторыг тухай бүрт нь арилгах арга хэмжээ авах идэвхгүй арга байж болно. Энэ асуудлыг шийдвэрлэх тогтсон нэг арга гэж байхгүй, улс орнуудын хувьд хэрэгжилтэд нөлөөлж болох эрх зүйн янз бүрийн хүрээ, бусад гэрээнүүд байж болох бөгөөд энэ бүхэнд өөр өөр аргаар хариу үйлдэл үзүүлэх шаардлагатай болно.

Баталгаажуулагчийн олохыг хүсэх нотлох баримтын төрлүүдэд дараахь зүйлс орно:

- Эрх зүйн хүрээний тойм
- Зохицуулалтын хүрээний тойм
- Эрх зүй, зохицуулалтын хүрээнд буй ОҮИТБС-ын хэрэгжилтэд нөлөөлж болохуйц саад тогторуудын үнэлгээ
- Ил тод байдал бий болгоход зориулж дэвшүүлсэн, батлан гаргасан эрх зүй, зохицуулалтын өөрчлөлтүүд
- Орлогоо ил тод тайлagnahыг зөвшөөрөх талаар засгийн газар болон компаниудын хооронд байгуулсан гэрээнүүдэд нууцлалын заалтуудаас татгалзсан байдал
- Ил тод байдлыг нэмэгдүүлэх чиглэлээр, тухайлбал компаниудтай, тогтоосон шууд харилцаа
- Засгийн газар болон компаниудын хооронд хэлэлцэн тохирсон ил тод байдлын стандартууд, зөвшилцлийг зааж өгсөн Ойлголцлын санамж бичиг

Хүснэгтийн үзүүлэлт 9: Үзүүлэлтийн үнэлгээний хэрэгсэл

Үзүүлэлт: Тайлангийн загваруудыг хэлэлцэн тохирсон уу?

Зорилго: Тайлангийн загварууд бол мэдээллийг илээр тайлagnаж, нэгтгэх, ОҮИТБС-ын эцсийн тайланг гаргах үйл явцад гол үүрэг гүйцэтгэдэг. Энэхүү загваруудад орлогын урсгалуудыг засгийн газрын болон компаниудын тайлagnалд оруулах ёстойг тодорхойлно. Уг загваруудыг олон оролцогч талуудын бүлгээр хэлэлцэн батлах шаардлагатай.

ОҮИТБС-ын шалгуурт “засгийн газарт төлж байгаа газрын тос, байгалийн хий, уул уурхайн холбогдолтой бүх материаллаг төлбөрүүд” ба “газрын тос, байгалийн хий, уул уурхайн компаниудаас засгийн газарт хүлээн авсан бүх материаллаг орлогууд”-ыг ил тодоор хэвлэн нийтэлж байхыг шаарддаг. Иймээс ОҮИТБС-ын загваруудад эдгээр материаллаг



төлбөрүүд ба орлогууд юу юунаас бүрдэх, “материаллаг” гэдэгт юу орохыг олон оролцогч талуудын бүлгээр хэлэлцэн тохирсны үндсэн дээр тодорхойлох шаардлагатай болно. Түүнчлэн олон оролцогч талуудын бүлгээс тайлагнаад хамрагдах цаг хугацааны үеүдийг заах зайлшгүй шаардлагатай байх болно. Аливаа орлогын урсгалыг орхигдуулах эсвэл буруу тодорхойлсноор ОҮИТБС-ын эцсийн тайландаа материаллаг байдлаар нөлөө үзүүлэх чадамжтай бол түүнийг материаллаг гэж үзнэ.

Үүнд орлогын дараахь урсгалуудыг оруулах ёстой гэдгийг хүлээн зөвшөөрөх нь нийтлэг байдаг:

- Хүлээн авагч засгийн газраас олгосон үйлдвэрлэлийн эрхийн төлбөр.
- Үндэсний төрийн өмчit компаниудын үйлдвэрлэлийн эрхийн төлбөр.
- Ашгийн татварууд
- Нөөц ашигласны төлбөрүүд
- Ноогдол ашгууд
- Урамшууллууд (гэрээний, орд илрүүлсний, үйлдвэрлэлийн)
- Тусгай зөвшөөрлийн төлбөрүүд, түрээсийн төлбөрүүд, орох хураамжууд болон тусгай зөвшөөрөл болон хөнгөлөлттэй холбоотой бусад асуудлууд
- Газрын тосны ашиг
- Засгийн газарт орж буй, Олон оролцогч талуудын бүлгээр зөвшөөрөгдсөн бусад томоохон ашиг орлогууд

Нотлох баримт: Энэ үзүүлэлтээр үнэлгээ өгөхийн тулд Баталгаажуулагч олон оролцогч талуудын бүлэгт уг загваруудыг боловсруулахад оролцож зөвлөсөн эсэх, олон нийтийн илүү өргөн хүрээг хамарсан санал шүүмжлэл явуулсан эсэх, маягтын эцсийн загварыг олон оролцогч талуудын бүлэг хүлээн зөвшөөрч батласан эсэхийг нотлох баримт олох хэрэгтэй болно. Үүнд дараахь нотлох баримтуудыг оруулж болно:

- Олон оролцогч талуудын бүлэгт өгсөн загваруудын төсөл
- Маягтын загварыг хэлэлцсэн тухай олон оролцогч талт бүлгийн хурлын тэмдэглэл
- Тайлангийн загваруудын талаар олон оролцогч талуудын илүү өргөн хүрээнд (тухайлбал, компаниудад) харилцсан байдал
- Олон оролцогч талуудад холбогдох асуудлуудыг ойлгох боломж олгоход чиглэсэн зохицуулалтууд
- Тайлангийн загварууд ба түүнд орсон бүхий л орлогын урсгалуудыг хүлээн зөвшөөрч олон оролцогч талуудын бүлгээс гаргасан шийдвэр

Хүснэгтийн үзүүлэлт 10: Үзүүлэлтийн үнэлгээний хэрэгсэл

Үзүүлэлт: Тoo баримтуудыг цуглуулж нэгтгэх байгууллагад олон оролцогч талуудын бүлэг сэтгэл ханамжтай байна уу?

Зорилго: Компани болон засгийн газраас тайлагнасан тоо баримтуудыг хүлээн авч, тэдгээрийг нэгтгэх, улмаар ОҮИТБС-ын эцсийн тайланг боловсруулан гаргах ямар нэг байгууллагыг томилох хэрэгтэй болно. Энэ байгууллагыг захиргаа, нэгтгэгч эсвэл аудитор гэх мэт янз бүрээр нэрлэсэн байдаг. Энэ үргийг гүйцэтгэж байгаа байгууллагыг оролцогч талуудын зүгээс найдвартай, итгэл хүлээхүйц, техникийн хувьд чадвартай байгууллага гэж үздэг байх нь амин чухал.

Нотлох баримт: Энэ үзүүлэлтээр үнэлгээ өгөхийн тулд Баталгаажуулагч тоо баримтыг нэгтгэн дүгнэхээр томилогдсон байгууллагад олон оролцогч талуудын бүлэг сэтгэл ханамжтай байгаа эсэхийг нотлох баримт олох хэрэгтэй болно. Үүнд дараахь нотлох баримтууд орж болно:

- Олон оролцогч талуудын бүлгээс зөвшөөрөгдсөн Ажлын даалгаварууд
- Боломжит Баталгаажуулагчийг тогтоохын тулд ОҮИТБС-ын Нарийн бичгийн дарга нарын газар болон Удирдах зөвлөлтэй ил тодоор харилцаж холбоо тогтоосон байдал
- Тухайн байгууллагын эцсийн сонголтыг олон оролцогч талын бүлэг хүлээн зөвшөөрч батласан байдал

Хүснэгтийн үзүүлэлт 11: Үзүүлэлтийн үнэлгээний хэрэгсэл

Үзүүлэлт: Засгийн газраас бүх компаниудад тайлагнах тэгш нөхцлийг хангаж өгсөн үү?

Зорилго: ОҮИТБС-ын шалгуурт улсын (төрийн өмчит), хувийн, гадаад, дотоодын бүх компаниуд засгийн газарт төлж буй төлбөрөө зөвшөөрөгдсөн загваруудын дагуу тайлагнаж, уг тайлагнасан тоо баримтыг нэгтгэн дүгнэхээр томилогдсон байгууллагад хүргүүлэхийг шаарддаг. Ийнхүү бүх компаниуд тайлагнах нөхцлийг хангах үүднээс засгийн газар бүхий л үндэслэлтэй алхмуудыг авч хэрэгжүүлэх шаардлагатай болно. Үүнд сайн дурын гэрээ,

зохицуулалт эсвэл хууль тогтоомж ашиглах явдал орно. Мөн яагаад зарим компаниудыг ойрын хугацаанд тайлагнаанд хамруулж болохгүй тухай (хэдийгээр онцгой тохиолдол мэт боловч) учир шалтгаан байж болохыг энд үгүйсгээгүй. Энэ тохиолдолд дунд хугацаанд эдгээр компаниудыг тайлагналын үйл явцад хамруулах чиглэлд зохих алхамууд хийсэн гэдгийг, эдгээр алхамууд нь бусад компаниудаар хүлээн зөвшөөрөгдөхүйц арга хэмжээ болохыг засгийн газар нотлон харуулах ёстой.

Нотлох баримт: Энэ үзүүлэлтээр үнэлгээ өгөхийн тулд Баталгаажуулагч тухайн засгийн газар дараахь зүйлийг хийсэн эсэхийг нотлох баримтыг олох хэрэгтэй болно:

- Компаниуд ОҮИТБС-ын шалгуурууд болон зөвшөөрөгдсөн тайлангийн загваруудын дагуу заавал тайлагнадаг байх хууль тогтоомж шинээр гаргасан эсвэл ийм нэмэлт өөрчлөлт хийсэн байх.
- Компаниуд ОҮИТБС-ын шалгуурууд болон зөвшөөрөгдсөн тайлангийн загваруудын дагуу заавал тайлагнадаг байх холбогдох зохицуулалтууд шинээр гаргасан эсвэл ийм нэмэлт өөрчлөлт хийсэн байх.
- Бүх компаниуд ОҮИТБС-ын шалгуурууд болон зөвшөөрөгдсөн тайлангийн загваруудын дагуу заавал тайлагнадаг байх нөхцлийг хангахын тулд тэдэнтэй гэрээ хэлэлцээр (ойлголцлын санамж бичиг байгуулах, бүтээгдэхүүн хуваах гэрээний нууцлалын заалтаас татгалзах гэх мэт) хийсэн байх.
- Компаниуд оролцогүй байгаа тохиолдолд эдгээр компаниуд (оролцогч талуудтай) тогтсон өдрөөс 1 хоногийн өмнө тайлагнадаг болгох үүднээс ерөнхийдөө (бусад оролцогч талуудаар) хүлээн зөвшөөрөгдсөн арга хэмжээг засгийн газраас авсан байх.

Хүснэгтийн үзүүлэлт 12: Үзүүлэлтийн үнэлгээний хэрэгсэл

Үзүүлэлт: Компаниудын тайлан олон улсын стандартуудын дагуу аудитлагдсан тоо бүртгэлд тулгуурласан байх нөхцлийг засгийн газар хангаж өгсөн үү?

Зорилго: ОҮИТБС-ын шалгуурт компаниудын тайлагнасан бүх тоо баримтууд олон улсын стандартуудын дагуу аудитлагдсан тоо бүртгэлд тулгуурласан байхыг шаарддаг. Энэ нь ОҮИТБС-ын хэрэгжилтийн нэг чухал бүрэлдэхүүн хэсэг юм.

Нотлох баримт: Энэ үзүүлэлтээр үнэлгээ өгөхийн тулд Баталгаажуулагч тухайн засгийн газраас компаниудын ирүүлж буй тоо баримтууд олон улсын стандартын дагуу аудитлагдсан байх нөхцлийг хангах алхамууд хийсэн тухай нотлох баримтыг олж авах хэрэгтэй болно. Эдгээрт дараахь нотлох баримтууд орж болно:

- Ирүүлж байгаа тоо баримтууд олон улсын стандартад тулгуурласан байхыг шаардсан хууль тогтоомжийг төрөөс гаргах.
- Төр засгаас одоо мөрдөгдөж байгаа аудитын стандартуудыг олон улсын стандарт болгох нэмэлт өөрчлөлт оруулж, компаниудыг тэдгээрт нийцүүлэн ажиллахыг шаардах.
- Засгийн газар бүх компаниутай Ойлголцолын санамж бичиг байгуулж, улмаар компаниуд тоо баримтаа олон улсын стандартуудын дагуу гаргаж ирүүлдэг байхаар тохиролцох.
- Компаниуд олон улсын стандартуудын дагуу аудитлагдсан тоо баримт ирүүлж байх сайн дурын үүрэг хүлээх.
- Компаниуд олон улсын стандартуудын дагуу аудитлагдсан тоо баримт ирүүлэхгүй байгаа тохиолдолд тогтсон хугацааны дараа олон улсын стандартуудыг хангах талаар засгийн газар тухайн компанийтай (түүний дотор төрийн өмчийт үйлдвэрийн газартай) төлөвлөгөө гаргаж ажиллах.
- Нэгтгэлд ирүүлж байгаа тоо баримтууд стандартын дагуу аудитлагдаагүй тохиолдолд түүнийг шийдвэрлэхээр хэлэлцэн тохирсон арга замд олон оролцогч талуудын бүлэг сэтгэл ханамжтай байгаа эсэх.

Хүснэгтийн үзүүлэлт 13: Үзүүлэлтийн үнэлгээний хэрэгсэл

Үзүүлэлт: Засгийн газрын тайлангууд олон улсын стандартуудын дагуу аудитлагдсан тоо бүртгэлд нийцсэн байх нөхцлийг засгийн газар хангаж өгсөн үү?

Зорилго: ОУИТБС-ын шалгуурт засгийн газрын тайлагнасан бүх тоо баримтууд олон улсын стандартуудын дагуу аудитлагдсан байхыг шаарддаг.

Нотлох баримт: Энэ үзүүлэлтээр үнэлгээ өгөхийн тулд Баталгаажуулагч нь засгийн газраас ирүүлж буй тоо баримтуудаа олон улсын стандартуудын дагуу аудитлагдсан байх нөхцлийг хангах алхамууд хийсэн эсэхийг нотлох баримтыг олох хэрэгтэй болно. Үүнд дараах нотлох баримтууд орж болох юм:

- Ирүүлж байгаа тоо баримтууд олон улсын стандартад нийцсэн байхыг шаардсан хууль тогтоомжийг төрөөс гаргах.
- Төр засгаас одоо мөрдөгдөж байгаа аудитын стандартуудыг олон улсын стандарт болгох нэмэлт өөрчлөлт оруулж, тэдгээрт нийцүүлэн ажиллах нөхцлийг бүрдүүлэх.
- Нэгтгэлд ирүүлж байгаа тоо баримтууд стандартын дагуу аудитлагдаагүй тохиолдолд түүнийг шийдвэрлэхээр хэлэлцэн тохирсон арга замд олон оролцогч талуудын бүлэг сэтгэл ханамжтай байгаа эсэх.

Хүснэгтийн үзүүлэлт 18: Үзүүлэлтийн үнэлгээний хэрэгсэл

Үзүүлэлт: ОҮИТБС-ын тайланг

- нийтэд хүртээмжтэй,
- дэлгэрэнгүй,
- ойлгомжтой байдлаар олон нийтийн хүртээл болгосон уу?

Зорилго: Эцэстээ ОҮИТБС-ын тайлан нийтийн хүртээл болж, түүнийг өргөнөөр түгээн дэлгэрүүлж, янз бүрийн оролцогч талууд нээлттэй хэлэлцдэг болсон үед ОҮИТБС бүрэн дүүрэн хэрэгжих юм. ОҮИТБС-ын шалгуурт уг тайланг нийтэд хүртээмжтэй, дэлгэрэнгүй, ойлгомжтой байдлаар олон нийтийн хүртээл болгохыг шаарддаг.

Нотлох баримт: Энэ үзүүлэлтээр үнэлгээ өгөхийн тулд Баталгаажуулагч нь засгийн газар уг тайланг ОҮИТБС-ын шалгууруудад нийцсэн байдлаар олон нийтийн хүртээл болгох нөхцлийг хангасан эсэхийг нотлох баримтыг олох хэрэгтэй болно. Үүнд:

- Тайланг цаасан дээр хэвлэн гаргаж, иргэний нийгэм, компаниуд, хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон бусад оролцогч талуудын өргөн хүрээг хамруулан тараах.
- Тайланг онлайн хэлбэрээр байрлуулж, вэб хуудасныхаа хаягыг гол оролцогч талуудад мэдээлж сурталчиллах.
- Тайлан дэлгэрэнгүй байх, түүний дотор баталгаажуулалтын явцад цуглуулсан бүх мэдээлэл, санаачилгыг сайжруулах бүх санал зөвлөмжүүдийг багтаасан байх, нөхцлийг хангах.
- Тайлан ойлгомжтой байх, түүний дотор тодорхой, хүртээмжтэй хэлбэрээр, зохих хэлүүд дээр бичигдсэн байх нөхцлийг хангах.
- Тайлангийн тухай мэдээллийг түгээн дэлгэрүүлэх үүднээс олон нийтэд сурталчиллах үйл ажиллагааг (засгийн газар, иргэний нийгэм, компаниудын зүгээс) зохион явуулсан байх.

7. Компанийн маягтууд

Хүснэгтийн үзүүлэлт: Үзүүлэлтийн үнэлгээний хэрэгсэл

Үзүүлэлт: Газрын тос, байгалийн хий, уул уурхайн компаниуд ОҮИТБС-ыг хэрхэн дэмжиж байна вэ?

Зорилго: ОҮИТБС-ын Зарчмууд ба Шалгууруудын дагуу, ОҮИТБС-ыг хэрэгжүүлэгч орнуудын холбогдох салбарт ажиллаж байгаа бүх компаниуд засгийн газарт төлж буй төлбөрүүдээ тайлангийн зөвшөөрөгдсөн загваруудын дагуу тайлагнаж, ОҮИТБС-ын хэрэгжилтийг дэмжих шаардлагатай. Үүнд: тус санаачилгыг нийтээр дэмжиж байгаагаа илэрхийлэх, олон оролцогч талт үйл явцад оролцох буюу дэмжлэг үзүүлэх, олон улсын сатандартуудын дагуу аудитлагдсан зөвшөөрөгдсөн тоо баримтуудыг тайлагнах, Баталгаажуулагч компанийн маягтуудтай холбоотой тодруулга хийх шаардлагатай үед түүнтэй хамтарч ажиллах зэрэг орно.

Нотлох баримт: Энэхүү үзүүлэлтэд Баталгаажуулагч ерөнхий үнэлгээ өгөхийг шаарддаггүй. Компани бүр өөрийгөө үнэлэх компанийн маягтуудыг (дор дурдсан) бөглөх шаардлагатай бөгөөд Баталгаажуулагч ОҮИТБС-ын Баталгаажуулалтын тайландаа тэдгээрт тулгуурлан бичгээр үнэлгээ өгөх ёстой. Компаниуд өөрийн үнэлгээний маягтуудаа бөглөж ирүүлээгүй бол Баталгаажуулагч энэ тухай эцсийн тайландаа дурдах ёстой. Түүнчлэн, Баталгаажуулагч тухайн компанийн талаар холбогдох мэдээллийг олон нийтийн мэдээллийн хэрэгслийдээс авч эцсийн тайландаа тусгах ёстой. Тухайн компанийд энэхүү мэдээллийг шалгах боломж олгоно. Уг маягтуудыг ОҮИТБС-ын тайландаа компанийн гүйцэтгэлийг нэгтгэн дүгнэхэд ашиглахын зэрэгцээ маягтуудыг нийтийн хүртээл болгож, компанийн өгсөн хариултуудыг зэрэгцүүлэн харьцуулсан хүснэгтийг ОҮИТБС-ын тайландаа оруулсан байх ёстой.

Баталгаажуулагч ажлаа эхлэхдээ юуны өмнө маягтуудыг бөглөх шаардлагатай компаниудтай холбоо барьж, уг маягтыг бөглөх тухай танилцуулаад бөглөсөн маягтыг Баталгаажуулагчид буцааж өгөхийг хүснэ. Мөн Баталгаажуулагч компанийн хэрэгжүүлэлтийн явцад олж мэдсэн сургамж, тэргүүн туршлагынхаа талаар санал шүүмжлэл ирүүлэхийг хүсэх ёстой. Компаниуд санал шүүмжлэлээ дараахь хоёр арга замаар илэрхийлж болно:

- Компаниуд өөрийгөө үнэлэх маягтад тусгайлан гаргасан зайлгаж болно;
- Тухайн компанийн талаар онцлохыг хүсч буй асуудлууд эмзэг шинжтэй тохиолдолд нотлох баримтыг Баталгаажуулагчид амаар өгч болно. Баталгаажуулагч уг сургамж, туршлагуудыг Баталгаажуулалтын тайландаа компанийн нэргүйгээр нэгтгэн оруулна.

Өөрийгөө үнэлэх маягтуудыг компаниуд эхний ээлжинд дараахь байдлаар бөглөх ёстай:

Улс орны түвшинд:

- Тухайн баталгаажуулалт хийлгэж байгаа улс оронд ажиллаж байгаа газрын тос, байгалийн хий, уул уурхайн компани бүр улсын түвшний Компанийн маягтын дагуу өөртөө үнэлгээ хийж, бөглөсөн маягтыг Баталгаажуулагчид буцааж өгөх ёстай.
- Үндэсний хэмжээний Баталгаажуулагч хариултуудыг цуглуулж нэгтгэх бөгөөд хэрэв нэмэлт асуулт асуух эсвэл нэмэлт мэдээлэл авах шаардлагатай бол тухайн компаниудтай холбоо барьж болно. Компаниуд ийм хүсэлтүүдэд нааштайгаар хандаж хариулах ёстай.
- Компаниуд бөглөсөн маягтуудаа үйл ажиллагаа явуулж буй орон бүрээр гадаад вэбсайтууд дээрээ байрлуулах ёстай.

Олон улсын түвшинд:

- ОҮИТБС-ыг дэмжих олон улсын үүрэг хүлээсэн компаниуд олон улсын түвшний өөрийгөө үнэлэх маягтыг бөглөх ёстай.
- Олон улсын түвшний Компаний маягтуудыг дээрх компани бүр бөглөх бөгөөд түүнийгээ ОҮИТБС-ын Нарийн бичгийн дарга нарын газарт ирүүлж, ОҮИТБС-ын вэбсайтад тавиулах ёстай.
- Түүнчлэн компаниуд ОҮИТБС-ыг баталсан тухай өөрсдийн вэбсайт дээр тодорхой тавьж танилцуулна.

ОҮИТБС-ЫН КОМПАНИЙН БАТАЛГААЖУУЛАЛТЫН МАЯГТ

Улс орны түвшин		
КОМПАНИ:	УЛС:	
Доорх үзүүлэлтүүдийг ✓ -р тэмдэглэнэ үү.		Тийм Үгүй
<ol style="list-style-type: none"> Тухайн компани тус улсад ОҮИТБС-ыг дэмжин ажиллах талаар олон нийтэд хандсан мэдэгдэл хийсэн үү? Тухайн компани (олон оролцогч талуудын бүлгээр хэлэлцэн тохирсны дагуу) энэ Улсын ОҮИТБС-ЫН Үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх, хамтран ажиллах, түүний дотор засгийн газраас гаргасан ОҮИТБС-тай холбоотой заавар удирдамжийг (хууль, ойлголцлын санамж бичиг гэх мэт) дагаж мөрдөх, шаардлагатай үед холбогдох оролцогч талуудтай уулзах талаар үүрэг хүлээсэн үү? Тоо баримтуудыг нэгтгэх, ОҮИТБС-ЫН тайлан гаргах гэрээт үүрэгтэй байгууллагад ОҮИТБС-ЫН тайлангийн зөвшөөрөгдсөн загварууд, тогтсон хуваарийн дагуу бүх материаллаг төлбөрүүдээ тайлagnаж хүргүүлсэн үү? Тоо баримтуудыг нэгтгэх, ОҮИТБС-ЫН тайлан гаргах гэрээт үүрэгтэй байгууллагад илгээсэн тоо баримтуудаа олон улсын стандартуудын дагуу хараат аудитлагдсан тоо бүртгэлээс авсан уу? Тоо баримтуудыг нэгтгэх, ОҮИТБС-ЫН тайлан гаргах гэрээт үүрэгтэй байгууллагаас ОҮИТБС-ЫН тайлангийн загваруудын дагуу тухайн улсад төлсөн төлбөрүүдийг засгийн газрын хүлээж авсан орлоготой харьцуулж нэгтгэх хүсэлт тавихад тус компани хариу өгсөн үү? 		
Ерөнхий үнэлгээ (дээрх үзүүлэлтүүдийн)	Тийм	Үгүй
Санал бодол		
Хэрэв дээрх үзүүлэлтүүдийн аль нэгд “үгүй” гэж тэмдэглэсэн бол түүнийгээ тайлбарлана уу?		
Өөр ямар нэг санал шүүмжлэл байна уу?		

Олон улсын түвшин

КОМПАНИ:

Доорх үзүүлэлтүүдийг ✓-р тэмдэглэнэ үү.	Тийм	Үгүй
<p>1. Тус компани ОҮИТБС-ын Зарчмууд ба Шалгууруудыг зөвшөөрөн баталсан тухай тодорхой мэдэгдэл гаргаж нийтэлсэн үү, үүнийгээ гадаад вэбсайт дээрээ тавьж олон нийтийн хүртээл болгосон уу?</p> <p>2. Тус компани хэрэв хамааралтай бол (өөрөөр хэлбэл, дор хаяж нэг удаа баталгаажуулалт хийлгэсэн ОҮИТБС-ыг хэрэгжүүлэгч оронд явуулж байгаа үйл ажиллагааныхаа хувьд) гадаад вэбсайт дээрээ өөрсдийн бөглөсөн Компанийн маятуудад хандах холбоосыг зааж өгсөн үү?</p> <p>3. Тус компани ОҮИТБС-ын хувьд хүлээх стратегийн үүрэг хариуцлагаа компанийхаа удирдлагуудын нэгэнд хариуцуулж, тухайн компаний ОҮИТБС-ын бодлого, дэмжих үйл ажиллагааны талаар мэдээлж, ОҮИТБС-ын оролцогч талуудаас ирүүлсэн асуултад хариулах үүрэг бүхий хүнийг томилсон уу?</p> <p>4. Хэрэв тухайн баталгаажуулалт хийлгэх хугацаанд ОҮИТБС-ын Бага хурал зохиогдсон бол компаний дээд удирдлагуудын хэн нэг гишүүн оролцсон, эсвэл дэмжих мэдэгдэл илгээсэн үү?</p> <p>5. Компани хэрвээ дэлхий нийтийн тогтвортой байдлын тайлан, эсвэл корпорацийн хариуцлагын тайлан гаргадаг бол түүндээ ОҮИТБС-д оруулж буй хувь нэмрээ нэгтгэн оруулж, гадаад вэбсайтдаа байрлуулсан уу?</p>		
	Тийм	Үгүй
Ерөнхий үнэлгээ (дээрх үзүүлэлтүүдийн)		
Санал бодол		
Хэрэв дээрх үзүүлэлтүүдийн аль нэгд “үгүй” гэж тэмдэглэсэн бол түүнийгээ тайлбарлана уу?		
Өөр ямар нэг санал шүүмжлэл байна уу?		

8. Дүгнэх үзүүлэлтүүд

Хүснэгтийн үзүүлэлт: Үзүүлэлтийн үнэлгээний хэрэгсэл

Үзүүлэлт: Хэрэгжилтийн явцад авсан сургамжуудаас суралцах, зөрүүтэй байдлыг шийдвэрлэх, ОҮИТБС-ыг цаашид тогтвортой хэрэгжүүлэх талаар ямар алхамууд хийгдээд байна вэ?

Зорилго: ОҮИТБС-ын тайланг гаргаж, түгээн дэлгэрүүлснээр ОҮИТБС-ын хэрэгжилт дуусахгүй. Түүний үнэ цэнэ гаргаж байгаа бүтээгдэхүүн төдийгүй өрнөж буй үйл явцаас үүдэн гарах бөгөөд хэрэгжүүлэлтээс олж авсан сургамжуудын дагуу арга хэмжээ авах, ОҮИТБС-ын тайлангаар илэрсэн зөрүүтэй байдлыг арилгаж шийдвэрлэх, ОҮИТБС-ын хэрэгжилтийг тогтвортой үргэлжлүүлэн хэрэгжүүлэх үндэс суурийг тавих явдал амин чухал.

Нотлох баримт: Баталгаажуулагч дээр дурдсан зорилтуудыг анхааралдаа авч дүгнэлт хийх механизм бий болсон эсэхийг нотлох баримтыг олох хэрэгтэй болно. Баталгаажуулагч энэ тухай санал шүүмжлэлээ Баталгаажуулалтын тайландаа оруулах ёстой.

Хавсралт Б: Баталгаажуулагчийн Ажлын даалгавар

Энэхүү Ажлын даалгавруудад Баталгаажуулагчид шаардагдах гол ур чадварууд, үндсэн үүрэг хариуцлагыг тодорхойлохыг эрмэлзэнэ.

ОҮИТБС-ын Баталгаажуулагч

1.1 ОҮИТБС-ын Баталгаажуулагч нь аливаа улс амласнаа үнэхээр хийж байгаа эсэхийг тодорхойлох үүрэгтэй байна. Энэ хүрээнд, тухайн улсад үйл ажиллагаа явуулж буй компаниуд ч бас үүргээ гүйцэтгэж байгаа эсэхийг Баталгаажуулагч хэлж чаддаг байх шаардлагатай.

1.2 “Хийж байна гэдэг хэлснээ хийх” хэмээх хэлц үгийг энд зориуд хэрэглэж байна. ОҮИТБС-ын Баталгаажуулалт гэдэг бол зүгээр нэг хар-цаагаан үйл явц биш. Дагаж мөрдөгч орны үнэлгээнд тэнцсэн, эсвэл тэнцээгүй гэсэн үнэлгээг хариуцлагатай хэрэглэдэг бол хараахан бүрэн хэрэгжүүлэхэд шаардлагатай тогтолцоог бий болгоход олон сарын хугацаа шаардагддаг бол олон орны хувьд хэдэн жил зарцуулдаг. Баталгаажуулалт нь ахиц дэвшлийг төдийгүй үнэмлэхүй амжилтыг ч бас тодорхойлох ёстой гэдэгтэй Олон Улсын Зөвлөлдөх Бүлэг санал нэг байна.

1.3 Олон Улсын Зөвлөлдөх Бүлгээс баталгаажуулалтад баримтлах багц зарчмыг дараахь байдлаар тогтоосон:

- ОҮИТБС-ын баталгаажуулалт нь ОҮИТБС-ын хэрэгжилтэд голлон анхаарахаас, ил тод байдлын бусад бодлогуудад чиглэхгүй.
- Баталгаажуулалт нь улс орнуудын хооронд харьцуулан жиших боломж олгох үүднээс дэлхий нийтийн нийтлэг нэг стандартад тулгуурласан байна.
- Уг үйл явцыг улс орнууд өөрийн болгохыг хичээх, тухайн улсын ОҮИТБС-ыг хэрэгжүүлэх өвөрмөц онцлогыг тусгана.
- Уг үйл явцад олон оролцогч талуудын оролцоог хангана.
- Уг үйл явц нь цомхон байх, хэрэгцээгүй хүнд суртал бий болгох ёсгүй. Одоо байгаа байгууллага, чадавхид аль болох тулгуурлана.
- Уг үйл явц нь шүүмжлэлээс илүү бүтээлч санал зөвлөмжийг чухалчилна.
- Баталгаажуулагч нь ОҮИТБС-ын талаар хангалттай мэдлэг, боловсрол, туршлагатай байх ёстой.
- Баталгаажуулагч нь үүргээ үр дүнтэй биелүүлэх хангалттай чадавхитай (тухайлбал, боловсон хүчний талаасаа) байх ёстой.
- Ахиц дэвшлээс гадна үнэмлэхүй ололт амжилтыг хүлээн зөвшөөрнө.

1.4 Баталгаажуулалт бол санхүүгийн аудит биш юм. Баталгаажуулагчийн ажил үүрэг бол улс орнууд болон компаниудаас амласан зүйлээ хийж гүйцэтгэж байгаа эсэхийг шалгах явдал юм. Баталгаажуулагч нь санхүүгийн аудит хийхийг эрмэлзэхгүй.

Юуг баталгаажуулах вэ?

2.1 Баталгаажуулалт хийх хоёр нөхцөл байна:

- ОҮИТБС-ыг хэрэгжүүлэх, түүний дотор иргэний нийгэм, компаниудтай хамтарч ажиллах, удирдах хүнийг томилох, холбогдох оролцогч талуудтай хамtran Үйл ажиллагааны төлөвлөгөө гаргах үүрэг хүлээсэн боловч ОҮИТБС-ын тайлан гаргаж, түүнийг түгээн дэлгэрүүлж, мэтгэлцээн өрнүүлэх шатанд хараахан хүрээгүй улс орон байна. Энэ тохиолдолд Баталгаажуулагч тухайн улсын хүрсэн ахиц дэвшлийн шатанд үнэлгээ өгч, тухайн улс (засгийн газар) амласнаа хийж буй эсэхийг баталгаажуулна. Ийм улс орныг ОҮИТБС-ын Нэр дэвшигч орон гэдэг.
- ОҮИТБС-ыг хэрэгжүүлэх үүрэг хүлээсэн бөгөөд ОҮИТБС-ын тайлан гаргаж, түүнийгээ хэвлэн, түгээн дэлгэрүүлж, мэтгэлцээн өрнүүлж байгаа улс орон байна. Энэ тохиолдолд Баталгаажуулагч тухайн улсад байдал үнэхээр тайланд дурдсан хэмжээнд байгаа эсэхийг шалгах, тайлангаа ОҮИТБС-ын Шалгууруудад нийцүүлэн гаргасан эсэхэд үнэлгээ өгнө. Хэрвээ тухайн улс үнэхээр амласнаа биелүүлж, түүнийгээ тавигдсан шалгууруудад нийцүүлэн гүйцэтгэж байгаа бол Баталгаажуулагч тухайн орныг ОҮИТБС-ыг “хэрэгжүүлж байна” хэмээн баталгаажуулна. Ийм улс орныг ОҮИТБС-ын Дагаж мөрдөгч орон гэдэг.

ОҮИТБС-ын Баталгаажуулагчид тавигдах мэдлэг, ур чадварын шаардлага

3.1 Баталгаажуулагч нь хариуцсан ажиллагаагаа явуулахад хэд хэдэн ур чадвар, мэдлэг туршлагыг эзэмшсэн байх шаардлагатай. Баталгаажуулагчийн эзэмшсэн байвал зохих хамгийн гол ур чадвар нь:

- Санхүүгийн техник ур чадвар: олон улсын аудитын стандартууд, хувийн хэвшлийн аудитын тайлангууд, засгийн газрын аудитын тайлангууд, төрийн санхүүгийн удирдлагын мэдлэг байна.

Түүнчлэн Баталгаажуулагч (баталгаажуулалтын багийн гишүүд) дараахь чадварыг эзэмшсэнээ үйл ажиллагаандaa харуулах хэрэгтэй:

- Хөгжлийг удирдах ажлын туршлага, иргэний нийгэмтэй ажиллах мэдлэг, түүний дотор иргэний нийгэм засгийн газрын дарамт шахалтад орж болзошгүй хүнд орчин нөхцөлд ажилласан туршлагатай байх.
- Итгэл хүлээх чадвар: тухайн Баталгаажуулагч нь хүлээн авагч засгийн газар, хувийн хэвшил, иргэний нийгмийнхэний итгэлийг хүлээх чадвартай байх.
- Баталгаажуулагч нь ОҮИТБС-ын талаар шаардагдах мэдлэг боловсрол, дадлага туршлагатай байх.
- Баталгаажуулагч нь энэ үргийг үр нөлөөтэй биелүүлэх хангалттай чадавхитай (тухайлбал, боловсон хүчний) байх.

- Баталгаажуулагч нь санал зөрөлдөөнөөс урьдчилан сэргийлэх, шаардлагатай тохиолдолд маргааныг шийдвэрлэх өндөр зэрэглэл, хангалттай ур чадвартай байх.

3.2 Баталгаажуулагч нь ур чадвар, мэдлэг туршлага бүхий хэд хэдэн найдвартай хүнээс бүрдсэн байна. Эдгээр нь олон улсын аудитын компани гэх мэт нэг пүүс компанийн мэргэжилтнүүд, эсвэл зохих ур чадвар, туршлагатай хэд хэдэн тусдаа хүнээс бүрдсэн байж болох юм. Ийм тохиолдолд нэг хүн эсвэл нэг пүүс компани нь уг үйл явцыг удирдаж, ерөнхий хариуцлагыг хүлээх нь чухал.

3.3 Үнэлгээний байж болох багууд:

- Олон улсын зөвлөх болон аудитын пүүс компаниас сонгогдсон баг.
- Олон улсын зөвлөх болон аудитын пүүс компани хариуцан гадны мэргэжилтнүүдээс сонгон авч нэгтгэсэн баг.
- Тэтгэвэрт гарсан ахмад улс төрч, нэр хүнд бүхий хуульч, эсвэл төрийн албан хаагч гэх мэт итгэл хүлээж чадах олон улсад нэр хүндтэй хүмүүсийн нэгдсэн баг.

3.4 Баталгаажуулагч нь санал болгосон багийн бүх гишүүдийнхээ нэрсийн жагсаалтыг Удирдах зөвлөлд танилцуулж батлуулах үүрэгтэй.

3.5 Баталгаажуулагч үйл ажиллагаагаа явуулж эхлэхээс өмнө төсвийн төслөө Удирдах зөвлөлд танилцуулж батлуулах ёстой.

Баталгаажуулалтын үйл явц (дэлгэрэнгүйг Баталгаажуулалтын удирдамжаас үзнэ үү)

4.1 Хамгийн эхний алхам бол олон оролцогч талуудын бүлгээс Баталгаажуулагчыг сонгож томилох явдал юм. Сонгогдсон баталгаажуулагч нь турван үндсэн баримт бичигт тулгуурлан ажлаа явуулна. Эдгээр нь:

- Тухайн улсын Үйл ажиллагааны төлөвлөгөө
- Баталгаажуулалтын хүснэгт болон Үзүүлэлтийн үнэлгээний холбогдох хэрэгсэл
- Компаний өөрийгөө үнэлэх Маягууд болно.

4.2 Тухайн баталгаажуулагч эдгээр баримт бичгүүдийг ашиглан олон оролцогч талуудын бүлэг, компаниуд болон засгийн газраас гаргаж өгсөн тоо баримтыг нэгтгэх үүрэгтэй байгууллага, бусад гол оролцогч талууд (туүний дотор олон оролцогч талуудын бүлэгт ороогүй компаниуд, иргэний нийгмийнхэн)-тай уулзаж ярилцана.

4.3 Баталгаажуулагч цуглуулсан мэдээллээ ашиглан тайлан гаргана. Тайланд дараахь зүйлсийг багтаасан байна:

- Гарсан ахиц дэвшлийг тухайн улсын Үйл ажиллагааны төлөвлөгөөтэй харьцуулсан товч тайлан
- Гарсан ахиц дэвшлийг Баталгаажуулалтын хүснэгтийн үзүүлэлтүүдтэй харьцуулсан товч тайлан
- Бүрэн бөглөсөн Баталгаажуулалтын хүснэгт
- Компанийн хэрэгжилтийн тайлан
- Харьцуулж нэгтгэсэн компанийн маягтууд
- **ОҮИТБС-ын хэрэгжилтийн ерөнхий үнэлгээ: тухайн улс Нэр дэвшигч орон уу, Дагаж мөрдөгч орон уу, аль эсвэл ямар нэг бодитой ахиц дэвшил гараагүй байна уу?**

4.4 Уг тайланд хэрэгжилтийн явцад авсан сургамжууд, түүнчлэн хүмүүсээс илэрхийлсэн санаа зовоосон асуудлууд, ОҮИТБС-ын цаашдын хэрэгжилтэд зориулсан санал зөвлөмжүүдийг тусгана.

4.5 Энэхүү тайлан эхлээд тухайн улсын олон оролцогч талуудын бүлэг, засгийн газарт болон ОҮИТБС-ын Удирдах зөвлөлд очих ёстой. Хэрвээ эдгээр субъектууд тухайн Баталгаажуулалтын тайлангийн агуулгад сэтгэл ханамжтай байвал түүнийг хэвлэн нийтэлж, холбогдох дүгнэлт, дагалдах арга хэмжээний саналуудыг гаргана. Тайланг англи хэл дээр болон дотоодын хэлүүдээр хэвлэж олон нийтийн хүртээл болгох ёстой.

4.6 Баталгаажуулалтын үйл явцтай холбоотой ямар нэг санал зөрөлдөөн гарвал түүнийг эхний ээлжинд Баталгаажуулагч дотооддоо хэлэлцэн шийдвэрлэнэ. Ноцтой санал зөрчилдөөн, зөрчил маргаан гарсан тохиолдолд ОҮИТБС-ын Удирдах зөвлөлд хандана.

Хавсралт В: ОҮИТБС-ын Удирдах зөвлөлийн Ажлын даалгавар

ОҮИТБС-ын цаашдын үйл ажиллагааг, түүний дотор ОҮИТБС-ын Нарийн бичгийн дарга нарын газрын үйл ажиллагааг удирдан чиглүүлэх Удирдах зөвлөл байгуулахыг ОУЗБ зөвлөмж болгож байна. Энэ нь ОҮИТБС-ыг хэрэгжүүлэгч орнууд, дэмжигч компаниуд, компаниудын холбоод, дэмжигч орнууд, хөрөнгө оруулагчид, иргэний нийгмийн байгууллагуудын төлөөлөгчдөөс бүрдсэн байна. Тус зөвлөл нь ОҮИТБС-ын ерөнхий хөгжил, стратегийн чиглэл, итгэл хүлээх чадварыг удирдан чиглүүлэх үүрэгтэй. ОҮИТБС-ын Бага хуралд зориулж бичгээр тайлан бэлтгэх тулгамдсан асуудлуудын талаар санал зөвлөмж гаргаж, Бага хурлаар хэлэлцүүлнэ. Мөн Удирдах зөвлөл нь ОҮИТБС-ын Нарийн бичгийн дарга нарын газрын үйл ажиллаагааг хянаж, удирдан чиглүүлнэ.

Удирдах зөвлөлийн эдгээр Ажлын даалгавруудыг 2006 оны ОҮИТБС-ын Бага хурлын дараа томилогдох Удирдах зөвлөлийн анхны хурлаар хэлэлцэн эцэслэн шийдвэрлэнэ.

1. Удирдах зөвлөлийн үндсэн чиг үүргүүд

i) Бодлогын ерөнхий болон урган гарсан тусгай асуудлуудыг авч хэлэлцэх

Удирдах зөвлөл нь ОҮИТБС-д нөлөөлөх бодлогын асуудлуудыг авч хэлэлцэхэд гол үүрэг гүйцэтгэнэ. Удирдах зөвлөл явц дунд урган гарсан бодлогын асуудлуудыг авч хэлэлцэн шийдвэр гаргах бөгөөд эдгээр бодлогын гол асуудлуудад тулгуурлан ОҮИТБС-ын Бага хурлаар хэлэлцэх санал зөвлөмжүүдийг бэлтгэнэ. Мөн тус зөвлөл ОҮИТБС-ын Бага хурлаас дэвшүүлэн гаргасан асуудлуудыг авч хэлэлцэх шаардлагатай болно. Жишээлбэл, 2006 оны ОҮИТБС-ын Бага хурлын дараа ОУЗБ-ээс нээлттэй орхисон олон улсын удирдлага зохицуулалтын асуудлуудаар Удирдах зөвлөл хэлэлцүүлэг явуулж, санал дүгнэлт гаргах болно.

ii) Нарийн бичгийн дарга нарын газрын үйл ажиллагааг удирдан чиглүүлэх

ОҮИТБС-ын өдөр тутмын үйл ажиллагааг явуулах, оролцогч талуудтай харилцах үүрэг бүхий ОҮИТБС-ын Нарийн бичгийн дарга нарын газар байгуулагдаад байна. Тус газар нь гол холбоо харилцааг тогтоох үйл ажиллагааг уялдуулах, нийтэд сурталчилах, мэдээлэх хөтөлбөр хэрэгжүүлэх замаар орлогын ил тод байдлын үзэл баримтлалыг төдийгүй ОҮИТБС-ыг дэлхий нийтээр авч хэрэглэж, хэрэгжүүлэх асуудлыг хөхүүлэн дэмжих талаар Удирдах зөвлөлийн дарга, гишүүдтэй хамтран ажиллана.

Удирдах зөвлөл нь Нарийн бичгийн дарга нарын газрын ажлыг удирдан чиглүүлнэ. Удирдах зөвлөлийн гишүүд нь тодорхой бодлогын асуудлуудаар, түүний дотор судалгаа явуулах холбогдох асуудлаар Нарийн бичгийн дарга нарын газраас зөвлөгөө авах хүсэлтийг хувиараа болон хамтдаа тодорхой үндэслэлтэйгээр тавьж болно.

iii) Хэрэгжүүлэгч орнууд болон дэмжигч компаниудын ОҮИТБС-ын байдалд үнэлгээ өгөх

Үүнд Баталгаажуулагчдын нэrsийн жагсаалтыг (Нарийн бичгийн дарга нарын газраас бэлтгэсэн) батлах, баталгаажуулалтын тайланг хүлээн зөвшөөрөх, ОҮИТБС-ыг хэрэгжүүлэгч бус орнуудад үнэлгээ өгөхөд хяналтын болон эцсийн арбитрийн үүрэг гүйцэтгэх явдал орно.

Арбитрийн үүргийн тухайд Удирдах зөвлөл Баталгаажуулагчдын бие даасан шийдвэрт голдуу найдах ёстой. Гэхдээ онцгой тохиолдолд Баталгаажуулагчийн санал зөвлөмжийг давж шийдвэр гаргах эрхтэй. Ийм нэхцэл байдалд Удирдах зөвлөл ямар нэг улсын тухай авч хэлэлцэхдээ хэлэлцүүлэгт ашиг сонирхолын зөрчилтэй гишүүд оролцохоос татгалзах (магадгүй орлох хүнээ нэр дэвшүүлэх) боломж олгоно.

iv) Хоёр жил тутмын ОҮИТБС-ын Бага хуралд зориулсан тайлан бэлтгэх

Удирдах зөвлөл нь Нарийн бичгийн дарга нарын дэмжлэгтэйгээр ОҮИТБС-ын Бага хурлаар хэлэлцэх тайланг бэлтгэн гаргана. Үүнд ОҮИТБС-ын цаашдын хөгжилд нөлөөлж буй бодлогын гол асуудлуудыг авч үзэж, санал зөвлөмж гаргах, ОҮИТБС-ын Нэр дэвшигч болон Дагаж мөрдөгч орнуудад гарч буй ахиц дэвшлийг тайлагнах явдал орно.

2. Дэд бүлгүүдийг ажиллуулах

Удирдах зөвлөл нь цаашид тодорхой асуудлуудыг хэлэлцэх дэд бүлгүүд байгуулах талаар авч үзэж болно. Байгуулагдсан аливаа дэд бүлгийн гол зорилго нь ОҮИТБС-ын Удирдах зөвлөлийн олон оролцогч талт бүтцийг аль болох үндэслэлтэйгээр тусгахад чиглэгдэх ёстой. Дэд бүлгүүдийг Удирдах зөвлөлийн гишүүд даргалж Нарийн бичгийн дарга нарын газраас дэмжлэг үзүүлнэ. Эдгээр дэд бүлгүүдэд Олон улсын санхүүгийн холбогдох байгууллагууд ч төлөөлөлтэй байж болох юм.

3. ОҮИТБС-ын Удирдах зөвлөлөөс Олон хандивлагчийн итгэлцэлийн сангийн Зохицуулах хороотой хамтран ажиллах

ОҮИТБС-ыг хэрэгжүүлэхийг хүсч буй орнуудад санхүүгийн дэмжлэг үзүүлэх зорилготой Олон хандивлагчийн итгэлцэлийн сан (ОХИС) байгуулагдсан. Уг санг Дэлхийн Банк удирдан ажиллуулдаг. Дэлхийн Банк болон уг ОХИС-д 500.000 ам.доллараас дээш хандив өргөөд байгаа засгийн газруудаас бүрдсэн Зохицуулах хорооноос ОХИС-ийн Үйл ажиллагааны төлөвлөгөөг баталдаг. Удирдах зөвлөл, уг Зохицуулах хороо хоёрын хооронд Ойлголцолын санамж бичиг байгуулж ажиллах санал гараад байгаа.

4. Удирдах зөвлөлийн даргын үүрэг

Удирдах зөвлөлийн дарга нь Удирдах зөвлөлийн болон Бага хурлын хуралдаан хэлэлцүүлгийг удирдаж зөвлөлийн гишүүд болон гол оролцогчид, түүний дотор засгийн газрууд, компаниуд, иргэний нийгэм, хөрөнгө оруулагчид, олон улсын байгууллагуудын хоорондын харилцаа хамтын ажиллагааг хадгалахыг эрмэлзэж ажиллана. Дарга нь Удирдах зөвлөлийн санал өгөх эрхтэй гишүүний нэг байна. Хэрвээ санал хураалтын журам ашиглахаар болсон бол гишүүдийн санал тэнцсэн тохиолдолд санал өгч хагалах ёстой.

Дарга нь:

- ОҮИТБС-ын Бага хуралд Удирдах зөвлөлийн тайланг танилцуулах;
- Тус санаачилгын олон оролцогч талт чанар хадгалагдаж, бүх шатны ОҮИТБС-д тусгалаа олж байх нөхцлийг бүрдүүлэх;
- Орлогын ил тод байдлыг цаашид дэлхий нийтээр мөрдөх, үүнд засгийн газрууд, компаниуд, бусад байгууллагуудаас шаардлагатай санхүүжилтийг татан оруулах үзэл санаатайгаар ОҮИТБС-ыг улс төр, бизнесийн ертөнцийн дээд түвшинд төлөөлөх;
- Нарийн бичгийн дарга нарын газарт стратегийн заавар удирдамж өгөх ёстой.

Удирдах зөвлөлийн дарга нь Удирдах зөвлөлийн гишүүд, бусад холбогдох талуудын дэмжлэгтэйгээр Нарийн бичгийн дарга нарын газрын тэргүүнийг томилж, удирдах, үйл ажиллагааны удирдамжаар хангаж, гүйцэтгэлийг Үйл ажиллагааны батлагдсан төлөвлөгөөтэй уялдуулан дүгнэх үүрэгтэй.

Дарга нь Удирдах зөвлөлөөр хэлэлцэх, батлуулах шаардлагатай асуудлуудаар зөвлөлийн хурлуудын завсар хугацаанд гишүүдтэйгээ хамтарч ажиллана. Зайлшгүй шаардлагатай үед шуурхай арга хэмжээ авах нөхцлийг бүрдүүлэхийн тулд чухал ач холбогдолтой асуудлуудад Даргын зүгээс оновчтой арга замаар зөвлөгөө өгч болох журмыг Удирдах зөвлөл хэлэлцэн батлах ёстой.

5. Удирдах зөвлөлд зориулсан зохицуулалтууд

Нарийн бичгийн дарга нарын газар нь Удирдах зөвлөлийн хурал болон Бага хурлыг хүлээн авагч орны засгийн газрууд болон зохих бусад байгууллагуудтай хамтран зохион байгуулна. Удирдах зөвлөл нь жилийн 120.000 ам. долларын төсөвтэй байна. Энэ нь Удирдах зөвлөл жилд дээд тал нь дөрвөн хурал хийхэд хангалттай байх бөгөөд хоёроос гурван хурлыг биечлэн хийж, бусад тохиолдолд видео эсвэл телеконференцээр дамжуулан хуралдахаар Удирдах зөвлөл шийдэж болно. Удирдах зөвлөлөөс зөвлөлийн дийлэнх гишүүдэд тохиромжтой газар хурал хийх шийдвэр гаргана.

Түүнчлэн Удирдах зөвлөлөөс авч хэрэгжүүлэх шийдвэр гаргах үйл явцад анхаарал хандуулах хэрэгтэй. ОҮИТБС-ын олон оролцогч талт чанарыг тусгах үүднээс Удирдах зөвлөл ямагт зөвшилцлийн зарчим арга барилаар ажиллахыг эрмэлзэх ёстай. Гэхдээ санал хураалт явуулах шаардлагатай үе гарч болно. Санал хураалтын журмыг Удирдах зөвлөлийн анхны хурлаар бүх гишүүдээр хэлэлцэн шийдвэрлэх ёстай, үүндээ цөөнхийн байр суурийг хүндэтгэн хамгаалах шаардлагыг үр ашигтай шийдвэр гаргах үйл явцтай хослуулна. Жишээлбэл, Удирдах зөвлөлийн гишүүдийн дор хаяж дөрөвний нэг нь хүсэлт гаргасан бодлогын ямар нэг асуудлыг “бодлогын гол асуудал” гэж авч үзэх санал гараад байна. Иймэрхүү чухал асуудлыг зөвхөн Удирдах зөвлөлийн гишүүдийн зөвхөн 2/3-ийн, олонхийн саналаар шийдвэрлэх, ингэхдээ ОҮИТБС-ын Бага хурлаар хэлэлцүүлж баттуулна.

Удирдах зөвлөл бүхий л үйл ажиллагаагаа бүрэн ил тод байдлаар явуулах шаардлагатай. Энд хэлэлцэх асуудал, гаргах баримт бичиг, протоколуудыг ил тод болгох явдал орно. Удирдах зөвлөлийн үйл ажиллагаа англи хэл дээр явагдана. Хэрвээ Удирдах зөвлөлөөс шаардсан, хэлэлцэж тохирсон тохиолдолд нэмэлт хэлүүдээр орчуулж болно.

Хавсралт Г: ОУЗБ-ийн хуралдаан бүрт оролцогчид

Олон Улсын Зөвлөлдөх Бүлгийн анхдугаар хуралдаан

ОҮИТБС-ын ОУЗБ-ийн нээлтийн хурал 2005 оны 8 дугаар сарын 26-ны Баасан гарагт Их Британий Лондон хотын Ланкастер Хауст болов.

Хурал даргалагч:

Пийтр Ейген,

ОУЗБ-ийн дараахь гишүүд оролцов:

Сабит Багиров, Азербайжаны Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлыг дээшлүүлэх эвслийн Зохицуулагч

Грэхэм Бакстер, БиПи компаний Корпорацийн хариуцлагын Дэд ерөнхийлөгч

Едвард Бикэм, Англо Американ компаний Гадаад хэргийн Гүйцэтгэх дэд ерөнхийлөгч

Оби Эзикуесли, Нигери улсын Хатуу эрдэс баялгийн хөгжлийн сайд

Ларри Грийнвүүд, АНУ-ын төрийн Департаментийн Орлогч нарийн бичгийн дарга

Гэвин Хэйман, Глобал Витнесс байгууллагын Кампанит ажлын удирдагч

Патрик Лэфон, Камерун улс дахь Төв Африкийн хамба нарын бага хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга

Сэм Лэйдлуу, Чеврон компаний Гүйцэтгэх дэд ерөнхийлөгч

Кэрин Лиссакерс, Нээлттэй нийгмийн хүрээлэнд Жорж Соросян ахлах зөвлөх

Карина Литвак, Эф&Си Ассет Менежмент пүүсийн Захирал, Засаглал ба нийгмийн хариуцлагатай хөрөнгө оруулалт хариуцсан Тэргүүн

Лейв Люнде, Норвег улсын Гадаад хэргийн яамны Олон улсын хөгжлийн асуудал хариуцсан Төрийн нарийн бичгийн дарга

Самир Шарифов, Азербайжан улсын Газрын тосны төрийн сангийн Гүйцэтгэх захирал

Янник Тэганд, Франц улсын Гадаад хэргийн сайд

Нарийн бичгийн дарга нарын газраас оролцогчид

Чарлес МакФерсон, Дэлхийн Банкны Газрын тос, байгалийн хий, уул уурхай, химийн бодисийн газрын Ахлах зөвлөх

Бен Меллор, Олон Улсын Хөгжлийн Газрын дэргэдэх ОҮИТБС-ын Нарийн бичгийн дарга нарын газрын Тэргүүн

Антон Он де Беке, ОУВС-гийн Бодлого боловсруулалт, хяналтын газрын Ахлах эдийн засагч

Хоёрдугаар хуралдаан

ОҮИТБС-ын ОУЗБ-ийн хоёрдугаар хуралдаан 2005 оны 10 дугаар сарын 21-ний Баасан гарагт АНУ-ын Вашингтон хотын Дэлхийн Банкны төв байранд хуралдав.

Хурал даргалагч:

Пийтр Ейген,

ОУЗБ-ийн дараахь гишүүд оролцов:

Грэхэм Бакстер, БиПи компани

Едвард Бикэм, Англо Американ компани

Стюарт Бруукс, Чеврон Тексако компани

Раул Кампос, Петробрас компани

Тормод Ендресен, Норвегийн Засгийн газар

Оби Эзикуесли, Нигерийн Засгийн газар

Ларри Грийнвүүд, АНУ-ын Засгийн газар

Гэвин Хэйман, Глобал Витнесс байгууллага

Делфин Лида, Францын Засгийн газар

Эцэг Патрик Лэфон, Камеруны Төв Африкийн хамба нарын бага хурал

Кэрин Лиссакерс, Нээлттэй нийгмийн хүрээлэн

Карина Литвак, Эф&Си Ассет Менежмент пүүс

Самир Шарифов, Азербайжаны Засгийн газар

Хүлцэл өчсөн:

Перу улсын Засгийн газраас Карлос Гарайкочеа оролцож чадаагүй

Нарийн бичгийн дарга нарын газраас оролцогчид

Мартин Фетерстон, ОУВС

Чарлес МакФерсон, Дэлхийн Банк

Бен Меллор, Их Британий Засгийн газар

Гуравдугаар хуралдаан

ОҮИТБС-ын ОУЗБ-ийн гуравдугаар хуралдаан 2006 оны 2 дугаар сарын 16-ны Пүрэв гарагт Нигери улсын Абуза хотын Транскорп Хилтон Зочид буудалд хуралдав.

Хурал даргалагч:

Пийтр Ейген,

ОУЗБ-ийн дараахь гишүүд оролцов:

Самир Ауад, Петробрас компани

Сабит Багиров, Азербайжаны ТББ-уудын эвсэл

Грэхэм Бакстер, БиПи компани

Едварт Бикэм, Англо Американ компани

Пол Боницелли, АНУ-ын Засгийн газар

Стюарт Бруукс, Чеврон компани

Тормод Ендресен, Норвегийн Засгийн газар

Оби Эзикуесли, Нигерийн Засгийн газар

Карлос Гарайкочеа, Перугийн Засгийн газар

Гэвин Хэйман, Глобал Витнесс байгууллага

Кэрин Лиссакерс, Нээлттэй нийгмийн хүрээлэн

Карина Литвак, Эф&Си Ассет Менежмент пүүс

Самир Шарифов, Азербайжаны Засгийн газар

Янник Тэганд, Францын Засгийн газар

Нарийн бичгийн дарга нарын газраас оролцогчид

Чарлес МакФерсон, Дэлхийн Банк

Бен Меллор, Их Британий Засгийн газар

Жесус Сийде, ОУВС

Хүлцэл өчсөн:

Патрик Лэфон, Католик хамба нарын бага хурал

Дөрөвдүгээр хуралдаан

ОҮИТБС-ын ОУЗБ-ийн дөрөвдүгээр хуралдаан 2006 оны 4 дүгээр сарын 5-ны Лхагва гарагт Азербайжан улсын Баку хотын Парк Хяйт Зочид буудалд болов.

Хурал даргалагч:

Пийтр Ейген,

ОУЗБ-ийн дараахь гишүүд оролцов:

Сабит Багиров, Азербайжаны ТББ-уудын эвсэл
Грэхэм Бакстер, БиПи компани
Едвард Бикэм, Англо Американ компани
Стюарт Бруукс, Чеврон компани
Тормод Ендресен, Норвегийн Засгийн газар
Гэвин Хэйман, Глобал Витнесс байгууллага
Стефен Краснер, АНУ-ын Засгийн газар
Патрик Лэфон, Католик хамба нарын бага хурал, Баруун Африк
Кэрин Лиссакерс, Нээлттэй нийгмийн хүрээлэн
Карина Литвак, Эф&Си Ассет Менежмент пүүс
Брайт Окогу, Нигерийн Засгийн газар
Терезина Серпа, Петробрас компани
Самир Шарифов, Азербайжаны Засгийн газар
Жан Пьер Видон, Францын Засгийн газар

Нарийн бичгийн дарга нарын газраас оролцогчид

Чарлес МакФерсон, Дэлхийн Банк
Бен Меллор, Их Британий Засгийн газар
Антон Он де Беке, ОУВС

Хүлцэл өчсөн:

Карлос Гарайкочеа, Перугийн Засгийн газар

Тавдугаар хуралдаан

ОҮИТБС-ын ОУЗБ-ийн тавдугаар хуралдаан 2006 оны 6 дугаар сарын 20-ны Мягмар гарагт Их Британий Лондон хотын Ланкастер Хауст болов.

Хурал даргалагч:

Пийтр Ейген,

ОУЗБ-ийн дараахь гишүүд оролцов:

Сабит Багиров, Азербайжаны ТББ-уудын эвсэл

Грэхэм Бакстер, БиПи компани

Едвард Бикэм, Англо Американ компани

Стюарт Бруукс, Чеврон компани

Жоакюим Диб Кохен, Петробрас компани

Тормод Ендресен, Норвегийн Засгийн газар

Оби Эзикуесли, Нигерийн Засгийн газар

Карлос Гарайкочеа, Перугийн Засгийн газар

Гэвин Хэйман, Глобал Витнесс байгууллага

Стефен Краснер, АНУ-ын Засгийн газар

Патрик Лэфон, Католик хамба нарын бага хурал

Кэрин Лиссакерс, Нээлттэй нийгмийн хүрээлэн

Карина Литвак, Эф&Си Ассет Менежмент пүүс

Шахмар Мовсумов, Азербайжаны Засгийн газар

Жан Пьер Видон, Францын Засгийн газар

Нарийн бичгийн дарга нарын газраас оролцогчид

Чарлес МакФерсон, Дэлхийн Банк

Бен Меллор, Их Британий Засгийн газар

